



Агуулга

Тайланг гүйцэтгэсэн:

Үндэсний аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын газар

Газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор
Л.Одгэрэл

Аудитын менежер
Л.Эрдэнэчулуун

Аудитын багийн ахлах
аудитор
Д.Гандолгор

Аудиторууд:
Б.Булган
Э.Уянга
М.Гүнжмаа
Б.Лхагвацэрэн

2018 оны 10 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар
261675, 261805, 263755
дугаарын утсаар харилцана
уу.

Уг тайланг YAG-ын цахим
хуудаснаас үзнэ үү.
[/www.audit.mn/](http://www.audit.mn/)

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр

Улаанбаатар хот, Монгол
улс

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгт, дүрслэл, зургийн товьёг.....	3
Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа.....	5
БҮЛЭГ 1. АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧИГ ҮҮРГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ УЯЛДАА ХОЛБООГҮЙ БАЙНА.....	7
Ерөнхий мэдээлэл.....	7
Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой гарсан эрх зүйн шийдвэрүүд нь хоорондоо уялдаагүйгээс энэхүү харилцааг нэгдмэл удирдлагаар бүрэн зохицуулж чадаагүй байна.....	8
Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг хангах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт тогтворгүй, үйл ажиллагаанд тавих хяналт орхигдсон байна.....	9
Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа зарим төрийн байгууллагуудын чиг үүрэг давхацсанаас зарим үйл ажиллагаа орхигдсон байна.....	12
2017 оноос өмнө агаарын бохирдлыг бууруулах талаар бие даасан үндэсний хөтөлбөр батлагдаагүй байна.....	13
БҮЛЭГ 2. АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗОРИЛГОО БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ ЧАДААГҮЙ БАЙНА.....	16
Ерөнхий мэдээлэл.....	16
Агаарын бохирдлыг бууруулах ажлын төлөвлөлтийн талаар.....	17
Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар.....	20
Сайжруулсан зуухний нийлүүлэлт, ашиглалтын талаар.....	20
Сайжруулсан түлшний нийлүүлэлтийн талаар.....	23
Гэрийн дулаалгын талаар.....	25
Цахилгааны үнийн хөнгөлөлтийн талаар.....	26
Нам даралтын зуух болон эрчим хүчний цахилгаан станцуудад авсан арга хэмжээний талаар.....	27
Автотээврийн хэрэгслийн утааны ялгаруулалтыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар.....	28
Гэр хорооллын айл өрхийг орон сууцжуулах хөтөлбөрийн талаар.....	29
Агаарын бохирдлыг бууруулах талаар хийсэн судалгааны ажлын талаар.....	30
ЦАС-ийн үйл ажиллагааны талаар.....	31
БҮЛЭГ 3. АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ҮР ДҮН, ТҮҮНД ТАВЬСАН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	32
Ерөнхий мэдээлэл.....	32
Агаарын бохирдлын хамрах хүрээ нэмэгдэж агаар дах хорт бодисын агууламж стандартад заасан түвшнээс хэтэрсэн хэвээр байна.....	33
Агаарын бохирдлын төлбөр ногдуулах хэмжээ өнөөгийн нөхцөл байдалтай уялдаагүй байна.....	38
Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга, хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт дутагдсанаас зөрчил гарч хууль, хяналтын байгууллагаар шалгагдсан байна.....	39
Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй ажилласан байна.....	40
Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаас хийсэн хяналт шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.....	42
Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийсэн ажлын үр дүн, үр нөлөөг нээлттэй ил тод тайлагнаагүй байна.....	43
ДҮГНЭЛТ:.....	44
ЗӨВЛӨМЖ:.....	46
Холбогдох байгууллагын санал.....	49
Ирүүлсэн саналд өгөх тайлбар.....	57
Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал.....	58
Хавсралт.....	589


Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АББҮХ	Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо
АЕГ	Архивын ерөнхий газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
АХБ	Азийн хөгжлийн банк
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНХАУ	Бүгд найрамдах Хятад Ард улс
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОНХАЖС	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БОХХАА	Байгаль орчин, хүнс, хөдөө, аж ахуй
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ДБ	Дэлхийн банк
ДТҮЭХ	Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕХОБ	Европын хөрөнгө оруулалтын банк
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГ	Засгийн газар
ЗГТСТХ	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
ЗГТХ	Засгийн газрын тухай хууль
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗЦА	Замын цагдаагийн алба
ЗТБХБС	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
ЗТБХБЯ	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТЯ	Зам тээврийн яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
мкг	Микрограмм
МУ	Монгол Улс
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МСС	Мянганы сорилтын сан
НАББГ	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар
НАББҮХ	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо
НАЧА	Нийслэлийн Агаарын чанарын алба
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НИТХТ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НЗД	Нийслэлийн Засаг дарга
ОББҮХ	Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо



ОХУ	Оросын Холбооны Улс
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгино хайрхан дүүрэг
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨҮҮГ	Төрийн өмчит улсын үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
УИХ	Улсын Их Хурал
УУС	Уул уурхайн сайд
УУЯ	Уул уурхайн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХУД	Хан-Уул дүүрэг
ЦАС	Цэвэр агаарын сан
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЦҮОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХГ	Эрчим хүчний газар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам
PM	Particular matter /Тоосонцор/

Хүснэгт, дүрслэл, зургийн товьёг

Хүснэгт 1	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зарцуулсан хөрөнгийн судалгаа	16
Хүснэгт 2	Төсөл, хөтөлбөрөөр нийлүүлсэн сайжруулсан зуух (тоо)	20
Хүснэгт 3	МСС-ийн Цэвэр агаар төсөл, ЦАС-ийн санхүүжилт (төгрөг)	20
Хүснэгт 4	ДБ-ны Улаанбаатар-Цэвэр агаар төсөл, ЦАС-ийн санхүүжилт (төгрөг)	20
Хүснэгт 5	Түлш үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн байдал (тонн)	23
Хүснэгт 6	Гэрийн дулаалгын нийлүүлсэн тоо хэмжээ, ЦАС-аас олгосон санхүүжилт	25
Хүснэгт 7	Гэрийн дулаалгын иж бүрдлийн үнэ	26
Хүснэгт 8	Нийслэлийн гэр хорооллын айл өрхөд үзүүлсэн цахилгааны үнийн хөнгөлөлт	26
Хүснэгт 9	Төвлөрсөн дулаан хангамжид холбосон нам даралтын зуухны судалгаа	27
Хүснэгт 10	Авто тээврийн салбарт хэрэгжүүлсэн арга хэмжээ	28
Хүснэгт 11	МУ-ын болон олон улсын нарийн ширхэглэгт тоосонцрын стандарт	34
Дүрслэл 1	Нарийн ширхэглэгт тоосонцрын өсөлт, бууралтын хэмжээ	14
Дүрслэл 2	Дотоод, гадаад эх үүсвэрээс санхүүжүүлсэн дүн	17
Дүрслэл 3	АББ чиглэлээрх арга хэмжээний ангилал /хувь/	22
Дүрслэл 4	Сайжруулсан болон энгийн зуухны судалгаа	21
Дүрслэл 5	Байшин болон гэр хорооллын өрхийн тоо	29
Дүрслэл 6	ЦАС-ийн үйл ажиллагааны зардал /сая.төгрөг/	31



Дүрслэл 7	Амьсгалын замын өвчлөл	32
Дүрслэл 8	Зүрх судасны өвчлөл	32
Дүрслэл 9	Агаар дах хорт бодисын агууламж ба зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт	34
Дүрслэл 10	Агаар дах хорт агууламж ба авто тээврийн хэрэгслийн утааны ялгаруулалтыг бууруулах чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт	35
Дүрслэл 11	Агаар дах тоосонцрын хэмжээ ба сайжруулсан зуух, түлш, дулаалгад зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт	35
Дүрслэл 12	Авто тээврийн хэрэгслийн тоо	36
Дүрслэл 13	Гэр хорооллын айл өрхийн тоо	37
Дүрслэл 14	Нийслэл хотод шилжин ирэгсдийн тоо	37
Дүрслэл 15	Агаар бохирдуулагч бодисын стандартаас хэтэрсэн хэмжээ	38
Дүрслэл 16	Аймгуудын агаар бохирдуулагч бодисын стандартаас хэтэрсэн хэмжээ	38
Дүрслэл 17	Автомашин тоо ба бохирдлын төлбөрийн харьцаа	39
Зураг 1	Зохион байгуулалтын бүтцийн нэгдсэн зураглал	11
Зураг 2	Хагас коксжсон түлш үйлдвэрлэх болон шингэн түлшний үйлдвэрийн ерөнхий байдал	24
Зураг 3	Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэр	32
Зураг 4	Мишээл экспо төвийн гадна байрлах зөөврийн УБ-01 станц	33
Зураг 5	АББ чиглэлээр ажил хариуцсан байгууллагуудын хяналтын тогтолцоо	41



Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2018 оны 02 дугаар тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторов 2018 оны А/40 дүгээр тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ЯАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

ЦАС болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр санхүүжүүлсэн ажлуудын хэрэгжилтийн байдлыг шалган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа, эрх зүйн орчин уялдаатай эсэх;
- Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг зохистой төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх;
- Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа үр нөлөөтэй байсан эсэх;

Аудитад ЦАС болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ээс түүвэрлэн авч тэдгээрийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой архивын баримт материалд тулгуурлан зарим төрийн байгууллага, бүтцийн нэгжүүдийн агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой явуулсан үйл ажиллагааны үр дүнг хамрууллаа.

Аудитад АЕГ-т хадгалагдаж байсан ЦАС-гийн 2013-2015 оны үйл ажиллагааны болон хэрэгжүүлсэн төслийн баримт, материал бүрэн бус, гүйцэтгэлийн мэдээллийн чанарын шаардлага хангахгүй, НЗДТГ-аас нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 356.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэр бүхий 8 ТАХ-ний баримт материал ирүүлээгүй, мөн УБЗАА-ны 2008-2016 оны агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийсэн ажлын баримт материал болон МСС-ийн “Цэвэр агаар төсөл” татан буух үед ажил хариуцаж авсан төрийн байгууллагаас холбогдох баримт материалыг ирүүлээгүй зэргээс шалтгаалан зарим асуудлыг хязгаарласан болно.

АТГ болон Цагдаагийн байгууллагаас ЦАС-ийн үйл ажиллагааг 2013-2014 онд хянаж, шийдвэрлэсэн 6.0 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө, санхүүжилттэй холбоотой 18 ТАХ-ний баримт материал аудитад хамрагдаагүй болно.

ЯАГ-аас агаарын бохирдолтой холбоотой 2010, 2014 онд хийсэн гүйцэтгэлийн, нийцлийн аудит болон ЦАС-ийн 2012, 2014, 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг аудитаар тулган баталгаажууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу холбогдох байгууллагуудаас ТАХ-ний баримт материалыг аудитад хамруулахаар түүвэрлэн авч түүнд судалгаа, шинжилгээ хийн гүйцэтгэлийн тоон мэдээллээр үр дүнг харьцуулан тулган баталгаажуулалт хийж, шалгуур үзүүлэлттэй харьцуулан нягтлан шалгаж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр батлагдсан хууль, эрхийн актыг судлах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, нэмэлт мэдээлэл, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан баримт, мэдээлэл, олон улсын байгууллагуудын дүгнэлт тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.



Аудитын шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын гол шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Агаарын тухай хууль
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль,
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль,
- ЗГТСТХ-ийн 5.4.29, 6.4.15, 12¹, 12²
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль /хүчингүй болсон/-ийн 13.2
- МУ-ын ЗГ-ын тухай хуулийн 20.5.1
- Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.11, 31, 32.1
- Зөрчлийн тухай хуулийн 7.4, 7.5
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 11.1, 14.1, 14.3, 15.1.1, 15.8, 15.2.1, 15.2.2, 16.1.1, 16.1.4, 16.1.5, 16.2.1, 16.2.2, 16.2.3, 16.2.4, 17.1.1, 17.2.1, 17.2.4, 18.2.1, 18.2.2, 18.2.4, 20.1.1, 35.1.7, 35.7, 57.1
- УИХ-ын 2010 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай” хөтөлбөр
- НАББҮХ-ны тогтоол,
- АББҮХ-ны тогтоол,
- БОАЖС-ын тушаал,
- НИТХТ-ийн тогтоол,
- НЗД-ын захирамж,
- Холбогдох бусад хууль, журам, тогтоол, шийдвэр.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг гүйцэтгэх үе шатны болон чанарын хяналтын зохих журмын дагуу ГАГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Одгэрэл удирдан зохион байгуулж, чанарын хяналтыг аудитын менежер Л.Эрдэнэчулуун хэрэгжүүлж, аудитын ажлыг ахлах аудитор Д.Гандолгор, аудитор Б.Булган, Э.Уянга, М.Гүнжмаа, Б.Лхагвацэрэн нар 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аудитад тулгарсан бэрхшээлтэй асуудлууд

ЦАС татан буугдсантай холбоотойгоор АББҮХ-ны тогтоол болон БОАЖС-ын тушаал зэрэг эрх зүйн шийдвэр болон архивын баримт материал бүрэн бус, тус сангаас зарцуулсан хөрөнгө, ТАХ-ний үр дүн, үр нөлөөний талаар хяналт хийж, үр дүнг үнэлж байсан эсэх талаар баримт материал олдоогүйгээс ЦАС-ийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэхэд бэрхшээлтэй байлаа.

Салбар хариуцсан яам, агентлаг, газрын бүтэц, зохион байгуулалт болон тухайн үед ажил үүргийг хариуцаж байсан удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнууд өөрчлөгдсөн, НАББГ-аас Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэрийн судалгааг зөвхөн 2015 оны байдлаар өгсөн, өмнөх жилүүдийн судалгааг гаргаж ирүүлээгүй зэрэг нь аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэхэд хүндрэлтэй байсан болно.

YAG-аас албан ёсоор шаардсан болон аудитын явцад шалгагдагч болон холбоотой талуудаас хүссэн гүйцэтгэлийн зарим мэдээлэл, тайлбар нь иж бүрэн бус, дүн шинжилгээ хийх боломжгүй, аудитын стандартын дагуу баримтат нотолгоо болгох үндэслэл, баталгаа сул, гүйцэтгэлийн мэдээллийн чанар хангалтгүй байв.



БҮЛЭГ 1. АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧИГ ҮҮРГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ УЯЛДАА ХОЛБООГҮЙ БАЙНА

Ерөнхий мэдээлэл

МУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан “МУ-ын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасныг ханган баталгаажуулах зорилгоор УИХ-аас 1995 онд “Агаарын тухай хууль”-ийг баталж 2010 оны 6 дугаар сард, 2012 оны 5 дугаар сард шинэчлэн баталсан байна.

2012 оны Агаарын тухай хуульд 2013 оны 12 дугаар сар, 2015 оны 1 ба 11 дүгээр сар, 2017 оны 5 дугаар сар, 2018 оны 1 дүгээр сард нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Дээрх хуулиудад агаарыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудыг дараах байдлаар зааж өгсөн байна. Үүнд:

- 1995 онд Байгаль орчны асуудал эрхэлсэн болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага¹;
- 2010 онд ЗГ, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нутгийн өөрөө удирдах болон Нутгийн захиргааны байгууллага, ААНБ, иргэн;
- 2012 онд УИХ, МУ-ын Ерөнхийлөгч, ЗГ, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нутгийн өөрөө удирдах болон Нутгийн захиргааны байгууллага, ААНБ, иргэн;

Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны хүрээнд 1992-2016 онд УИХ-аас 26, ҮАБЗ-өөс 2 эрх зүйн шийдвэр, ЗГ-аас 24 тогтоол гаргасан байна.

УИХ-аас 2011 оны 2 дугаар сард “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль”² болон УИХ-ын 11 дүгээр тогтоолоор нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 15 арга хэмжээг баталсан байна.

Дээрх хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2011 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 43 дугаар зарлигаар “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо” /цаашид “НАББҮХ” гэх/-г ЕТГ-ын дэргэд байгуулсан байна.

Агаарын бохирдол зөвхөн нийслэлийн хүрээнд яригдах асуудал биш болсон учраас Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийг 2012 оны 5 дугаар сард хүчингүй болгож, Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан байна.

Уг хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2012 оны 171 дүгээр зарлигаар дээрх НАББҮХ-г татан буулгаж ЕТГ-ын дэргэд АББҮХ-г байгуулан түүний ажиллах журмыг баталсан байна.

Бодит байдлаас шалтгаалан зөвхөн агаарын бохирдол бус орчны бохирдлын асуудал гарч ирсэнтэй холбоотойгоор ҮАБЗ-ийн 2017 оны 03-03 дугаар зөвлөмжийн 2.3-т заасныг үндэслэн Ерөнхий сайд /Ж.Эрдэнэбат/-ын 2017 оны 51 дүгээр захирамжаар Ерөнхий сайдын дэргэд ОББҮХ байгуулагдсан байна.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2011-2013 онд НАББҮХ, 2013-2014 онд АББҮХ, 2014-2015 онд БОНХАЖС, 2015-2017 АББҮХ, 2017 оноос ОББҮХ үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Манай улсад, тэр дундаа нийслэл хотод сүүлийн жилүүдэд агаарын бохирдолтой зэрэгцэн хөрс, усны бохирдол маш их хэмжээгээр ихэссэнтэй холбоотойгоор ҮАБЗ-өөс агаар, ус, хөрсний бохирдол гамшгийн хэмжээнд хүрсэн гэж үзэж, холбогдох байгууллагуудад өгсөн 2017 оны 03/03 дугаар зөвлөмжийг үндэслэн Ерөнхий сайд /Ж.Эрдэнэбат/-ын 2017 оны 51 дүгээр захирамжаар АББҮХ-г ОББҮХ болгон шинэчлэн зохион байгуулсан байна.

Мөн 2011 онд УИХ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан УИХ-ын БОХХАА-н Байнгын хорооны дэргэд агаарын бохирдлыг бууруулах асуудал хариуцсан дэд хороог байгуулжээ.

¹ ЭМЯ, БОЯ

² УИХ-аас “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль”-ийг 2012 оны 5 дугаар сард хүчингүй болгосон.



ЗГ-ын /Ерөнхий сайд С.Батболд/ 2010 оны 273 дугаар тогтоолоор ЦАС байгуулж, удирдах зөвлөлийн ажиллах журам болон бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд сангийн дүрэм, бүтэц зохион байгуулалт, стратегийг ЦАС-ийн удирдах зөвлөлийн саналыг үндэслэн БОАЖС /Л.Гансүх/-ын 2011 оны А-200 дугаар тушаалаар баталсан байна.

2015 оны 11 дүгээр сард ЗГТСТХ-д өөрчлөлт орсонтой холбоотойгоор ЗГ-ын 2015 оны 501 дүгээр тогтоолоор ЦАС-г татан буулгаж, хэрэгжүүлж байсан чиг үүргийг БОАЖЯ-нд шилжүүлсэн байна.

Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой гарсан эрх зүйн шийдвэрүүд нь хоорондоо уялдаагүйгээс энэхүү харилцааг нэгдмэл удирдлагаар бүрэн зохицуулж чадаагүй байна

1.1 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хоорондоо зөрчилдсөн олон эрх зүйн баримт бичиг гарсан нь үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлжээ. Тухайлбал,

- ЗГ-аас 2012-2013 онд “Нүүрс хөтөлбөр”-ийн хүрээнд түүхий нүүрсний хэрэглээг дэмжиж нэг тонн түүхий нүүрсийг 80.0 мянган төгрөгөөр борлуулах ажлыг зохион байгуулсан нь УИХ-аас 2012 онд шинэчлэн найруулж баталсан Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5-д *“агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаахыг хориглох”* гэсэн заалттай зөрчилдөж байна;
- БОАЖС /Л.Гансүх/-ын 2011 оны А-200 дугаар тушаалаар баталсан “ЦАС-ийн стратеги, бүтэц зохион байгуулалтын хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн 2.3.3-т *“ЦАС нь Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах”* гэж заасан нь 2010 оны Агаарын бохирдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд агаарын бохирдлын төлбөрийг татварын алба хариуцна гэж заасантай нийцэхгүй байна.
- АББҮХ-ны 2014 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 2-т *“Сайжруулсан түлшийг хадгалах, тээвэрлэх, борлуулах аж ахуйн нэгжүүдийг холбогдох хуулийн хүрээнд сонгон шалгаруулж, ээрээ байгуулан ажиллахыг Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга /Ж.Эрдэнэбат/-д ...даалгасугай”* гэсэн заалт нь “АББҮХ-ны ажиллах журам”-ын 3.1 дэх АББҮХ-ны бүрэн эрхэд тусгагдаагүй байна,
- АББҮХ-ны дарга, гишүүдэд ЗГ болон ЕТГ-ын ажилтнууд давхар ажиллаж байснаас үйл ажиллагаа нь холилдох асуудлууд гарч байсан байна. Тухайлбал, ЕТГ-ын дарга /Д.Баттулга/ агаарын бохирдолтой холбоотой асуудлаар БОАЖС /Л.Гансүх/-д явуулсан 2011 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн тг/593 дугаар албан бичгийг НАББҮХ-ны хаягаар бус ЕТГ-ын хаягаар хаягласан нь МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2009 оны 27 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрэм”-ийн 7-д заасан Тамгын газрын даргын үүрэгтэй зөрчилдөж байна.

1.2 Мөн БОАЖС /Д.Оюунхорол/, НЗД /С.Батболд/-ын 2017 оны А/04-А/19 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын 2.3.3.1 ба 2.4.3.1-т *“агаарын чанарыг сайжруулах 3, 4 дүгээр бүсэд түүхий нүүрс түлүүлэхгүй байх”* гэж зөвхөн 2 бүсэд хориглосноор заасан бол Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д *“Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйлсийг шатаахгүй байх”* гэж бүх бүсэд хориглосон заалттай зөрчилдөж байна.

1.3 Агаарын тухай хууль болон журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэж зөвхөн нэг удаагийн торгууль ногдуулахаар байгаа нь зөрчил дахин давтагдан гарах явдлыг таслан зогсоох эрх зүйн орчин бүрэн зохицуулагдаагүйтэй холбоотой байна.

1.4 2010 оны Агаарын бохирдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.3-т *“татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөрийн нэгдсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 15-ны дотор гаргаж агаарын чанарын мэргэжлийн албанд ирүүлнэ”* гэсэн заалт хэрэгжихгүй байгаа ба ТЕГ төлбөрийн орлогын мэдээг СЯ-нд хүргүүлж байгаа нь эрх зүйн баримт бичигт тусгагдаагүй байна.

1.5 НАББҮХ нь ЦАС-ийн удирдах зөвлөлийн баталсан жилийн ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, зохицуулж байсан нь хууль, эрх зүйн зарим заалттай уялдахгүй байна. Тухайлбал,



- МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2011 оны 43 дугаар зарлигаар баталсан НАББҮХ-ны ажиллах журмын 3.1.5-д АББҮХ-ны эрх, үүрэгт *“Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд шаардагдах хөрөнгийн тооцоо, эх үүсвэрийн асуудлыг уялдуулан зохицуулж, санхүүжилтэд хяналт тавих”* гэсэн заалтын дагуу тухайн онд хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг баталдаг боловч “Цэвэр агаар сангийн дүрэм”-ийн 2.8.3-т *“Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн төсвийг Удирдах зөвлөл батлах”*, “Цэвэр агаар санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах” журам”-ын 2.1.1-т *“Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг удирдах зөвлөлийн дарга батлах...”* гэж заасны дагуу ЦАС-ийн ТАХ бүрээр хэрэгжүүлэх хөрөнгийг баталсан төлөвлөгөөг өөрчилж, өөрийн эрх, үүргийг хэтрүүлсэн байна. Тухайлбал, НАББҮХ /дарга Д.Баттулга/-ны 2011 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 11/08 дугаар тогтоолоор ЦАС-ийн 2011 оны батлагдсан төлөвлөгөөнд буюу ТАХ-ний нийт төсвийн 30.0 тэрбум төгрөгийн дүнд багтаан 9.3 тэрбум төгрөгөөр ТАХ-ний дүнг нэмж, хасах замаар хооронд нь зохицуулалт хийгдсэн байна.
- АББҮХ /дарга П.Цагаан/-ны 2013 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 13/26 дугаар тогтоолоор *“...Үндэсний хорооны ажлын албаны хэрэгцээний автомашиныг 48.1 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөгөөнд тусгасан”* нь ЦАС-ийн дүрмийн 2.8.3-д *“Удирдах зөвлөл нь сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн төсвийг батлах”*, 2.8.4-т *“Сангийн үйл ажиллагаа, зарцуулалтад хяналт тавих...”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг хангах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт тогтворгүй, үйл ажиллагаанд тавих хяналт орхигдсон байна

1.6 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр батлан гаргасан хууль тогтоомжийн хүрээнд бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий Үндэсний хороог Ерөнхийлөгч болон Ерөнхий сайд, мөн салбарын сайдын дэргэд ажиллуулах байдлаар олон удаа өөрчилж байжээ. Тухайлбал,

- “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль”-ийн хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх харилцааг зохицуулахтай холбогдуулан МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2011 оны 43 дугаар зарлигаар НАББҮХ-г ЕТГ-ын дэргэд ажиллуулахаар,
- Дээрх хуулийг 2012 оны 5 дугаар сард хүчингүй болгон, Агаарын тухай хуулийг баталснаар МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2012 оны 171 дүгээр зарлигаар АББҮХ-г ЕТГ-ын дэргэд ажиллуулахаар,
- Агаарын тухай хуульд 2013 оны 12 дугаар сард орсон өөрчлөлтийн дагуу АББҮХ-г Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар,
- Ерөнхий сайд /Н.Алтанхуяг/-ын 2014 оны 151 дүгээр захирамжаар АББҮХ-г татан буулгаж, чиг үүргийг нь БОНХАЖС-ын эрхлэх асуудлын хүрээнд хамруулахаар,
- Ерөнхий сайд /Ч.Сайханбилэг/-ын 2015 оны 247 дугаар захирамжаар АББҮХ-г 2015 онд дахин Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар,
- Ерөнхий сайд /Ж.Эрдэнэбат/-ын 2017 оны 51 дүгээр захирамжаар дээрх хороог “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо” болгон өөрчлөн Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар тус тус шийдвэрлэж ирсэн байна.

1.7 МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2011 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 43 дугаар зарлигаар байгуулагдсан НАББҮХ-г ЕТГ-ын дарга удирдахаар зохицуулагдсан нь “УБ хотын агаарын бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” ҮАБЗ-ийн 2011 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 2/03 дугаар зөвлөмжийн 1.2-ын *“НАББ тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих Үндэсний хороог УИХ-ын дэд даргаар ахлуулан байгуулж ажиллах”* гэж заасантай уялдсан шийдвэр болж чадаагүй байна.

1.8 2011 онд байгуулагдсан НАББҮХ-г ЕТГ-ын дарга удирдаж, бүрэлдэхүүнд нь УИХ-ын гишүүн болон Ерөнхийлөгчийн зөвлөхүүд, ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга, НЗД, зарим яамдын³ ТНБД, агентлагийн дарга, олон нийтийн байгууллагын төлөөллийг оролцуулан нийт 19 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж ажиллуулсан байна.

³ СЯ, БОАЖЯ, ЗТБХБЯ, ЗБЭХЯ



1.9 Харин МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2012 оны 171 дүгээр зарлигаар байгуулагдсан АББҮХ нь 22 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан байна.

1.10 АББҮХ нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлээрх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, бодлого, эрх зүйн хүрээний зорилтын хэрэгжилтийг хангуулж ажиллахдаа тогтвортой зохион байгуулалтын бүтцээр ажиллаж ирээгүй байна. Тухайлбал,

- МУ-ын Ерөнхийлөгч /Ц.Элбэгдорж/-ийн 2012 оны 171 дүгээр зарлигаар байгуулагдсан АББҮХ-г ЕТГ-ын дарга удирдах, бүрэлдэхүүнд нь УИХ-ын гишүүн болон Ерөнхийлөгчийн зөвлөхүүд, ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга, зарим яамдын⁴ ТНБД, ЗГХЭГ-ын дэд дарга, НИТХ-ын дарга, НЗД-ын орлогч, агентлагийн дарга, ШУА-ийн ерөнхийлөгч, олон нийтийн байгууллагын төлөөллийг оролцуулан нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй,
- Ерөнхий сайд /Ч.Сайханбилэг/-ын 2014 оны 151 дүгээр захирамжаар байгуулагдсан АББҮХ-г Ерөнхий сайд удирдах, бүрэлдэхүүнд нь УИХ-ын гишүүн болон Ерөнхийлөгчийн зөвлөх, БОНХАЖС, Эрчим хүчний дэд сайд, зарим яамдын⁵ ТНБД, НЗД-ын орлогч, БОНХАЖА-ны газрын дарга, НМХГ-ын даргыг оролцуулан нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй,
- Ерөнхий сайд /Ч.Сайханбилэг/-ын 2015 оны 247 дугаар захирамжаар байгуулагдсан АББҮХ-г Ерөнхий сайд удирдах, бүрэлдэхүүнд нь УИХ-ын гишүүн болон Ерөнхийлөгчийн зөвлөх, БОНХАЖС, зарим яамдын⁶ ТНБД, НЗД, НЗД-ын орлогч, зарим аймгийн⁷ Засаг Дарга, БОНХАЖА-ны газрын дарга, НМХГ-ын даргыг оролцуулан нийт 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, ажиллуулсан байна.

1.11 Агаарын бохирдлыг бууруулах ажлын албаны үйл ажиллагаанд баталсан төсвийн хөрөнгөөс зарим арга хэмжээнд зарцуулсан ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, гадаад орны туршлагаас авч хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн шинэ санал, санаачилга тодорхойгүй, томилолтоор явсан ажлын тайлан байхгүй байгаа нь үр дүнгүй арга хэмжээ болжээ гэж үзэхээр байна. Тухайлбал,

- АББҮХ-ны даргын /П.Цагаан/ 2013 оны 51 дүгээр тушаалаар Канад улсаас нийлүүлж буй “60-80 кв талбай халаах усан халаалтын сайжруулсан зуух”-ны үйлдвэрлэлт, хийц, технологитой газар дээр нь танилцах, гэрээний биелэлтийг шалгах зорилгоор НЗД-ын экологи хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ, Ажлын албаны дарга Р.Мягмар, Ажлын албаны шийдвэрийн гүйцэтгэлийн мэргэжилтэн С.Наранбаатар, ЦАС-ийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх, НАЧА-ны дарга Ч.Батсайхан, сэтгүүлч н.Чимэд-Эрдэнэ, н.Мөнх-Эрдэнэ нарыг томилолтоор ажиллуулсан,
- НАББҮХ-ны даргын /Д.Баттулга/ 2011 оны 6, 2011 оны 12, 2012 оны 23, 24 дүгээр тушаалаар Канад, Герман, АНУ-д Ажлын албаны дарга Р.Мягмарыг томилолтоор ажиллуулахаар нийт 8.8 сая төгрөг,
- АББҮХ-ны даргын /П.Цагаан/ 2012 оны 31 дүгээр тушаалаар Герман, Польш, Чех улсад Ажлын албаны дарга Р.Мягмар, мэргэжилтэн Г.Баттүвшин, Э.Түвшинтөр нарыг ажиллуулахаар 4.4 сая төгрөг,
- АББҮХ-ны даргын /П.Цагаан/ 2012 оны 36 дугаар тушаалаар “Цэвэр агаарын төлөө” сэдэвт чуулга уулзалтыг зохион байгуулахад хурлын танхимын түрээс, урилга, 50 хүний 2 өдрийн хоолны зардалд нийт 4.2 сая төгрөг,
- НАББҮХ-ны даргын /Д.Баттулга/ 2011 оны 17 дугаар тушаалаар НАББҮХ-ны Ажлын албаны 4 хүнд 1 сарын цалинтай тэнцэх урамшуулалд нийт 1.7 сая, АББҮХ-ны даргын /П.Цагаан/ 2012 оны 35 дугаар тушаалаар АББҮХ-ны Ажлын албаны 8 хүнд 1 сарын цалинтай тэнцэх урамшуулалд нийт 3.8 сая төгрөг,
- Мөн АББҮХ-ны Нарийн бичгийн дарга /Ж.Эрдэнэцогт/-ын 2014 оны 64 дүгээр тушаалаар ажлын албаны 2014 оны ажлын тайлан хэвлүүлэх зардалд 5.9 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.


1.12 Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны 2011-2015 онд үйлчилж байсан удирдлага, зохион байгуулалтын бүтцээс харахад агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр явуулж ирсэн үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд тавих хяналт, үнэлгээний ажил орхигдсон байна.

⁴ СЯ, БОНХЯ, ЭЗХЯ, ЗТЯ, БХБЯ, ЭХЯ, ЭМЯ

⁵ СЯ, УУЯ, БХБЯ, ЗТЯ

⁶ СЯ, БХБЯ, ЗТЯ, УУЯ, ЭХЯ

⁷ Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Ховд



- Дарга - БОАЖС
- Орлогч дарга - Сангийн сайд
- Гишүүд
 - ЭМС
 - ЗТБХБЯ-ны Хот төлөвлөлт, газрын харилцааны бодлогын газрын дарга
 - ЭБЭХЯ-ны Түлшний бодлогын газрын дарга
 - Улаанбаатар хотын Үйлдвэр, экологийн асуудал хариуцсан орлогч дарга
 - Агаарын чанарын мэргэжлийн алба
 - ШУА-ын ерөнхийлөгч
 - Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн
- Нарийн бичгийн дарга – БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга

1.14 2011 онд БОАЖС /Л.Гансүх/ нь ЦАС-ийн удирдах зөвлөлийн даргаар, Улаанбаатар хотын орлогч дарга /Д.Ганболд/ нь удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан боловч ЦАС-аас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн зарим ТАХ-ний захиалагч байсан нь хяналт тавих үйл ажиллагааг алдагдуулах эрсдэл үүсгэжээ.

1.15 ЦАС-г ЗГ-ын тусгай сан болгон байгуулсан боловч түүний удирдлагад яам, агентлагийн эрх бүхий албан тушаалтнуудыг томилсноос сангийн үйл ажиллагаа болон ТАХ-ний санхүүжилтэд нөлөөлсөн шийдвэр гаргаж хэрэгжүүлсэн байна. Жишээлбэл,

- НАББҮХ-ны 2011 оны ажлын төлөвлөгөөнд сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг дэмжиж, түлшний үнийн зөрүүний санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх байгууллагаар ЦАС-ийн удирдах зөвлөлд ажиллаж буй БОАЖЯ, ЭБЭХЯ, НЗДТГ-ыг тусгасан байна.
- ЗГ /Ерөнхий сайд Н.Алтанхуяг/-ын 2013 оны 18 дугаар тогтоолд БОНХС болон ЭХС-д гэр хорооллын айл өрхийн гэр, орон сууцны дулааны алдагдлыг бууруулахад чиглэсэн ажлыг хэрэгжүүлэхийг даалгасан боловч зөвхөн ЦАС-аас энэхүү ажлыг хэрэгжүүлжээ.

1.16 НАББУХ /дарга Д.Баттулга/-ны 2011 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд зарим зорилт, арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй байна. Тухайлбал, эрчим хүчний үйлдвэрлэлийн шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохдоо агаарын бохирдлыг бууруулах үндсэн зорилттой уялдаагүй, хүлэмжийн хийн



ялгарлыг бууруулахад чиглэгдсэн сэргээгдэх эрчим хүчний төсөл, хөтөлбөрийг дэмжих, урамшуулах механизмыг бий болгож хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, хариуцан хэрэгжүүлэгчээр ЭБЭХЯ, ЭХГ, БОАЖЯ зэрэг байгууллагыг сонгосон ч хэрэгжээгүй, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндсэн зорилттой уялдаагүй байна.

1.17 Мөн Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн талаар дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны хүрээнд гэрийн дулаалгын стандартыг батлах гэсэн арга хэмжээг төлөвлөж байсан боловч хэрэгжүүлээгүй, энэ ажил орхигдсон байна.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа зарим төрийн байгууллагуудын чиг үүрэг давхацсанаас зарим үйл ажиллагаа орхигдсон байна

1.18 УИХ, ЗГ-аас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох хууль, тогтоомж, бодлогын шийдвэрийг баталж, эрх зүйн орчныг бий болгосноор хариуцсан байгууллага, нэгжийг үүсгэн байгуулах, бодлого, стратегийн хүрээнд хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төрийн захиргааны байгууллагуудын холбогдох түвшний газар, нэгж, албан тушаалтны чиг үүрэгт хариуцуулж ирсэн байна.

1.19 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон төрийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж ирсэн боловч тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн дүгнэх, хяналт тавих чиг үүрэг орхигдсон байна. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж ирсэн төрийн байгууллагуудын чиг үүргийг авч үзвэл:

- **БОАЖЯ /Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар/-** хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаарх хууль тогтоомж, бодлого, урт болон дунд хугацааны стратеги, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, агаарын бохирдлоос сэргийлэх, хамгаалах, бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг зохион байгуулах, зохицуулах;
- **АББҮХ-ны ажлын алба /БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээнд/-** агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг салбар дунд зохицуулан ажиллах, хяналт тавих;
- **НАББГ /хуучнаар НАЧА/-** агаарын бохирдлыг бууруулах, агаар хамгаалах талаар төр, засаг, нийслэлийн удирдлагуудаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, хөтөлбөр, стандартын төсөл боловсруулах, агаарын чанарыг тодорхойлох, **агаар бохирдуулах эх үүсвэрүүдэд хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, холбогдох мэдээ, мэдээлэл гаргах;**
- **ЦУОШГ-** хүрээлэн буй орчны төлөв байдал, агаар ус, хөрсний чанар, цацраг идэвхийн түвшний болон **бохирдлын эх үүсвэрийн хяналт шинжилгээний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,** орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэмжилт зүй, стандартын нэгдмэл байдлыг хангах, улсын агаарын чанарын мэргэжлийн албаны үүргийг гүйцэтгэж, агаарын чанарын болон бохирдлын эх үүсвэрийн мэдээллийг нэгтгэж сан бүрдүүлэх, тайлагнах, агаар бохирдуулах бодисын хаягдал, түүний эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулах, агаарын чанарын төлөв байдлыг мэдээлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах, озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

1.20 Агаар бохирдуулах эх үүсвэрүүдэд хийх хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулах чиг үүрэг БОАЖЯ-нд байгаа боловч энэ талаар тодорхой үйл ажиллагаа явуулаагүйгээс Агаарын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д *“Төрийн захиргааны төв байгууллага нь агаарын чанар, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, хүчиллэг тунадас, давхраат мандлын озон, хүлэмжийн хийн агууламжийн өөрчлөлтөд ... судалгаа, шинжилгээ хийж үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулна”* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.21 ЗГ-ын 2018 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гарсан хууль, эрх зүйн хэрэгжилтэд хяналт тавих, агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд бохирдлын түвшин тодорхойлох хэмжилт, шинжилгээ хийж, түүнийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй Агаарын чанарын хэлтсийг 2018 онд 14 улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр НМХГ-ын бүтцэд байгуулсан байна.



1.22 АББҮХ, ЦАС-ийн хоорондын уялдаа холбоог хууль тогтоомжид тодорхой зааглаж өгөөгүйгээс ЦАС-ийн удирдах зөвлөлд орсон яам, агентлагийн төлөөлөл, ЦАС-ийн чиг үүргийг давхар хариуцан ажиллаж байгаа нь үйл ажиллагаанд хэрэгжих хяналтыг орхигдуулах эрсдэлийг үүсгэжээ. Тухайлбал,

- ЦАС-ийн удирдах зөвлөлд БОАЖС, ЭМС, СС болон Улаанбаатар хотын орлогч дарга нар, АББҮХ-ны удирдах зөвлөлд БОАЖ-ын болон ЭМЯ, СЯ-ны ТНБД нар болон Улаанбаатар хотын захирагч бүрэлдэхүүнд байна.

1.23 Агаарын бохирдлыг бууруулах тухай эрх зүйн шийдвэрүүдэд холбогдох чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудад энэхүү ажиллагаанд үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтийг хянах эрх, үүрэг олгогдсон байхад АББҮХ-нд энэхүү чиг үүргийг давхардуулан тодорхойлсон байна.

1.24 Түүнчлэн зарим албан тушаалтны хуулиар эрхлэх асуудал нь тодорхой байхад ажлын хэсэгт оруулаагүй байна. Тухайлбал, ЗГТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.5.1-т Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд “... агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал” гэсэн чиг үүрэг тодорхойлогдсон байхад үүнийг хэрэгжүүлэх тодорхой албан тушаалтныг АББҮХ болон ЦАС-ийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллуулаагүй байна.

1.25 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг тодорхой хэмжээгээр бүрдүүлсэн боловч энэхүү үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй, үйл ажиллагаа харилцан уялдаагүй, арга хэмжээг хэрэгжүүлэгч, хяналт тавих байгууллагуудыг нэгдмэл удирдлагаар хангаагүй, үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн дүгнээгүй, нэгдсэн хяналтаар хангаагүй байна.

2017 оноос өмнө агаарын бохирдлыг бууруулах талаар бие даасан үндэсний хөтөлбөр батлагдаагүй байна

1.26 ДБ-аас “Агаарын бохирдлын түвшин ба чанар эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тогтоох судалгаа”-г 2008 оноос эхлүүлж нийслэлийн агаарын бохирдлын нөхцөл байдал, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг судалснаар агаарын бохирдлын үүсгэгчийг дараах байдлаар тодорхойлсон байна⁸. Үүнд:

- Нийслэл дэх гэр хорооллын 190.0 гаруй мянган айл өрхүүд нүүрсээр галлаж байгаа ердийн галлагаатай зуухнаас ялгарч байгаа утаа, үнс тортог,
- Нийслэлд бүртгэгдсэн, автозамын хөдөлгөөнд өдөр тутамд оролцож байгаа 400.0 гаруй мянган автомашин, үүний дотор олон жилийн эдэлгээтэй 100.0 орчим мянган хуучин автомашинаас ялгарах утаа болон хорт бодисууд,
- Дулааны цахилгаан станц болон алслагдсан дүүргийн 3.0 мянга гаруй уурын зуухны галлагаанаас ялгарах утаа, үнс тортог,
- Нийслэлийн нутаг дэвсгэрийн хатуу хучилтгүй, ердийн хөрсөн замаас үүсэх тоосжилт,
- Гэр хорооллын ил задгай хог хаягдал, овоолго.

1.27 Дээрх судалгаа, дүгнэлтэд үндэслэн УИХ-аас дараах бодлого, хөтөлбөрүүдийг баталж, зорилтыг тодорхойлж иржээ. Тухайлбал,

- УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого 2007-2021”,
- 2008 оны 35 дугаар тогтоолоор “ЗГ-ын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”,
- 2010 оны 36 дугаар тогтоолоор “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр”,
- 2011 оны 02 дугаар тогтоолоор “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”,
- 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”,
- 2014 оны 43 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлого” зэрэг баримт бичгүүдийг тус тус баталж, тодорхой зорилтуудыг дэвшүүлжээ.

1.28 МУ-ын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 2-т заасан “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах” эрхийг ханган

⁸ Эх сурвалж: ДБ, 2009 он



баталгаажуулах зорилгоор УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг баталж, 2010-2016 оны хооронд хэрэгжүүлжээ.

1.29 Тус хөтөлбөрийн 4.4.5-д Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах 26 зорилт, 7.1-д хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, 8.1-т “хөтөлбөрийн биелэлтийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг томъёолсон байна. Гэвч аудитын явцад “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд ЗГ-аас 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг тус хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй харьцуулахад хангалтгүй, зорилт биелээгүй байна.

1.30 Дээрх тус хөтөлбөрийн 7.1.2-т “Улаанбаатар хотын утаанд эзлэх хорт бодисын агууламж 2012 онд 30 хувь, 2016 онд 70 хувиар багасах” үр дүнд хүрэхээр төлөвлөж, үүнийг 8.1.5-д заасны дагуу “Улаанбаатар хотын тоосжилтын хэмжээ”-г шалгуур болгон үнэлэхээр заасан байна. Гэтэл ЦУОШГ-аас авсан мэдээгээр энэ үзүүлэлт 2012 онд 30 хувь буурахаас 20 хувиар буурсан, 2016 онд 70 хувь буурахаас 5 хувь өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1. Нарийн ширхэглэгт тоосонцрын өсөлт, бууралтын хэмжээ (он, хувь)



Эх сурвалж: ЦУОШГ

1.31 Хөтөлбөрийн 7.1.5-д “нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 20 м² талбай болж, байршил, суурьшлын зохистой байдал бүрдэх” гэж заасан байхад УБЗАА-аас авсан мэдээгээр нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 2.5м² байна.

1.32 УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолын 2.3-т “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн биелэлтийг 2 жил тутам гаргаж, УИХ-д танилцуулахыг ЗГ-т үүрэг болгосон байна. Гэвч ҮАГ-т ЗГХЭГ-аас ирүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах 26 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудын биелэлтийн мэдээллийг ирүүлээгүй байна.

1.33 Дээр дурдагдсан зөрчилтэй асуудлуудаас үзэхэд “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 3.1.5-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлж дүгнэх хариуцлагын тогтолцоо бий болгох” гэж заасан зарчмыг ЗГ баримталж ажиллаагүй, нэгтгэн дүгнээгүй, хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарал төдийлөн хандуулаагүй байна.

1.34 2010 оны Агаарын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “ЗГ агаарыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг батлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг үндэслэн УИХ-ын 2011 оны 02 дугаар тогтоолоор “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”-ийг баталсан боловч агаар хамгаалахтай холбоотой асуудлыг орхигдуулсан байна.

1.35 ЗГ-аас 2010 онд нийслэлийн агаарын бохирдлыг зөвшөөрөгдөх хэмжээнд нь хүртэл бууруулахын тулд үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх нэн тэргүүний стратеги зорилтууд, үйл ажиллагаа, түүнд шаардагдах хөрөнгө санхүүгийн тооцоог цогцоор нь тодорхойлсон гэх “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг боловсруулж УИХ-д өргөн барьсан боловч хэлэлцэгдэж, батлагдаагүй байна. Харин ЗГ /Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат/-ын 2017 оны 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталжээ.

1.36 Үүний дагуу БОАЖЯ 2017 оны хэрэгжилтийн тайланг холбогдох яамд, агентлаг, НЗДТГ-аас авч нэгтгэн 70 хувийн хэрэгжилттэй байна гэж дүгнэснээс өөр агаар, орчны бохирдлыг бууруулах талаар дорвитой цогц арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

1.37 АББҮХ-ны хэрэгжүүлэх ажлын болон ЦАС-ийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн Улаанбаатар



хотын агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд дэвшүүлсэн зорилтуудын ихэнх ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгаж ирсэн байна.

1.38 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баталж, мөрдүүлсэн хууль эрх зүйн орчинд хийсэн судалгааны дүнгээс үзэхэд хууль тогтоох болон төрийн төв, бусад захиргааны байгууллага, үндэсний хороод, аж ахуйн нэгж, иргэний хүлээх чиг үүрэг, хариуцсан асуудлаар тодорхой заалтууд үйлчилж байгаа боловч хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлох, үнэлэх, зөрчлийг арилгах, хэрэгжилтэд хяналт тавих замаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил хийгдээгүй байна.

1.39 Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой батлагдсан хууль тогтоомжид үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт, шаардлагатай санхүүгийн эх үүсвэр, төсөв, төсөл, хөтөлбөрийг баталж мөрдүүлэх, хяналт тавих, дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой заалт нийт чиг үүргийн 56.1 хувийг эзэлж байна.

1.40 Гэвч холбогдох хууль тогтоомж батлагдсан ч биелэлтэд тавих хяналт сул, үйл ажиллагааны давхардал ихтэй, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь нэгдсэн удирдлагаар хангагдаагүй буюу засаглал, чадавх, төлөвлөлт сул байснаар агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлын үр дүн, үр нөлөөт байдалд сөргөөр нөлөөлсөн байна.



БҮЛЭГ 2. АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗОРИЛГОО БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ ЧАДААГҮЙ БАЙНА

Ерөнхий мэдээлэл

Агаарын бохирдлын төлбөрийг ногдуулах талаар 1995 оны Агаарын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1⁹, 19.2¹⁰ дэх заалтыг 2010 оны Агаарын тухай хуулийн 23.1-т “Агаарын бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын төлбөр төлнө”, 23.2-т “Энэ хуулийн 23.1-д заасан агаарын бохирдлын төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх журмыг хуулиар тогтооно” гэж өөрчлөн найруулсан байна.

Мөн 2010 онд Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийг баталж, 2011 оноос мөрдсөн ба 2011-2016 онд агаарын бохирдлын төлбөрийг улсын төсөвт 135.0 тэрбум, нийслэлийн төсөвт 9.7 тэрбум, нийт 144.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ.

Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг бохирдуулагч эх үүсвэрийг тогтоох, шинжлэх, хяналтыг сайжруулах, хор хөнөөлийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний чадавхыг сайжруулах болон үнэлгээ хийх, бодлогын зөвлөмж гаргах чиглэлээр гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр, уламжлалт зуухны хэрэглээг хумьж сайжруулсан зуухыг нэвтрүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, гэрийн дулаан алдалтыг бууруулах, боловсруулсан түлшээр хангах зэрэг арга хэмжээг дотоодын эх үүсвэрээс буюу улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж ирсэн байна.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2008-2016 онд улсын төсвийн урсгал зардлаас 97.7 тэрбум, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 54.9 тэрбум, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаас 9.2 тэрбум, МУХС-аас 2.1 тэрбум буюу нийт **164.1** тэрбум төгрөг зарцуулж, гадаадын 104.7 сая ам.долларын зээл, 48.6¹¹ сая ам.долларын буцалтгүй тусламж авч ашигласан байна. (Хүснэгт 1-д үзүүлэв)

Хүснэгт 1. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зарцуулсан хөрөнгийн судалгаа*

ҮЗҮҮЛЭЛТ		Он									Нийт дүн
		2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	
А. Дотоод эх үүсвэрийн дүн, Тбм.төг/ үүнээс:		4.0	3.3	5.6	44.7	45.2	32.3	13.8	5.7	9.5	164.1
Улсын төсөв	Урсгал	-	-	-	31.5	24.6	22.9	9.2	5.3	4.2	97.7
	Хөрөнгө оруулалт	1.7	0.3	5.2	10.6	20.6	8.6	2.6	-	5.3	54.9
Нийслэлийн төсөв	Хөрөнгө оруулалт	0.2	3.0	0.4	2.6	-	0.8	2.0	0.4	-	9.4
Монгол Улсыг хөгжүүлэх сан		2.1	-	-	-	-	-	-	-	-	2.1
Б. Гадаад зээлийн дүн /сая ам.доллар/		-	0.3	1.3	52.9	-	2.2	32.2	9.2	6.6	104.7

Эх сурвалж: СЯ, НЗДТГ (СЯ-аас тусламжийн дүнг он тус бүрээр гаргаж ирүүлээгүй болно)

Улсын төсвөөс ЦАС-ийн 2011-2015 оны үйл ажиллагаанд 93.4 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийг он бүрээр харуулбал:


⁹ 19.1 “Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хорттой нөлөөлөл үзүүлдэг болон агаарыг савлах, бусад аргаар үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр төлнө.

¹⁰ 19.2 Төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх журмыг хуулиар тогтооно.

¹¹ Тайлбар: СЯ-аас хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд олгосон буцалтгүй тусламжийн хөрөнгийн ашиглалтыг он тус бүрээр ирүүлэх боломжгүй гэсэн тайлбар ирүүлсэн.




Дүрслэл 2. Дотоод, гадаад эх үүсвэрээс санхүүжүүлсэн дүн /сая төгрөг/



Эх сурвалж: СЯ, НЗДГ

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зарцуулсан нийт хөрөнгийн 26 хувийг үртсэн шахмал түлшний цогцолбор байгуулж, өргөжүүлэхэд, 22 хувийг сайжруулсан зуух, үнс тээвэрлэх автомашин авах, 14 хувийг нам даралтын халаалтын зууханд шинэчлэлт хийх, 10.9 хувийг сайжруулсан түлш, хэсгийн ахлагчийн урамшуулал, агуулахын түрээс гэх мэт зардалд зарцуулсан байна. /Дүрслэл 2-оос үзнэ үү./

Дүрслэл 3. АББ чиглэлээрх арга хэмжээний ангилал /хувь/



Эх сурвалж: Аудитын ажлын баримт (дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү)

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР

2.1 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээрх ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө тооцоо судалгааг иж бүрэн хийгээгүй, зураг төсөв батлагдаагүй, мэргэжлийн байгууллагаас техникийн нөхцөл болон тусгай зөвшөөрлийг аваагүй зэрэг бэлтгэл ажлыг хангаагүй байна. Тухайлбал,

- ЗГ /Ерөнхий сайд С.Баяр/-ын 2008 оны 14 дүгээр тогтоолоор зураг, төсөв батлагдаагүй байхад “ДЦС-2 ТӨХК-ийг түшиглэн 210.0 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах” ТАХ-г 17.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлэхээр төсөвт тусгасан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹², Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11¹³ дэх заалтыг зөрчжээ.

¹² 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон ТАХ-а тусгана”.

¹³ 32.1.1 “зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх”



- НЗД /Г.Мөнхбаяр/-ын 2009 оны 320 дугаар захирамжаар батлагдсан зураг, төсөвгүй, эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгаагүй, газрын байршлыг оновчтой тодорхойлоогүй, түүхий эдийн нөөцийг тогтоогоогүй байхад “*Үртсэн шахмал түлшний иж бүрэн үйлдвэр*”-ийг байгуулахаар шийдвэрлэжээ. Одоогоор тус үйлдвэр нь зогсонги байдалд орсон бөгөөд ЦАС-аас олгох санхүүжилт зогссон, үйлдвэрлэлийн гол түүхий эдийн олдоц муудсан, хүн хүч дутмаг зэргээс шалтгаалсан байна.
- Коксжсон болон шахмал түлшний үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгохдоо хэрэглэгчийн болон технологи, эдийн засаг, санхүүгийн хэрэгцээг нарийвчлан тооцоолоогүй байна.

2.2 Түүнчлэн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамрах хүрээ, зорилтыг оновчтой тогтоогоогүй, хугацаандаа хэрэгжүүлэх боломжгүй, төсөв, санхүүгийн эх үүсвэрийн эрсдэл дагуулсан, арга хэмжээний давхардал үүсгэсэн, нэгдсэн зохион байгуулалтгүй, эрх зүйн хэм хэмжээний холбогдох заалтыг баримтлаагүй буюу төлөвлөлтийн үндсэн шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал,

- НАББҮХ /дарга Д.Баттулга/-ны 2011 онд хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд эрчим хүчний үйлдвэрлэлийн шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дэвшүүлсэн “*ДЦС-5*” барих ажлыг эхлүүлэх, “*ДЦС-6*”-ын ТЭЗҮ боловсруулах арга хэмжээг тусгасан боловч хэрэгжээгүй байна.
- Дээрх төлөвлөгөөнд “*ДЦС-2*” ТӨХК-г түшиглэн хагас коксжсон түлшний үйлдвэр байгуулах арга хэмжээг төлөвлөсөн ч 3 жил гаруй хугацаанд үргэлжилсэн байна.
- 2011 онд гэр хорооллыг барилгажуулах, дэд бүтцийг барьж байгуулах зорилтын хүрээнд төлөвлөсөн “*гэр хорооллын газрыг чөлөөлөх, барилгажуулах, айл өрхөд нөхөн төлбөр олгох хөрөнгийг шийдвэрлэх, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах*” арга хэмжээг төлөвлөхдөө урьдчилсан судалгааг хийгээгүй, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эрсдэлийг үнэлээгүй, нэгдсэн зохион байгуулалт, цогц байдлаар хэрэгжүүлэх бодлогыг харгалзан үзээгүйгээс бүрэн хэрэгжээгүй байна.
- АББҮХ /дарга Д.Баттулга/-ны 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбар дундын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих зорилтын хүрээнд “*Хотыг дахин хөгжүүлэх хууль*”-ийн төслийг боловсруулсан боловч уг хууль өнөөг хүртэл батлагдаагүй орхигджээ. Харин 2015 онд хот, суурин газрын гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан “*Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай*” хууль батлагдсан байна.
- 2012 онд зарим цахилгаан станцад өргөтгөл шинэчлэлт хийх, дэд бүтцийн ажил гүйцэтгэх, дэд станц байгуулах, ЦДАШ барих гэх мэт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-г төлөвлөсөн байна.

2.3 УИХ-ын 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн тогтоолын дагуу ЗГ болон АХБ хоорондын “*Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр*”-ийг 3 үе шаттайгаар нийт 320.0 сая ам.долларын¹⁴ хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.4 Дээрх ТАХ-г НЗД-ын харьяанд “*Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр*” төслийн нэгж хэрэгжүүлж байгаа бөгөөд ТЭЗҮ-д 22 айл өрхийг нүүлгэн шилжүүлэн 77 айл өрхийн хашааны байршлыг өөрчлөхөд 6.7 тэрбум төгрөгийг тусгасан боловч төслийн явцад 872 айл өрхийг нүүлгэн шилжүүлэхээр болсон байна. 2016-2018 онд газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх зардалд нийт 9.3 тэрбум төгрөг зарцуулсан нь анхны төсөвлөсөн хэмжээнээс 2.6 тэрбум төгрөгөөр хэтэрсэн байна. Гэвч нийт 872 айл өрхийг нүүлгэн шилжүүлэхээр төсвийг тодотгож өгөөгүйгээс төлөвлөгдөөгүй их хэмжээний зардал гарах эрсдэл үүсжээ. Цаашид уг төслийг хэрэгжүүлэхэд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд зарцуулах зардал тодорхойгүй байгаа нь төслийн төлөвлөгөөг боловсруулахдаа бодит тооцоо судалгаанд суурилан боловсруулаагүйтэй холбоотой байна.

2.5 Дээрх төслийн баримт бичигт төслийн удирдах хороог жилд хоёроос доошгүй удаа хуралдана гэж заасан боловч төсөл хэрэгжүүлэх нэгжийг бодлогын удирдамжаар хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий төслийн удирдах хороо 2016 оны 04 дүгээр сараас хойш хуралдаж, ажлын үр дүнгээ хэлэлцээгүй бөгөөд үйл ажиллагаагаа НЗД-ын захирамжийг үндэслэн явуулж ирсэн байна.

2.6 ЦАС нь ТАХ-ний хувьд захиалагч болон санхүүжүүлэгчийн үүргийг хослон гүйцэтгэж байснаас 2011-2015 онд 5 үндсэн орон тоотой ажиллаж байсан бөгөөд 3 мэргэжилтэн нь ТАХ-

¹⁴ Нийслэлийн төсвөөс 96 сая, ЕХОБ-ны зээлээр 60.3 сая, АХБ-ны зээлээр 163.7 сая, нийт 320 сая ам.доллар



ний гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулахад оролцсон нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4¹⁵ дэх заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,

ЦАС-ийн гүйцэтгэх захирал /Н.Хүрэлсүх/-ын Үнэлгээний хороо байгуулах тухай 2012 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 21/А дугаар тушаалаар дараах ТАХ-г зохион байгуулахаар үнэлгээний хорооны даргаар ЦАС-ийн мэргэжилтэн Г.Баярсайхан, нарийн бичгийн даргаар мэргэжилтэн Б.Соёлмааг, гишүүнээр мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ нарыг томилсон байна.

- “МУ-ын өрсөлдөх чадварын тайлан 2011- Ногоон эдийн засаг” ном хэвлүүлэх арга хэмжээ;
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхүүдэд шалны халаагуур нийлүүлж, суурилуулах арга хэмжээ,
- Автомашинаас ялгарах агаар бохирдуулагч бодисын ялгарлыг багасгах түлш шатахууны зориулалттай биомасс агуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх арга хэмжээ;
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхүүдэд цахилгаан халаагуур нийлүүлэх арга хэмжээ.

2.7 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34¹⁶ дүгээр зүйлд заасан нөхцөлүүдийг хангаагүй байхад зарим ТАХ-ний гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д *“Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”* гэсэн заалтыг зөрчжээ. Тухайлбал,

- ЭБЭХЯ “ДЦС-2” ТӨХК-ийн хагас коксон түлш хийхэд шаардагдах шингэн шилний үйлдвэр байгуулах ажлыг 1.2 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Аморе интернэйшнл” ХХК-тай 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 11/65 дугаар гэрээг шууд байгуулсан,
- НАББҮХ-ны 2011 оны “Авто тээврийн хэрэгслийн бохирдлыг бууруулах арга хэмжээний тухай” 11/05 дугаар тогтоолын дагуу 495 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа, тортогжилтын хэмжээг бууруулах зориулалттай тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажил”*-ыг хийж гүйцэтгүүлэхээр НЗДТГ, ЦАС “Хаштехник” ХХК-тай 2011 онд шууд гэрээ байгуулсан,
- НАББҮХ /Д.Баттулга/-ны 2011 оны 11/04 дүгээр тогтоолоор баталсан *“Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай”* журмын дагуу НЗДТГ, ЦАС-аас түлш үйлдвэрлэгч компаниудтай *“Түлш нийлүүлэх гэрээ”*-г байгуулахдаа ЦАС-д ирүүлсэн НАББҮХ /Д.Баттулга/-ны 2011 оны ҮХ-1119 дугаар албан бичигт *“ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5¹⁷-д заасны дагуу болон НАББҮХ-ны хурлаар бүтээгдэхүүний үнийг тогтоосон, МУ-ын нутаг дэвсгэрт түлш үйлдвэрлэж байгаа бүх компаниудыг оролцуулж байгаа учраас өрсөлдөөн гарахгүй гэсэн шалтгааны улмаас шууд гэрээ байгуулах”* гэж заасны дагуу шууд гэрээ байгуулжээ.

2.8 ЦАС-ийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим ТАХ-ний зориулалтыг авч үзэхэд ЗГТСТХ-ийн 12¹ дүгээр зүйлийн 12¹.2-д заасан зориулалттай нийцэхгүй байгаа нь агаарын бохирдолд хөрс, ус, агаар, орчны бохирдлын асуудлыг цогцоор нь авч үзэн эрх зүйн баримт бичигт тусгаагүйтэй холбоотой байна. Тухайлбал,

- Хөрсний бохирдлыг бууруулах, шивтрийн хийг багасгах ажлын хүрээнд УБ хотын гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхийг ариутгах ажлыг 3,048.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Ирвэс интертрейд ХХК /захирал Л.Төгсжаргал/-тай УБ хотын ерөнхий менежер бөгөөд ЗАА /дарга Ч.Бат/, ЦАС /гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх/ 2011 оны 6 дугаар сарын 06-ны өдөр 01 дугаар бүхий гэрээ байгуулсан;
- Туул, Сэлбэ голын эхийг сэргээх, урсцыг нэмэгдүүлэх арга хэмжээг нийт 2,297.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр дараах 2 гэрээг байгуулсан байна.
- БОНХЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар /дарга Г.Чулуун/, ЦАС /гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх/ “Монхидроконстракшн” ХХК-тай (Сэлбэ гол) 1,325.8 сая төгрөгийн ажил гүйцэтгэх ТБГШ-2011/12 дугаар гэрээг 2011 онд,

¹⁵ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл ТББ-ын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэн, ЗДТГ-ын ажилтныг оролцуулна.

¹⁶ “ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйл. “Гэрээ шууд байгуулах арга”

¹⁷ “ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйл. 34.1.5 дах заалт



- “Монгол Ус/ ТӨҮҮГ /захирал Ц.Сосорбарам/-тай (Туул гол) 971.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэх ЦАС-2012/12/24 дүгээр гэрээг 2012 онд тус тус байгуулсан;
- Эзэн хариуцагч тодорхойгүй барилгын болон гэр хорооллын хур хогийг цэвэрлэх ажилд 633.9 сая төгрөгийг зарцуулахаар БОАЖЯ-ны экологийн цэвэр технологи, шинжлэх ухааны хэлтэс /дарга А.Энхбат/, Улаанбаатар хотын ХУД, БЗД, СБД, ЧД, СХД, БГД, Налайх, Багануур, Багахангай дүүргийн Засаг дарга нартай 2012 оны 5 дугаар сарын 04-нд 01-09 дүгээр гэрээ байгуулсан;
- Хөрсний бохирдлын судалгаа хийлгэхэд 76.0 сая, “МУ-ын өрсөлдөх чадварын тайлан 2011-Ногоон эдийн засаг” номыг 1,000 ширхэг хэвлүүлэхэд 24.6 сая, АСЕМ-ийн хүрээнд “МУ-н сэргээгдэх эрчим хүчний өлгий нутаг” сэдэвт олон улсын хурал зохион байгуулахад 25.0 сая, ойжуулалт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нэг сая мод ургуулахад 489.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан боловч үр дүнг дүгнэсэн баримт материал байхгүй байна.

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Сайжруулсан зуухны нийлүүлэлт, ашиглалтын талаар

2.9 УБ хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ДБ, МСС, ЦАС болон улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр сайжруулсан зуух бэлтгэн, худалдан нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Аудитын явцад олж авсан бүрэн бус мэдээллээр Турк, Хятад улсад үйлдвэрлэсэн болон өөрсдийн зохион бүтээсэн зуухыг лабораторийн шинжилгээгээр оруулан туршилт хийж, нийлүүлэгдэх зуухыг сонгон, дүүрэг, хороодоос гаргаж ирүүлсэн судалгааг үндэслэн тодорхой үнийн дүнгийн хөнгөлөлт үзүүлэн айл өрхүүдэд худалдан нийлүүлсэн гэсэн боловч баримтаар нотлогдохгүй байна.

2.10 Агаарын бохирдлыг бууруулах үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий БОАЖЯ болон НАББГ хоорондын ажлын уялдаа, нэгдсэн зохион байгуулалт хангалтгүйгээс сайжруулсан зуухны нийт нийлүүлэгдсэн тоо хэмжээний мэдээлэл хүснэгт 2-оос харахад зөрүүтэй байна. Тухайлбал, ЯАГ-т ирүүлсэн мэдээллээс үзэхэд:

- БОАЖЯ-ны 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/6855 дугаар албан бичигт нийт 176,913 ширхэг сайжруулсан зуух нийлүүлсэн,
- Хас банкны 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 18/5960 дугаар албан бичигт нийт 149,233 ширхэг сайжруулсан зуух нийлүүлсэн байна.
- Гэтэл НАББГ-ын 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 03/486 дугаар албан бичигт нийт 7,500 ширхэг зуух нийлүүлсэн гэсэн нь дээрх судалгаануудад ороогүй байна.

Хүснэгт 2. Төсөл, хөтөлбөрөөр нийлүүлсэн сайжруулсан зуух (тоо)

№	Он	Санхүүжилтийн эх үүсвэр		БОАЖЯ	Хас банк
1	2011-2013	Гадаадын тусламж	МСС-ийн “Цэвэр агаар” төсөл	97,787	85,160
2	2011-2015	ЦАС /дангаараа/		38,313	23,170
3	2013-2016	Гадаадын зээл	ДБ-ны “Улаанбаатар-Цэвэр агаар” төсөл	40,813	40,903
НИЙТ				176,913	149,233

Эх сурвалж: БОАЖЯ, Хас банк

2.11 Сайжруулсан зуухны үнийн хөнгөлөлтөд 2010-2012 онд хэрэгжсэн МСС-ийн “Цэвэр агаар” төслөөс нийт 33.0 сая ам.доллар, 2012-2016 онд хэрэгжсэн ДБ-ны санхүүжилттэй “УБ цэвэр агаар” төслөөс 4.5 сая ам.доллар, ЦАС-аас 2011-2015 онд нийт 32.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.12 Сайжруулсан зуухны утааны бохирдлын хэмжээг харгалзан гэрээнд оролцогч талууд зуухны борлуулах үнийг тогтоосон гэх боловч аудитын явцад тодорхой баримтаар нотлогдохгүй байгаа бөгөөд иргэдийн төлөх үнийг 7-14 хувь байхаар тооцон, зөрүүг гадаадын төсөл, ЦАС-аас санхүүжүүлжээ. Тухайлбал,

Хүснэгт 3. МСС-ийн Цэвэр агаар төсөл, ЦАС-ийн санхүүжилт (төгрөг)

д/д	Зуухны нэр	Зах зээлийн үнэ	МСС-ийн Цэвэр агаар төсөл	ЦАС	Хэрэглэгчийн төлөх үнэ
1	Өлзий зуух	352,000	273,280	51,220	27,500



2	Хас зуух	480,000	219,040	203,260	57,700
3	Дөл зуух	378,000	238,333	111,367	28,300
4	Голомт зуух	330,000	245,000	40,000	45,000

Эх сурвалж: МСС-ийн Цэвэр агаар төслийн ажлын тайлан

Хүснэгт 4. ДБ-ны Улаанбаатар-Цэвэр агаар төсөл, ЦАС-ийн санхүүжилт (төгрөг)

д/д	Зуухны нэр	Зах зээлийн үнэ	УБ-Цэвэр агаар төсөл	ЦАС	Хэрэглэгчийн төлөх үнэ
1	Өлзий зуух	415,000	192,000	192,000	31,000
2	Дөл зуух	419,360	193,680	193,680	32,000
3	Талст зуух	295,900	132,950	132,950	30,000
4	Бекас зуух	275,000	123,000	123,000	29,000

*Эх сурвалж: УБ-Цэвэр агаар төслийн ажлын тайлан

2.13 МСС-аас хэрэгжүүлсэн “Зуух хөтөлбөр”-ийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдэд тараасан зууханд лабораторийн туршилт хийгдсэн талаарх мэдээлэл байхгүй байна.

2.14 МСС-ийн “Цэвэр агаар” төслийн хүрээнд хамрагдаагүй үлдсэн нийслэлийн гэр хорооллын 6 дүүргийн 45,000 гаруй айл өрхүүдэд ДБ-ны “УБ-цэвэр агаар” төслөөс шаардлагад нийцсэн бүрэн шаталттай, сайжруулсан зуухыг нийлүүлэхийн тулд сонгон шалгаруулах туршилтын ажлын зарыг 2013 оны 5 дугаар сард олон нийтэд нээлттэй зарлаж, нийт 10 ААНБ-аас 15 төрлийн зуухыг туршилтад хамруулах хүсэлт ирсний дагуу зуухнуудыг “Зуухны утаа ялгаруулалт, үр ашгийг турших лаборатори”-т туршсан байна.

2.15 Зуухны туршилтад орсон 15 төрлийн зуухнаас төслийн шалгуур үзүүлэлт болон зуухны стандартыг “Сэлэнгэ констракшн” ХХК-ийн “Өлзий зуух”, “Роял өүшн” ХХК-ийн “Дөл зуух”, “Элмеко” ХХК-ийн “Талст зуух”, “Их тэнгэрийн хүч” ХХК-ийн “Векас-107” зуух хангасан байна.

2.16 ДБ-ны “УБ-цэвэр агаар” төслөөс хэрэгжүүлсэн “Зуухны хөтөлбөр”-т дараах байгууллагууд оролцсон байна. Үүнд:

- ЗГ-ын тусгай сан-ЦАС,
- Зуух борлуулах цэгүүдийн үйл ажиллагааг хариуцагчаар Хас банк,
- Зуухны утаа ялгаруулалт, үр ашгийг турших лаборатори- ШУТИС-ийн дэргэдэх ДТҮЭХ,
- Төслийн шалгуур үзүүлэлтийг хангасан зуух нийлүүлэгчид,
- Зуух устгалын компани,
- Чанарын хяналтын баг

2.17 Гадаадын төсөл, ЦАС-аас хэрэгжүүлсэн сайжруулсан зуухны төслийн гүйцэтгэгчээр ажилласан Хас банканд бүртгэгдсэн мэдээллээс үзэхэд нийт түгээсэн 64,073 зуухнаас уламжлалт зуухаа хураалгахаас татгалзсан, шаардлага хангахгүй зэвэрч хуучирсан хэрэглэгдэх боломжгүй зуух өгөх гэх мэт шалтгааны улмаас 5,287 зуухыг түгээгээгүй нь сайжруулсан зуухны хэрэглээг сайн сурталчлаагүй, энэ талаар орон нутгийн засаг захиргааны байгууллага тодорхой үр дүнд хүрэх ажил зохион байгуулж ажиллаагүйтэй холбоотой байна.

2.18 Аудитын явцад НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс гаргасан мэдээгээр нийслэлийн төсвөөс 2010-2011 онд нийт 63.0 сая төгрөгийн өртөгтэй 640 ширхэг сайжруулсан зуухыг гэр хорооллын айл өрхөд нийлүүлсэн байхад НАББГ-аас ирүүлсэн албан бичигт энэ талаарх мэдээллийг огт дурдаагүй, нэмэлт тодруулга, тайлбарыг өгөөгүй болно.

2.19 Агаар бохирдуулагч эх үүсвэрийн 2016 оны тооллогын бүртгэлд 111.7 мянган сайжруулсан зуух бүртгэгдсэн байхад аудитаар тогтоосон дүнгээс 65.2 мянган зуухаар зөрүүтэй байгаа нь зуухны тараалт, ашиглалтад хяналт тавиагүй, бүртгэл тооллогыг дутуу хийсэн, ажил

Дүрслэл 4. Сайжруулсан болон энгийн зуухны судалгаа





хариуцсан байгууллага, албан тушаалтан тодорхой арга хэмжээ авч ажиллаагүйг харуулж байна.

2.20 Дээрх судалгаанаас харахад агаарын бохирдлыг бууруулахын тулд сайжруулсан зуухыг нийлүүлсээр байхад нийслэл дэх ердийн галлагаатай зуухны тоо жилээс жилд нэмэгдэн 2017 оны жилийн эцсийн байдлаар 100,730 болж, 2014 оноос 24,511 буюу 32.1 хувиар өссөн нь зуух нийлүүлэх талаарх арга хэмжээ үр дүнтэй болсон эсэх нь эргэлзээтэй, энэ ажлын үр дүнг үнэлж, тодорхойлсон баримт материал аудитын явцад олдоогүй болно.

2.21 ДБ-ны “Улаанбаатар цэвэр агаар” төслийн чанарын хяналтын багаас төслийн хүрээнд нийлүүлсэн 40,813 ширхэг зуухны ашиглалтад 2015 онд хийсэн хяналтын тооллогоор 672 айл өрх зуухаа ашиглаагүй байсан байна.

2.22 Сайжруулсан зуух тараах үед хийгдэж байсан лабораторийн туршилтаар зуухнаас ялгарч буй нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)-ыг 30 хувиар буурч, галлагааны зааврыг дагаж мөрдсөнөөр өвлийн улиралд хоногт зарцуулах нүүрсний хэрэглээг 17 хувиар бууруулж байна гэсэн дүгнэлт өгч байжээ.

2.23 2011-2013 онд сайжруулсан зуух нэвтрүүлсэн үед буюу зуухны баталгаат 2 жилийн хугацаанд сайжруулсан зуухны ашиглалт сайн байсан боловч өнөөдрийн байдлаар ашиглалтын хугацаа дууссан, түүхий нүүрс байнга түлснээс шалтгаалан ихэнх зуух ашиглалтгүй болсон, энгийн зуухтай ижил үүрэг гүйцэтгэж, зуухны болон сэлбэгийн үнэ өндөр байгаагаас иргэд төдийлөн сайжруулсан зуух хэрэглэх боломжгүйд хүрсэн байна. Тухайлбал, өнөөдрийн байдлаар Дөл зуухны том хэмжээтэй нь 598,500 төгрөг, жижиг хэмжээтэй нь 498,500 төгрөгөөр борлуулагдаж байна.

2.24 Аудитын явцад ШУТИС-ийн харьяа ДТҮЭХ-ийн зуух туршилтын лабораториор СБД-ийн дугаар хорооны иргэний 2011 оноос ашигласан “Өлзий” зууханд ашиглалтын технологийн сорил хийхэд зөвшөөрөгдөх агууламж стандарт үзүүлэлтийг хангахгүй байгаа нь сайжруулсан зуухыг хэрэглээний горимын дагуу ашиглаагүй, ашиглалтын горимд нийцсэн түлш хэрэглээгүй, ашиглалтын хугацаа дууссантай холбоотой байна.

2.25 Нийслэлийн БЗД, БГД, ЧД, СХД-ийн гэр хорооллын зарим хороо, хэсгийн айл өрхийн ашиглаж байгаа зуухны хэрэглээнд ажиглалт хийж үзэхэд зуухны төрөл, ашиглалт, хэрэгцээ харилцан адилгүй түвшинд байна.

Сайжруулсан зуухны хэрэглээний ерөнхий байдал:



Уламжлалт зуух:



2.26 БГД-ийн дугаар хорооны хэсгийн зарим айл өрх ханан пийшингийн “Дөл” зуухыг 5 жил ашиглаж байгаа боловч тортог ихтэй, халалт удаан, өвлийн улиралд ердийн хэрэглээний өртгөөс илүү хэмжээний түлш хэрэглэдэг, сайжруулсан зуухны сэлбэг хэрэгслийн нийлүүлэх цэг ойр бус, зарим тохиолдолд үнэ ихтэй байгаа зэрэг шалтгааны улмаас ашиглалт муу байгаад иргэд шүүмжлэлтэй хандаж байна.



Сайжруулсан зуухны хэрэглээний ерөнхий байдал:



Горимыг өөрчилсөн байдал:



2.27 Сайжруулсан зуух нийлүүлэгдсэн буюу агаарын бохирдол ихтэй 1 дүгээр бүсийн 3 дүүрэг, 7 хорооны нутаг дэвсгэрт суурьшил бүхий 300 гаруй айл өрхөөс аудитын явцад авсан санал, асуулгын дүнгээс үзэхэд сайжруулсан зуух халаалтаа сайн барьдаг учраас түлшний зардал хэмнэгдэн өрхийн зарцуулалтад хэмнэлт гарч байгаа боловч сайжруулсан түлшний нийлүүлэлт хангалтгүй, зарим тохиолдолд түлшний чанар муу, үнэ өндөр, сайжруулсан зууханд түүхий нүүрс түлэхэд зуухны ашиглалтад сөргөөр нөлөөлсөн байна.

Сайжруулсан түлшний нийлүүлэлтийн талаар

2.28 НАЧА-аас тооцсон судалгаагаар 2011 оны байдлаар нийслэлийн гэр хорооллын 184.0 мянган айл өрхийн түүхий нүүрсний жилийн хэрэглээг ойролцоогоор 736.0 мянган тонн /1 өрх дунджаар 4 орчим тонн нүүрс хэрэглэдэг/ гэж үзэн сайжруулсан түлшээр хангахад 552.0 мянган тонн түлш шаардлагатай гэжээ.

2.29 Уг судалгаанд үндэслэн “ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн байгуулах үйлдвэр 210 мянган тонн хагас коксжсон түлшийг үйлдвэрлэж, үлдсэн хэрэгцээг түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага хангахаар шийдвэрлэсэн байна.

2.30 НАББҮХ-ны 2011 оны 11/04 дүгээр тогтоолоор баталсан “Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам”-ын дагуу НЗДТГ, ЦАС, түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд хамтран гурван талт гэрээ байгуулжээ.

2.31 Гэвч НЗДТГ, ЦАС-аас 14 түлш үйлдвэрлэгч ААНБ-уудтай түлш нийлүүлэх гэрээ байгуулахдаа бэлтгэн нийлүүлэгчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, өмнө нь үйлдвэрлэж байсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, ажлын туршлага зэргийг харгалзалгүйгээр түлш нийлүүлэх гэрээг байгуулсан бөгөөд гэрээгээр 2011-2012 онд 51.7 мянга, 2012-2013 онд 18.9 мянган тонн нийлүүлэхээс гүйцэтгэлээр 2011-2012 онд 7.8 мянга, 2012-2013 онд 8.0 мянган тонныг тус тус нийлүүлжээ.

2.32 ЦАС-аас 2011-2014 онд сайжруулсан түлшний үнийн зөрүүд олгосон санхүүжилт болон тээвэрлэлт, агуулахын зардалд нийт 5.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2.33 “Боловсруулсан түлш нийлүүлэх, түүнийг санхүүжүүлэх тухай” гэрээг доорх нэр бүхий компаниудтай 2011-2013 оны халаалтын улиралд байгуулсан боловч гэрээт байгууллагууд хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна. Тухайлбал,

Хүснэгт 5. Түлш үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн байдал, (тонн)

Д/д	Үйлдвэрлэгчдийн нэрс	Түлшний төрөл	Түлшний тоо хэмжээ	
			нийлүүлэх	нийлүүлсэн
1	“Ворм энерги” ХХК	Үртсэн шахмал түлш	800.0	80.0
2	“Дулаан-Агаар” ХХК		1,200	-
3	“Голден блейз” ХХК		1,000	240.5
4	“Хайрхан буянт” ХХК		2,420	1,250.7
5	“Үртсэн шахмал түлшний үйлдвэр” НӨҮГ		7,500	3,942.6



6	"Тара" ХХК		1,460	1,319.0
7	"Тэнотэ" ХХК		2,200	220.9
8	"МННБД" ХХК		400.0	377.7
9	"Хүслэн-Өлзий" ХХК		700.0	551.9
10	"Өлзийт төв" ХХК		1,200	233.8
11	"Монголын тосгоны хөгжлийн санаачилга" сан		1,200	0
12	"Шарын гол энерго" ХХК	Хагас коксон шахмал түлш	20,000	1,684.0
13	"Монголын Алт" (МАК) ХХК	Бүхэллэг хагас коксон түлш	19,500	5,825.4
14	"Нако түлш" ХК		11,000	55.3
Нийт		-	70,580.0	15,781.8

Эх сурвалж: НАББГ.

2.34 Түлш нийлүүлэгчид 15,781.8 тонн түлш нийлүүлж, гэрээний үүргээ 77.6 хувиар биелүүлээгүй байхад гэрээний 4.8¹⁸-д заасны дагуу гэрээг дүгнэж, хариуцлага тооцоогүй байна.

2.35 Гэрээт үйлдвэрүүдийн түлшийг хүлээн авч, нөөцлөх зорилгоор НАЧА-аас "Бөөний худалдаа" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу тус компанийн агуулахад түлш хадгалахаар 1 сарын түрээсийг 1.2 сая төгрөгөөр тооцож, 2011 онд 4.2 сая, 2012 онд 18.0 сая, 2013 онд 12.6 сая, нийт түрээсийн зардалд 34.8 сая төгрөгийг ЦАС-аас зарцуулсан нь түлш нийлүүлэгч компаниудтай 2011 оны 5 дугаар сарын 17-нд байгуулсан "Боловсруулсан түлшний нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан түлш нийлүүлэх, түүнийг урьдчилан худалдан авах гэрээ"-ний 2.2-т *"стандартын шаардлага хангасан боловсруулсан түлш нөөцлөх агуулахыг НАЧА-аас санхүүжүүлэх ..."* гэж заасныг зөрчсөн байна.

2.36 "ДЦС-2" ТӨҮГ-ыг түшиглэн 210 мянган тонн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах ТАХ-г гүйцэтгүүлэхээр ЭБЭХЯ-аас 2010 онд зарласан сонгон шалгаруулалтад "Аморе интернэшнл" ХХК, ОХУ-ын "Сибтермо" ХХК-ийн түншлэл шалгарч ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.16-д заасан *"Түлхүүр гардуулах нөхцөл"*-өөр 16.8 тэрбум төгрөгөөр 2010 оны 7 дугаар сарын 14-ны өдрөөс 2012 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэхээр 10/56 дугаар гэрээг 2010 оны 7 дугаар сарын 9-нд байгуулж, улсын төсвөөс 14.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.37 Дээрх ТАХ-ний хүрээнд "ДЦС-2" ТӨҮГ-ын БКЗ-75-39 МФ маркийн эрчим хүчний зуухыг эрчим хүчний төхөөрөмж болгон өөрчилж, туршилтын галлагааг хийх үед нүүрсний фракцаас шалтгаалан нэмэлт тохируулга, өөрчлөлт хийх шаардлага үүссэнээс ТАХ гэрээнд заасан хугацаанд хийгдэж дуусаагүй, удааширч улмаар 2014 оны 9 дүгээр сард улсын комиссын актаар шахмал түлшний цех, агуулах, шингэн түлшний үйлдвэрийн барилгыг ашиглалтад хүлээн авсан боловч тус үйлдвэрийн үндсэн түүхий эдэд орох нүүрсний чанар үйлдвэрийн технологитой таарахгүйгээс төслийн ажил зогсож, бүрэн хэрэгжээгүй байна. (Зураг 2-ийг үзнэ үү)

Зураг 2. Хагас коксжсон түлш үйлдвэрлэх болон шингэн түлшний үйлдвэрийн ерөнхий байдал



2.38 "ДЦС-2" ТӨХК-аас 2016 онд ЭХЯ-д үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах тухай албан бичгээр хандаж байсан боловч санхүүжилтийг шийдээгүйн улмаас үйлдвэрлэл явуулаагүй, харин 2018 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн "ДЦС-2" ТӨХК нь "Таван толгой түлш" ХХК-

¹⁸ гэрээний 4.8-д *"... гэрээнд заасан хэмжээнээс дутсан, эсхүл хуваарьт хугацаанаас хоцорч нийлүүлсэн гэдгийг захиалагч нотолсон тохиолдолд нийлүүлэгч тал гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.03 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө. Сарын гүйцэтгэлийн хугацаа хэтэрсэн хоногийг дараа сарын 01-ний өдрөөс эхлэн тоолно. Алдангийг дараагийн сард нийлүүлсэн түлшний үнийн дүнгээс суутган тооцно"*



тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан тус үйлдвэрт туршилтын журмаар үйлдвэрлэл явуулж эхэлсэн байна.

2.39 “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” НӨҮГ-ыг НЗД /Г.Мөнхбаяр/-ын 2009 оны 320 дугаар захирамжаар Булган аймгийн Хангал сумын Хялганат багт байгуулсан боловч уг үйлдвэрийг байгуулах ТЭЗҮ эцэслэн боловсруулагдаагүй, туршилт хийгдээгүй, үйлдвэрлэлийн бодит хүчин чадал 3,240 тонн түлш үйлдвэрлэхээр байхад 12,500 тонноор тооцсон байна.

2.40 Дээрх үйлдвэрийг байгуулахад 1,552.8 сая, үйлдвэрлэлийг өргөжүүлэх, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах зардалд 802.9 сая, түүхий эдийн нөөц нэмэгдүүлэхэд шаардагдах техникийн шинэчлэлт хийх зардалд 183.4 сая, нийт 2,539.1 сая төгрөгийг нийслэлийн төсвөөс зарцуулсан нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээтэй харьцуулж үзэхэд эдийн засгийн үр ашиг багатай байна.

Уг үйлдвэр нь 2011-2016 онд нийт 7,491.7 тонн үртсэн шахмал түлш үйлдвэрлэн бүтээгдэхүүнээ нийслэлийн 26 борлуулалтын цэгээр дамжуулан борлуулсан ба 2,326.1 сая төгрөгийн түлшний үнийн зөрүүний дэмжлэгийг нийслэлийн төсөв болон ЦАС-аас авсан ч одоогийн байдлаар бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй байна.

2.41 Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангахаар НЗД-ын үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан орлогч /Д.Ганболд/, ЦАС-ийн гүйцэтгэх захирал /Н.Хүрэлсүх/ нар 2012 оны 6 дугаар сарын 18-ны өдрөөс 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 680 тонн үртсэн шахмал түлш /1 тонн нь 150.0 мянган төгрөг/-ийг 102.0 сая төгрөгөөр худалдан авахаар “Тара” ХХК-тай 2012 оны 6 дугаар сарын 18-нд 12/06 дугаар гэрээг байгуулсан байна.

2.42 Тус компани гэрээний дагуу нийлүүлэх ёстой дүнгээс 141.5 тонн үртсэн шахмал түлш дутуу нийлүүлсэн байхад ЦАС-аас 2012 оны 8 дугаар сараас 2013 оны 2 дугаар сарын хооронд гэрээний үнийн дүнгээс 1,342.8 сая төгрөгөөр илүү буюу 1,444.8 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Тус компанитай холбоотой асуудлууд хууль, хяналтын байгууллагаар шалгагдаж байна.

Гэрийн дулаалгын талаар

2.43 Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн монгол гэрийн дулаалгыг сайжруулснаар түлш бага зарцуулж, улмаар агаарын бохирдлыг бууруулахад тодорхой хэмжээний хувь нэмэр оруулна гэж үзээд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 2005-2006 онд нийслэлийн 400 айл өрхөд гэрийн дулаалга нийлүүлж, үр дүнг туршилтаар хэмжиж байжээ.

2.44 НАББҮХ-ны 2012 оны 12/15 дугаар тогтоол¹⁹-ын дагуу ЦАС-ийн гүйцэтгэх захирал /Н.Хүрэлсүх/, НЗД-ын орлогч /Д.Ганболд/, Хас банкны Иргэдийн банкны газрын захирал /С.Мөнхболд/ нар 16 нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй нийт 3.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 8,565 ширхэг гэрийн дулаалгын иж бүрдэл ханган нийлүүлэх гэрээг байгуулж, ХУД, ЧД, СХД, БГД, СБД-ээс ирүүлсэн судалгааг үндэслэн нийт 9,049 айл өрхөд гэрийн дулаалгын иж бүрдлийг нийлүүлсэн байна.

2.45 Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд гэрийн дулаалгын иж бүрдлийг борлуулсан дараах 16 аж ахуйн нэгж, байгууллагад ЦАС-аас нийт 3.0 тэрбум төгрөгийн үнийн зөрүүг олгожээ. Үүнд:

Хүснэгт 6. Гэрийн дулаалгын нийлүүлсэн тоо хэмжээ, ЦАС-аас олгосон санхүүжилт

д/д	Аж ахуйн нэр	Нийлүүлсэн гэрийн дулаалга /тоо/			Олгосон санхүүжилт /мян.төг/		
		4 ханатай	5 ханатай	Нийт	4 ханатай /330.0/	5 ханатай /350.0/	Бүгд
1	Өнө монгол гэр ХХК	10	617	627	3,300.0	215,950.0	219,250.0
2	Мөнх хүрэл зос ХХК	20	1,061	1,081	6,600.0	371,350.0	377,950.0

¹⁹ МСС-ийн “Цэвэр агаар” төслөөс нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр нийлүүлж буй стандартын шаардлага хангаасан 8,500 ширхэг гэрийн дулаалгад 3.0 тэрбум төгрөгийн татаасыг ЦАС-аас олгохыг БОАЖЯ-ны сайд, ЦАС-ийн Удирдах зөвлөлийн дарга Л.Гансүхд үүрэг болгосон.



3	Богд өргөө ХХК	8	31	39	2,640.0	10,850.0	13,490.0
4	Дөрвөлжийн бэл ХХК	3	723	726	990.0	253,050.0	254,040.0
5	Сэлбэ дулаан ХХК	34	752	786	11,220.0	263,200.0	274,420.0
6	Дорнын зам ХХК	15	410	425	4,950.0	143,500.0	148,450.0
7	Сувдан цагаан ХХК	123	602	725	40,590.0	210,700.0	251,290.0
8	Мон форте ХХК	23	243	266	7,590.0	85,050.0	92,640.0
9	Вийнвүүд ХХК	45	207	252	14,850.0	72,450.0	87,300.0
10	Моголноос ХХК	63	1,052	1,115	20,790.0	368,200.0	388,990.0
11	Азийн бамбар ХХК	45	265	310	14,850.0	92,750.0	107,600.0
12	Босоо загал ХХК	43	877	920	14,190.0	306,950.0	321,140.0
13	Ундрах дөхөм ХХК	37	599	636	12,210.0	209,650.0	221,860.0
14	Замбалгарамын гомёо ХХК	19	110	129	6,270.0	38,500.0	44,770.0
15	Урал инженеринг ХХК	-	493	493	-	195,300.0	195,300.0
16	Нэхээсгүй эдлэл	1	34	35	330.0	11,900.0	12,230.0
Нийт		489	8,076	8,565	161,370.0	2,826,600.0	3,010,720.0

Эх сурвалж: YAG-ын архив

2.46 Нийслэлийн гэр хорооллын айл өрхөд борлуулсан гэрийн дулаалгын иж бүрдлийн үнийн дүнгийн 23.6-27.4 хувийг хэрэглэгч төлсөн байна. Үүнд:

Хүснэгт 7. Гэрийн дулаалгын иж бүрдлийн үнэ (төгрөг)

Гэрийн дулаалгын иж бүрдлийн үнэ							
5 ханатай				4 ханатай			
Зах зээлийн үнэ	МСС-ийн Цэвэр агаар төсөл	ЦАС	Хэрэглэгчийн төлөх үнэ	Зах зээлийн үнэ	МСС-ийн Цэвэр агаар төсөл	ЦАС	Хэрэглэгчийн төлөх үнэ
1,240,000	550,000	350,000	340,000	1,120,000	526,000	330,000	264,000

Эх сурвалж: YAG-ын архив

2.47 МСС-ийн “Цэвэр агаар” төсөл, ЦАС-ийн санхүүжилтээр нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд 2010-2013 онд хөнгөлөлттэй үнээр нийт 19,850 гэрийн дулаалга борлуулсан гэсэн мэдээллийг дүүргүүдээс аудитын явцад ирүүлсэн “ХУД-ийн 394 өрх, СБД-ийн 2042 өрх, ЧД-ийн 5,896 өрхөд борлуулсан, БЗД, БГД, СХД-т борлуулаагүй” мэдээлэлтэй тулгахад зөрүүтэй байна.

2.48 “Урал инженер” ХХК-тай байгуулсан 2012 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/12 дугаар гэрээний 172.5 сая төгрөгийг санхүүжүүлэх байсан боловч 22.7 сая төгрөгийг илүү олгосон нь ЗГТСТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.4²⁰, ЦАС-ийн дүрмийн 6.1²¹ дэх заалтыг зөрчсөн байна. Тус компани болон ЦАС татан буугдсан учраас хохирлыг төлүүлэх боломжгүй байгаа тул аудитаар хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Цахилгааны үнийн хөнгөлөлтийн талаар

2.49 Агаарын тухай хуулийн 6.1.6-д заасныг үндэслэн ЗГ-ын 2011 оны 309, 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн гэр хорооллын өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”²²-ын дагуу 2012-2017 онд “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нийслэлийн гэр хорооллын 2 тарифт тоолууртай 2,535,739 хэрэглэгчдэд /давхардсан тоогоор/ хүйтний улиралд орой, шөнийн цагаар хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнэнд нийт 14.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн ба²³ харин 2016 онд хөнгөлөлт үзүүлээгүй байна.

Хүснэгт 8. Нийслэлийн гэр хорооллын айл өрхөд үзүүлсэн цахилгааны үнийн хөнгөлөлт

№	Он	Хэрэглэгчийн тоо	Хууль, эрх зүйн үндэслэл	Үзүүлсэн хөнгөлөлт /сая төгрөг/
---	----	------------------	--------------------------	---------------------------------

²⁰ “ТЕЗ нь ЗГ-ын нөөц сангийн санхүүжилтээр тухайн салбарт хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина”

²¹ “Сан нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээ тогтоосон хугацаанд нь дүгнэж, төслийн үр дүн, тайланг хүлээн авсны дараа удирдлагын зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн тухайн төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааг дуусгавар болгон санхүүжилтийн эцсийн тооцоог хийнэ”

²² нийслэлийн ... гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээ болон халаалтын зориулалтаар хүйтний улиралд оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цагийн хооронд хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувиар бууруулж, хөнгөлөлт үзүүлэх

²³ энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан, агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд үзүүлэх цахилгаан эрчим хүчний үнийн урамшууллын хэлбэр, хувь хэмжээг тогтоох, урамшууллыг улсын төсвөөс санхүүжүүлэх;



1	2012	200,569	ЗГ-ын 2011 оны 309 дүгээр тогтоол	961.6
2	2013	472,183	ЗГ-ын 2011 оны 309 дүгээр тогтоол	2,428.5
3	2014	721,093	ЗГ-ын 2011 оны 309 дүгээр тогтоол	3,834.9
4	2015	90,346	ЗГ-ын 2011 оны 309 дүгээр тогтоол	719.4
5	2017	1,051,548	ЗГ-ын 2017 оны 199 дүгээр тогтоол	6,084.1
Дүн		2,535,739		14,028.5

Эх сурвалж: УБЦТС ТӨХК

2.50 Орон нутагт ЭХЗХ-ны 2015 оны “Тарифын хөнгөлөлт үзүүлэх тухай” 293 дугаар тогтоолоор төвийн бүсийн 15 аймгийн нэгдсэн сүлжээнд холбогдсон 2 тарифт тоолууртай гэр хорооллын 120 мянга орчим хэрэглэгчдийн 2015 оны 12 сар, 2016 оны 1, 2, 3 дугаар саруудад хэрэглэсэн цахилгааны тарифын 50 хувь буюу 3.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

Нам даралтын зуух болон эрчим хүчний цахилгаан станцуудад авсан арга хэмжээний талаар

2.51 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд зарим нам даралтын зуухнуудыг татан буулгах, төвлөрсөн дулааны шугамд холбох ажилд 2011-2013 онд ЦАС-ийн төсөвт нийт 15,098.6 сая төгрөг баталж, 8 ТАХ-нд 13,745.4 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Хүснэгт 9. Төвлөрсөн дулаан хангамжид холбосон нам даралтын зуухны судалгаа (сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гэрээний үнийн дүн	Санхүүжилт	Гүйцэтгэгчийн нэр
1	Цагаан даваа орчмын халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажил	2,300.0	2,299.8	2,290.3	"НАБСАН" ХХК
2	Цагдаагийн академи УБ-15 орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажил	3,500.0	3,144.0	2,986.8	"НАБСАН" ХХК
3	Дэнжийн 1000 орчмыг төвлөрсөн дулаан хангамжид холбох 2 дугаар ээлжийн ажил	2,000.0	1,934.0	1,934.0	"Хүрд" ХК
4	Дэнжийн 1000 орчмыг төвлөрсөн дулаан хангамжид холбох эхний ээлжийн ажил	1,687.1	1,425.3	1,425.3	"Хүрд" ХК
5	УБ хотын захын хорооллын нам даралтын зуухнуудыг татан буулгаж, төвлөрсөн дулаанд холбох /Зэвсэгт хүчний 015, 310 дугаар ангиуд/	2,322.4	1,965.5	1,831.0	Сан ХХК, Эн Ар Жи Эм ХХК-ийн түншлэл, "Жаргал констракшн" ХХК, "Нягт холбоос" ХХК
6	Шувуун фабрикт дахин төлөвлөлтийн дагуу одоо ажиллаж байгаа халаалтын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэн технологийн дагуу шинэчлэлтийг хийж, тухайн хэрэглэгчдийн инженерийн шугам сүлжээнд холбох	1,884.3	1,884.3	1,884.3	Хасу мегаватт ХХК, Эн Ар Жи Эм ХХК-ийн түншлэл
7	Дэнжийн 1000-ын цахилгааны шугамыг чөлөөлөх ажил	494.8	494.8	486.4	"Хүрд" ХК
8	УБ хотын нам даралтын зуухнуудыг шинэчлэх	910.0	910.0	907.3	"МонКитурами" ХХК
Нийт		15,098.6	14,057.7	13,745.4	

Эх сурвалж: YAG-ын архив

2.52 Дээрх ТАХ нь нам даралтын зуухаар халдаг байсан барилга, объектууд халаалтын улиралд их хэмжээний нүүрс түлж, орчны бохирдлыг үүсгэх хорт бодисын хэмжээг багасгахад үр нөлөө үзүүлжээ.

Уур-усны дулаан солилцуулагч
бүхий дулааны дэд станц



2.53 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “ДЦС-4” ТӨХК-д 2012-2014 онд хэрэгжүүлсэн зарим төсөл зохих үр нөлөө үзүүлсэн ба тухайлбал, “Уур-усны дулаан солилцуулагч бүхий дулааны дэд станц шинээр барих” 10.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий төсөл хэрэгжсэнээр дулаан хангамжийн үндсэн сүлжээтэй зэрэгцээ ажиллаж, аль ч улиралд станц дулаанжуулалтын ашигтай горимоор ажиллах, дулааны хүчин чадлаа бүрэн ашиглах, үндсэн сүлжээ болон дулааны дэд станцаас түгээгдэх дулааны ачааллыг сэлгэх боломжтой болж ашиглалтыг сайжруулснаар турбины ажиллагааг дээшлүүлэх нөхцөл бүрдсэн байна.



Сүлжээний өргөлтийн 1-р насос



2.54 2012 онд “Сүлжээний өргөтгөлийн 1 дүгээр насосуудыг “0” түвшинд шилжүүлэх” 1.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий төсөл /гүйцэтгэгч “Альянс-Тех” ХХК/ арга хэмжээний хүрээнд дулааны шугам сүлжээний гидравлик горимыг сайжруулахын тулд сүлжээний өргөлтийн 1 дүгээр насосуудыг коллектор станцын дэргэд зөөж, “0” тэмдэгтэд шилжүүлэх ажил хийгдсэнээр буцах усны даралт 0.4 атагаар, мөн нэмэлт усны хэрэглээ жилд 307,600 тонноор буурч,

усны коллекторуудын нэвтрүүлэх чадвар 12,000 м³/цаг-аар нэмэгдэж, 5,400 айл өрхийг дулаанаар хангах шинэ эх үүсвэрийг бүрдүүлж дулаанаар хангаж байна.

2.55 “ДЦС-4” ТӨХК-ийн үндсэн тоноглолоор БКЗ-420-140-10С маркийн 8 зуухны шаталтын бүтээгдэхүүн болох үнс шааргийг тээвэрлэх систем нь ус ашиглан 3 км-ийн зайд үнсэн санд хуримтлуулахаар шийдэгдсэн байсныг “Зуухны гаргах утаа, үнсийг үлэмж хэмжээгээр бууруулах технологи нэвтрүүлэх” 10.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий төслийг “МЭЗ” ХХК 2012-2014 онд хэрэгжүүлсэн байна.

Үнс шааргийг хуурайгаар зайлуулах зүүх



2.56 Төслийн хүрээнд 8 дугаар зуухны галын хотлын үнс шааргийг хуурайгаар зайлуулах Итали улсын “МАС” техник технологийг нэвтрүүлснээр механик дутуу шаталтаас үүсэх болон шаарагтай алдах дулааныг бууруулж жилд 2,100 тонн нүүрсийг эргүүлэн ашиглаж, агаарт хаягдах утааны хэмжээ болон хорт хийн хэмжээ буурсан, жилд 39,660 тонн үнс шааргийг үнсэн санд хаяхгүйгээр хуурайгаар барилгын материалд ашиглах боломжтой болсон, усны хэрэглээ 18 тонн/цагаар буурсан байна.

Авто тээврийн хэрэгслийн утааны ялгаруулалтыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

2.57 Агаарын бохирдлын 10 орчим хувийг эзэлж байгаа авто тээврийн хэрэгслийн утааг бууруулах зорилгоор 9.8 тэрбум төгрөгийг ЦАС-аас санхүүжүүлжээ. Үүнд:

Хүснэгт 10. Авто тээврийн салбарт хэрэгжүүлсэн арга хэмжээ

Д/Д	Хэрэгжүүлсэн арга хэмжээний нэр	Тоо хэмжээ	Хэрэгжүүлсэн он	Зарцуулсан хөрөнгө /сая төг/
1	Нийтийн тээврийн их багтаамжийн 400 автобусыг дизель-хийн хосолмол хэрэглээнд шилжүүлэх	250	2011-2013	3,042.0
2	Авто тээврийн хэрэгслээс ялгарах утааны тортогжилт бууруулах 1500 төхөөрөмж нийлүүлж суурилуулах	1500	2011	495.0
3	Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл 9 автобус угсрах	9	2011-2012	1,799.9
4	Автомашин хийгээр цэнэглэх станц 8 байгуулах	6	2012-2013	1,808.3
5	Авто тээврийн хэрэгслээс ялгарах утааны тортогжилт бууруулах 2510 төхөөрөмж нийлүүлж суурилуулах	1658	2013	747.0
6	Шингэрүүлсэн хийн агуулахын хүчин чадлыг нэмэгдүүлэх	3	2014	1,494.9
6	Тээврийн хэрэгслээс ялгарах утаа хэмжих багаж хэрэгсэл нийлүүлэх	3	2013	408.4
НИЙТ				9,795.5

Эх сурвалж: YAG-ын архив

2.58 Авто тээврийн хэрэгслийн дизель хөдөлгүүрийг шингэрүүлсэн шатдаг хийн нэмэлт төхөөрөмжөөр тоноглох эрх зүйн шийдвэр гараагүй, аюулгүй ажиллагааны стандарт байхгүй, эрх бүхий байгууллагаас хийн баллонт тоног төхөөрөмж угсрах, суурилуулах зөвшөөрөл өгөөгүй, автобус баазуудад хийгээр цэнэглэх станц байгуулаагүй зэрэг бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй байхад нийслэлийн нийтийн тээврийн их багтаамжийн 400 автобусыг дизель-хийн хосолмол түлшний хэрэглээнд шилжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах ажлыг 3.3 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр 2011 оны 9 дүгээр сарын 19-нд ЗТБХБЯ-ны ТНБД /Ж.Бат-Эрдэнэ/, ЦАС-ийн гүйцэтгэх захирал /Н.Хүрэлсүх/ нар ЦАС-УБ-04/2011 дугаар бүхий гэрээг “Туртелком” / ерөнхий захирал С.Мөнхжаргал/ ХХК-тай байгуулжээ.



2.59 Уг ажлыг эхлүүлсэн боловч бэлтгэл ажилд цаг хугацаа алдсан, зарим автобус бааз автобусаа чөлөөлж өгөөгүй, мөн БНСУ-ын “Daewoo Bus Corporation”-аас зөвшөөрөлгүйгээр зориулалтыг өөрчлөх боломжгүй талаар мэдэгдэл ирүүлсэн зэрэг шалтгааны улмаас 150 их багтаамжийн автобусанд төхөөрөмж суурилуулаагүй, тухайн ажил бүрэн хийгдэж дуусаагүй, орхигдсон байна.

2.60 ЗТБХБЯ-ны хэрэгжүүлсэн дээрх ажлын гүйцэтгэгч “Туртелком” ХХК-д ТАХ хийгдэж дуусаагүй байхад 2011 онд ЦАС-аас 3.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд энэхүү асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

2.61 Автомашинаас гарах бохирдлыг бууруулах зорилгоор тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан боловч түүний үр дүн, үр нөлөөг үнэлээгүй, зөвхөн бизнесийн хүрээг дэмжсэн үйл ажиллагаа болжээ. Тухайлбал,

- Нийслэлийн төсвөөр НЗД /Г.Мөнхбаяр/-ын 2011 оны 156 дугаар захирамжийн дагуу “Биоэтанолийн хольцтой “Эко-92” шатахууныг үйлдвэрлэж, авто тээврийн хэрэгслийг хангах” 100.0 сая төгрөгийн гэрээт ажлыг “Оргил ойл” ХХК-тай 2010 оны 5 дугаар сарын 04-нд хийж, “Петровис” ХХК-ийн 8 шатахуун түгээх станцыг хангаж, ажлын гүйцэтгэлийг хүлээлцэх актаар НАЧА 2010 оны 7 дугаар сарын 29-нд хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон;
- “Биодизель түлшний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, нийтийн тээврийн хэрэгслийг биодизель түлшээр хангах” 40.0 сая төгрөгийн гэрээт ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Эн Би Эф” ХХК-тай 2010 оны 2 дугаар сарын 19-нд гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон боловч гүйцэтгэсэн тоо хэмжээ тодорхойгүй,
- ЦАС-ийн хөрөнгөөр 2012 онд “Автомашин хийгээр цэнэглэх 8 станц байгуулах” ТАХ-ний ажлыг 1,890.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Дашваанжил” ХХК /ерөнхий захирал Н.Баатаржав/-тай БОАЖЯ /ТНБД Н.Батсуурь/, ЦАС /гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх/ гурвалсан гэрээг 2012 оны 5 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан ба дээрх компани 6 станцыг барьж ЦАС-аас 1,808.3 сая төгрөгийн санхүүжилт авсан;
- 2014 онд “Шингэрүүлсэн хийн агуулахын хүчин чадлыг нэмэгдүүлэх” ТАХ-ний ажлыг “Дашваанжил” ХХК-тай 499.9 сая төгрөгөөр ЦАС-2014/02-01 дугаартай гэрээ, “Юнигаз” ХХК-тай 495.0 сая төгрөгөөр ЦАС-2014/02-02 дугаартай гэрээ, “Горгаз” ХХК-тай 500.0 сая төгрөгөөр ЦАС-2014/02-03 дугаартай гэрээг тус тус байгуулж, ЦАС-аас нийт 1,494.9 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

2.62 “Эн Би Эф” ХХК-тай 2010 оны 2 дугаар сарын 19-нд “Биодизель түлшний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, нийтийн тээврийн хэрэгслийг биодизель түлшээр хангах” зорилгоор байгуулсан 40.0 сая төгрөгийн санхүүжилттэй ажил гүйцэтгэх гэрээний дагуу тус компани нийтийн 60 гаруй автобусанд биодизель түлш нийлүүлж, “Эрдэм Транс” ХХК-ийн том оврын 30 гаруй автобусыг өөрийн шатахуун түгээх станцаар дамжуулан гэрээгээр ханган ажилласан гэх боловч нийлүүлэлтийн тоо хэмжээний талаарх баримт материалгүй байна.

Гэр хорооллын айл өрхийг орон сууцжуулах хөтөлбөрийн талаар

2.63 Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулах хөтөлбөрүүдэд 2008-2016 онд 317.8 тэрбум төгрөгийг²⁴ зарцуулж, энэ хугацаанд байшин хорооллын²⁵ айл өрхийн тоо 4.7 нэгжээр өссөн байна. 2008-2016 онд байшин хороолол болон гэр хорооллын айл өрхийн тоог харуулбал,



Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар

²⁴ БХБЯ. Аудитын явцад БХБЯ-аас 2008-2016 онд орон сууцжуулалтад хамрагдсан гэр хорооллын өрхийн тоог гаргуулахаар 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 02/1718 дугаар албан бичгээр хандсан боловч энэхүү мэдээллийг маягтын дагуу гаргаж ирүүлээгүй болно.

²⁵ Нийтийн орон сууц + тусдаа тохилог орон сууц



2.64 Байшин хорооллын айл өрхийн тоо сүүлийн 8 жилийн өсөлтийн хурдаа хадгална гэж үзвэл 10 жилийн дараа 5.0 орчим пунктээр буюу ойролцоогоор 72.0 мянган өрхөөр нэмэгдэхээр байгаа бөгөөд 2016 оны жилийн эцсийн байдлаарх нийслэл хот дах гэр хорооллын 216.0 мянган айл өрхийг 97 жилийн дараа бүрэн орон сууцжуулах тооцоолол гарч байна.

2.65 Аудитын явцад ЗГХЭГ-ын 2018 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн Х/765 дугаар албан бичгээр ирүүлсэн “УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн тайланд дурдагдсанаар тус хөтөлбөрийн 4.4.1.4-д “УБ хотын гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх” гэж заасны дагуу нийслэлийн 8 хэсгийн нийт 1777 нэгж талбарт 7524 айлын орон сууц барих төслийн талбарын судалгаа, барилгажилтын зураг төсөл боловсруулан холбогдох байгууллагаар батлуулсан байна.

2.66 Хөтөлбөрийн 4.4.3.4-д “УБ хотын гэр хорооллыг инженерийн дэд бүтэцтэй болгох, гэр хорооллын өрхүүдийг орон сууцанд орох нөхцөлийг бүрдүүлэхдээ хот төлөвлөлтийн судалгаанд үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 32,100-аас доошгүй орон сууцыг ашиглалтад оруулах” гэж заасны дагуу 13 байршлын 50 хэсэгчилсэн талбайд 35 төсөл хэрэгжүүлэгчийг шалгаруулан нийт 9,654 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлж 4,829 айлын орон сууц ашиглалтад оржээ.

2.67 Мөн дээрх хөтөлбөрийн 4.4.3.6-д “УБ хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоо байгаа гэр хорооллын 557,8 га газрыг чөлөөлөх” гэж заасны дагуу НЗД-ын 13 удаагийн захирамжаар 72 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар болон үл хөдлөх хөрөнгийн нөхөн олговорт нийт 3,565.6 сая төгрөгийг олгож, 2.1 га газрыг чөлөөлсөн байна.

2.68 БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл”-ийн хүрээнд нийт 99.8 сая ам.долларын санхүүжилт олгож, УБ хотын СБД-ийн 7 дугаар хороололд “Хангай хотхон”-ы 1,800 айл, БЗД-ийн 14 дүгээр хороололд “Цагаан хуаран хотхон”-ы 792 айлын орон сууцны барилга ашиглалтад орсон ба МҮОНРТ орчмын хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил газар чөлөөлөлтөөс шалтгаалан удааширч бүрэн хэрэгжээгүй, төслийн хэрэгжилт 85 хувьтай байна.

2.69 АХБ, ЕХОБ-ны 320.0 сая долларын хөнгөлөлттэй зээлээр 3 үе шаттайгаар хэрэгжих “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн ТЭЗҮ-г анх боловсруулахдаа газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд нийслэлийн төсвөөс 2.78 сая доллар буюу 6.7 тэрбум төгрөг /одоогийн ханшаар/ зарцуулна гэж тооцоолсон боловч 2018 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 9.3 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 2.6 тэрбум төгрөгийг илүү зарцуулсан байна.

2.70 2016 оны байдлаар Улаанбаатар хотод борлогдоогүй орон сууц 32.7²⁶ мянга, нэгж талбайн дундаж үнэ 2.1 сая төгрөг²⁷ байсан ба нийслэлийн өрхийн сарын дундаж орлого 1,073.1 мянган төгрөг, зарлага 1,035.0 мянган төгрөг²⁸ байгаа нь иргэд орон сууцны зээл авахад орлого хүрэлцэхгүй, санхүүгийн эх үүсвэр хангалтгүйг харуулж байна. Иймээс иргэдийг орон сууцжуулах замаар агаарын бохирдлыг бууруулах арга нь удаан хугацаанд хэрэгжихээр байгаа тул богино хугацаанд хэрэгжүүлэх оновчтой шийдэл биш байна.

2.71 Иймд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаа, арга хэмжээний үр нөлөөт байдлыг үндэслэн гэр хорооллын иргэдийн амьжиргааны түвшин, санхүүгийн эх үүсвэр, дэмжлэгтэй уялдуулан ойрын болон хэтийн төлөвлөгөөг үндэслэн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг үе шаттайгаар, үр дүнг тооцож болохоор, бодлоготойгоор хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.

Агаарын бохирдлыг бууруулах талаар хийсэн судалгааны ажлын талаар

²⁶ “Орон сууцны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа”

²⁷ БХБЯ-ны тайлан. 2016 он

²⁸ Нийслэлийн статистикийн газар 2016 оны байдлаар



2.72 ЦАС, НАЧА бодит практикт нэвтрүүлэх эсэх нь тодорхойгүй дараах ажлуудыг хийлгэж төсвийн хөрөнгийг үргүй зарцуулжээ. Тухайлбал,

- Математикийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад нөлөөллийн үнэлгээ ба прогнозчлолын математик загварчлал”;
- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн гүйцэтгэсэн 29.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “УБ хотын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа, дүгнэлт, агаарын бохирдлыг бууруулах түүнийг ашиглах мастер төлөвлөгөө”;
- ЭМШУИС-ийн гүйцэтгэсэн 143.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хот суурин газрын агаарын бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа”;
- МУИС-ийн Цөмийн судалгааны төвийн 2011 онд гүйцэтгэсэн 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дулааны цахилгаан станцуудын үндсэн сангийн найрлага, агуулалтыг тодорхойлох” судалгаа;
- ШУТИС-ийн ДТҮЭХ-ийн 2011 онд гүйцэтгэсэн 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гидродинамикийн насос ашиглан цахилгаан эрчим хүчийг хамгийн бага хэрэглэж үйлдвэр, олон нийтийн үйлчилгээний барилгыг дулаанаар хангах судалгаа”;
- МУ-ын ШУА, ОХУ-ын ШУА-ын Сибирийн салбартай хамтран 2011 онд гүйцэтгэсэн 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн болон автомашины хаягдлаас хамаарсан агаарын бохирдлын загварчлал”;
- МУ-ын ШУА, ОХУ-ын ШУА-ын Сибирийн салбартай хамтран 2011 онд гүйцэтгэсэн 30.0 сая төгрөгийн өртөгтэй “Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн болон автомашинаас хамаарсан агаарын бохирдлын загварчлал”-ын програм.

2.73 Манай улсын эрдэмтэд, судлаачдын олон жилийн судалгааны дүнд агаар дах хорт хийн агууламж нь цочмог ба архаг бронхит, уушгины үрэвслийн өвчлөлд шууд хамааралтайг тогтоосон бөгөөд агаарын бохирдол нь уушгины хорт хавдар болон өөр олон төрлийн өвчин ихсэх, хүүхэд, 65-аас дээш насны хүмүүсийн дархлаа суларч өвчлөх нэг шалтгаан болж, өвдсөн тохиолдолд түүний үр дагавар зөвхөн тэр хүнээр зогсохгүй цаашид гинжин холбоо бүхий олон сөрөг үр дагаврыг авчирч нийгэмд бүхэлд нь нөлөөлдөг болохыг тогтоожээ²⁹.

2.74 Аудитын явцад эрдэмтэн, судлаачдаас агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ, түүнд шаардагдах хугацааны талаар тодруулахад дараах байдлаар томьёолж байна. Үүнд:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шаардагдах хугацаа
1	Хот төлөвлөлтөөр бүрэн шийдэх	10-30 жил
2	Гэр хорооллын дахин төлөвлөлт, барилгажилт	0-30 жил
3	Гэр хорооллын дахин төлөвлөлт, хэсэгчилсэн дэд бүтэц байгуулах	5-20 жил
4	Яндангийн тоог цөөлөх, цахилгаанаар, сэргээгдэх эрчим хүчээр	5-10 жил
5	Яндангийн тоог цөөлөх, хэсэгчилсэн халаалтаар шийдэх	3-5 жил
6	Зуухнаас гарах бохирдлыг бууруулах, түлшний чанарыг сайжруулах	3-5 жил
7	Зуухнаас гарах бохирдлыг бууруулах, зуухны хийцийг сайжруулах	2-4 жил


Эх сурвалж: Монгол Улсын Шинжлэх Ухааны академи

ЦАС-ийн үйл ажиллагааны талаар

Дүрслэл 6. ЦАС-ийн үйл ажиллагааны зардал /сая.төгрөг/

2.75 ЦАС-ийн үйл ажиллагааны зардалд 2011-2015 онд нийт 932.1 сая төгрөгийг төсвөөс санхүүжүүлснээс 30 орчим хувийг цалин хөлс болон НДШ-ийн зардалд, 20 орчим хувийг зар сурталчилгаа, сургалт, хурал, зөвлөгөөний зардалд, 17 орчим хувийг байрны түрээсийн зардалд, 33 хувийг бусад үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Эх сурвалж: ЦАС-ийн санхүүгийн тайлан, төлөвлөгөө



²⁹ Эх сурвалж: Монгол Улсын Шинжлэх ухааны академи



БҮЛЭГ 3. АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ҮР ДҮН, ТҮҮНД ТАВЬСАН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Ерөнхий мэдээлэл

Нийслэлд агаар бохирдуулагч үндсэн эх үүсвэрүүдэд гэр хорооллын 218,665 айл өрх, гэр хороолол орчмын 3,000 нам даралтын зуухны утаа хамгийн их буюу 80 хувь, 331,564 тээврийн хэрэгслийн утаа 10 хувь, ДЦС-аас гарах утаа 6 хувь, бусад буюу тоос шороо, хог хаягдал, үнс зэргээс шалтгаалсан бохирдол 4 хувийг эзэлж байна.

Зураг 3. Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэр³⁰



МУ-д агаарын бохирдлоос шалтгаалан жилд 4,000 гаруй хүн нас барж, агаарын бохирдол нь харвалт, зүрх, судасны өвчин, уушгины хавдар болон амьсгалын замын өвчний шалтгаан болж байна. Мөн уушгины хатгалгаагаар нас барж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь агаарын бохирдлоос үүдэлтэй бөгөөд 100,000 хүн тутамд ногдох агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын тоо 132 буюу дэлхийн дунджаас 1.4 дахин их байна.³¹

ДЭМБ-аас улс орнуудын тоосонцрын жилийн дундаж үзүүлэлтүүдийг харьцуулж, тэдгээрийн агаарын бохирдлын түвшнийг илэрхийлсээр ирсэн ба МУ-ын хувьд энэ үзүүлэлт 2016 оны байдлаар ДЭМБ-аас зөвлөсөн хэмжээнээс 6-10 дахин өндөр байгааг судалгааны тайланд дурджээ.

Сүүлийн 10 жилд эдгээр хорт бодисуудын агууламж стандартад заасан хэмжээнээс тогтмол өндөр байгаа нь хүн амын дунд халдварт бус өвчлөлийн³² тэргүүлэх шалтгаан болж, 2008 оныг 2016 онтой харьцуулахад 10,000 хүн амд зүрх судасны тогтолцооны өвчин 1.7 дахин, амьсгалын тогтолцооны өвчин 1.6 дахин нэмэгдсэн байна.

Дүрслэл 7. Амьсгалын замын өвчлөл



Дүрслэл 8. Зүрх судасны өвчлөл



Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс эрхлэн гаргасан 2008-2016 оны “Эрүүл мэндийн үзүүлэлт” эмхэтгэл

³⁰ Эх сурвалж: НАББГ-ын 2015 оны судалгаа

³¹ Эх сурвалж: ДБ-ны 2018 оны 2 дугаар сарын 28-нд хийсэн судалгаа

³² амьсгалын замын тогтолцооны болон зүрх судасны архаг өвчин



Агаарын бохирдлын хамрах хүрээ нэмэгдэж агаар дах хорт бодисын агууламж стандартад заасан түвшнээс хэтэрсэн хэвээр байна

3.1 БОАЖС /Л.Гансүх/-ын 2011 оны А-131 дүгээр тушаалаар “Агаар бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг батлан 2014 онд шинэчилсэн ба энэхүү журмын дагуу аймаг, нийслэлд агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах ажил зохион байгуулагдаж, үр дүнг ЦУОШГ нэгтгэж байна.

3.2 Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2010 онд ЦУОШГ-т 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий суурин 5, хөдөлгөөнт 1, нийт 6 автомат станцыг нийлүүлсэн байна.

3.3 Нийслэлийн хэмжээнд 2008 онд агаарын чанарыг хянах суурин 4 харуул байсан бол 2009 оноос хойш гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 11 станц нэмэгдэж, 2016 оны байдлаар ЦУОШГ-ын харьяанд 10, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газрын харьяанд 5, нийт 15 станц, үүнээс автомат ажиллагаатай 12, гар ажиллагаатай 3 станц ажиллаж байна.

3.4 Нийслэлийн агаарын чанарыг 2008 онд зөвхөн хүхрийн давхар исэл (SO₂), азотын давхар исэл (NO₂)-ийн үзүүлэлтээр хэмждэг байсан бол 2010 оноос том ширхэглэгт тоосонцор (PM₁₀), 2011 оноос нарийн ширхэглэгт тоосонцор (PM_{2.5}), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃)-ыг хэмждэг болсон боловч хар тугалга, хром, цайр, зэс, кадми зэрэг хүний биед хамгийн их хорт нөлөө үзүүлдэг хүнд металлыг хэмждэггүй байна.

3.5 Харин хөдөө орон нутагт гар ажиллагаатай суурин 25 станц ажиллаж, орон нутгийн агаарын чанарыг зөвхөн хүхрийн давхар исэл, азотын давхар ислийн үзүүлэлтээр хэмжиж байна.

3.6 Агаарын чанарыг хэмжиж, хянах суурин станцуудад 2016 оноос эвдрэл гэмтэл үе үе гарч, хэвийн бус ажиллагаатай болсноос тоосонцор болон бусад бохирдуулагчдад тогтмол хэмжилт хийх боломжгүйд хүрчээ.

Тухайлбал, нийслэл дэх суурин станцуудын багаж, төхөөрөмжид гэмтэл гарсан үед “Мишээл экспо төв”-ийн гадна байрлах зөөврийн УБ-01 станцаас хэмжигч төхөөрөмжийг авч шилжүүлж байснаас уг станц ашиглах боломжгүй болсон байна.

Зураг 4. “Мишээл экспо төв”-ийн гадна байрлах зөөврийн УБ-01 станц



3.7 Монгол улсын агаарын чанарын стандартад заасан нарийн ширхэглэгт тоосонцрын хүлцэх агууламж ДЭМБ-ын зөвлөсөн хэмжээ болон зарим улсын агаарын чанарын стандартад заасан хэмжээнээс өндөр байна.

3.8 Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 60 дугаар тогтоолоор “Монгол Улсын агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага”³³-ыг баталж, гадаад, дотоод орчны агаар дах хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоосон байна.


3.9 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан хөрөнгө агаарын чанарын үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж байгаа талаар дүн шинжилгээ, үнэлгээ хийж байгаагүй байна. Аудитаар агаарын чанарыг өнөөгийн байдалд хэмжиж байгаа 6 үзүүлэлтээс хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), том ширхэглэгт тоосонцор (PM₁₀), нарийн

³³ MNS4585:2007, тус стандартад 2016 онд өөрчлөлт орж MNS4585:2016 болсон



ширхэглэгт тоосонцор (PM2.5) гэсэн 4 үзүүлэлтийг сонгон авч агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зарцуулсан хөрөнгөтэй харьцуулан үзлээ.

Дүрслэл 9. Агаар дах хорт бодисын агууламж ба зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт




Эх сурвалж: Сангийн яам, Нийслэлийн төрийн сан, ЦУОШГ-ын судалгаа

3.10 Дээрх дүрслэлээс үзэхэд хорт бодисуудын агууламж 2011 онд хамгийн өндөр хэмжээнд хүрч байсан бөгөөд НАББҮХ-г ЕТГ-ын дэргэд байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зарцуулах төсвийг нэмэгдүүлснээр 2012 оноос агаар дах хорт бодисын агууламж хүлцэх хэмжээнээс өндөр байгаа ч “бага” зэрэг буурсан үзүүлэлттэй болсон байна. Харин 2014 оноос АББҮХ-ны харьяалал өөрчлөгдөж, агаарын бохирдлын бууруулах арга хэмжээнд зарцуулах төсөв буурснаас агаар дах хорт бодисын агууламж нэмэгдсэн байна. /Дүрслэл 8-аас харна уу/

3.11 Мөн авто тээврийн хэрэгслийн утааны ялгаруулалтыг бууруулахад болон сайруулсан зуух, түлш, дулаалгад зарцуулсан хөрөнгийн хэмжээ ихэссэн үед агаар дах хорт бодисын агууламж “бага” зэрэг буурч, харин хөрөнгийн хэмжээ буурахад хорт бодисын агууламж өсөх хандлагатай байсан байна. /Дүрслэл 9, 10-аас харна уу/




Дүрслэл 10. Агаар дах хорт агууламж ба авто тээврийн хэрэгслийн утааны ялгаруулалтыг бууруулах чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт



Эх сурвалж: Сангийн яам, Нийслэлийн төрийн сан, ЦУОШГ-ын судалгаа

Тайлбар: Авто тээврийн хэрэгслийн утааны ялгаруулалтыг бууруулах чиглэлээр зарцуулсан хөрөнгийн дүнг нийт зарцуулсан хөрөнгөд эзлэх хувиар тооцсон болно.

Дүрслэл 11. Агаар дах тоосонцрын хэмжээ ба сайжруулсан зуух, түлш, дулаалгад зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт



Эх сурвалж: Сангийн яам, Нийслэлийн төрийн сан, ЦУОШГ-ын судалгаа



3.12 ДЭМБ-аас МУ-ын агаарын бохирдлын талаар 2018 онд хийсэн судалгаагаар³⁴ МУ-ын агаарын чанарын стандартын³⁵ зарим үзүүлэлтүүд нь ДЭМБ-аас гаргасан зөвлөмжтэй³⁶ харьцуулахад доогуур тогтоогдсон байгаа тул агаарын чанарын стандартаа чангатгах зөвлөмжийг өгчээ. Тухайлбал, МУ-ын агаарын чанарын стандартад заасан нарийн ширхэглэгт тоосонцор ДЭМБ-аас зөвлөсөн хэмжээнээс 24 цагийн дундаж 2 дахин, жилийн дундаж хүлцэх агууламж 2.5 дахин доогуур байна.


3.13 Австрали улсын агаарын чанарын стандартад нарийн ширхэглэгт тоосонцрын хүлцэх агууламжийг дэлхийн хэмжээнд хамгийн хатуу буюу өндөр тогтоосон байна³⁷. Харин МУ-ын агаарын чанарын стандартад заасан нарийн ширхэглэгт тоосонцрын 24 цагийн дундаж хүлцэх агууламж Австрали улсын агаарын чанарын стандартаар тогтоосон хэмжээнээс 2 дахин, жилийн дундаж хүлцэх агууламж 3 дахин доогуур байна.

Хүснэгт 11. МУ-ын болон олон улсын нарийн ширхэглэгт тоосонцрын стандарт

Хорт бодисын 24 цагийн дундаж хүлцэх агууламж	Монгол	ДЭМБ	Европын холбоо	Австрали	АНУ	Канад
Нарийн ширхэглэгт тоосонцор	50	25	50	25	65	30

3.14 Нийслэл дэх агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо 2011 оноос жилд дунджаар 7.1 хувиар өсөж, 2016 оны байдлаар 666.8 мянгад хүрч нэмэгдсэн, үүний дотор агаарын бохирдлын 10 орчим хувийг үүсгэгч авто тээврийн хэрэгслийн тоо 458.2 мянгад хүрч 2014 оноос 1.2 дахин өссөн байна.

Дүрслэл 12. Авто тээврийн хэрэгслийн тоо



3.15 Нийслэлийн нийт авто машины 55 хувь нь бензинээр, 25 хувь нь дизель шатахуунаар, 18 хувь нь хосолсон, 2 хувь нь хийгээр ажилладаг байна.

3.16 Нийслэлд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн 60 гаруй хувь нь 10-аас дээш жилийн насжилттай автомашин байгаа нь бохирдолт үүсэхэд нөлөөлж байна.

3.17 2009 онд тээврийн хэрэгсэлтэй холбоотой “Бензин хөдөлгүүртэй автомашин-утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS5014:2009, “Дизель хөдөлгүүртэй автомашин-утааны тортогжилт зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS 5013:2009 стандарт батлагдсан байна.

3.18 ЗЦА, АТҮТ, НЗД-ын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч нарын баталсан удирдамжийн дагуу 2012 оноос эхлэн замын хөдөлгөөнд оролцож буй авто тээврийн хэрэгсэлд хэмжилт, хяналт хийх, стандартаас илүү утаатай тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах ажлыг зохион байгуулж байна.

3.19 Дээрх ажлын хүрээнд түүвэрчилсэн байдлаар нийт 150-700 автомашинд шалгалт хийхэд эдгээрийн 16-50 хувь нь утааны үзүүлэлтээр тэнцээгүй ба стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгсэлд Зөрчлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.7³⁸, 15³⁹ дах заалтын

³⁴ ДЭМБ-аас 2018 оны 2 дугаар сард Монгол Улсын агаарын бохирдолд хийсэн судалгааны ажлын тайлан

³⁵ МУ-ын агаарын чанарын стандартыг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 60 дугаар тогтоолоор баталжээ.

³⁶ ДЭМБ-аас агаарын чанарын үзүүлэлтүүдийн зөвлөмжийг анх 1987 онд гаргаж, 1997, 2005 онд шинэчилсэн байна.

³⁷ Эх сурвалж: Австрали улсын Үндэсний байгаль хамгаалах зөвлөлөөс 1994 онд баталсан “Гадаад орчны агаарын чанарын стандарт”, (Тус стандартыг 2015 онд шинэчилсэн байна)

³⁸ “Ажлын тоормосын систем, жолооны механизм ажиллахгүй, чиргүүлийн холбоос /чиргүүлтэй үед/ эвдэрсэн, эсхүл харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл нь бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”,

³⁹ “Энэ зүйлийн 14 дэх хэсэгт зааснаас бусад ашиглахыг хориглосон бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”




дагуу зөвхөн торгох арга хэмжээ авахаар байгаа нь зөрчил арилахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

3.20 Нийслэлийн агаарын бохирдлын 80 орчим хувийг үүсгэгч гэр хорооллын айл өрхийн тоо 2016 онд 216 мянгад хүрч, 2008 оноос 1.4 дахин нэмэгдэж агаарын бохирдлын хамрах хүрээг нэмэгдүүлсэн байна.

3.21 Агаарын чанарыг сайжруулах бүсийг анх НЗД /Г.Мөнхбаяр/-ын 2008 оны 154 дүгээр захирамжаар, дараа нь БОАЖС, НЗД-ын хамтарсан 5 тушаал, захирамжаар 2011, 2012, 2013, 2015, 2017 онд шинэчлэн тогтоож байсан боловч 2014 болон 2016 онд шинэчлэн тогтоогоогүй нь Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг жил бүр шинэчлэн тогтооно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дүрслэл 13. Гэр хорооллын айл өрхийн тоо (мянга)




3.22 Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсэд 2008 онд анх 6 бүс хамрагдаж байсан бол 2011 онд 3 бүс, 50 хороо, 2013 онд 3 бүс, 108 хороо, 2015 онд 3 бүс, 138 хороо хамрагдсан нь хамрах хүрээ тэлснийг харуулж байна.

3.23 Агаарын тухай хуульд заасны дагуу нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг жил бүр шинэчлэн тогтоож, зөвхөн тухайн бүсүүдэд түүхий нүүрс түлэхийг хориглосон заалттай бөгөөд бусад бүсүүдэд түүхий нүүрсний хэрэглээг хориглоогүй байснаас нийслэлийн хэмжээнд агаар дах хорт бодисын агууламж стандарт заасан хэмжээнээс өндөр байх нэг шалтгаан болжээ.

3.24 ЗГ-ын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-аас бусад иргэн, ААНБ-ыг 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглох шийдвэр гаргасан байна.

Дүрслэл 14. Нийслэлд шилжин ирэгсдийн тоо /2008-2017 он/



3.25 НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-ийн 2017 оны 1 дүгээр сарын 09-ний А/17 дугаар захирамжаар орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн хөдөлгөөнийг 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаанд зогсоох шийдвэр гаргасан ба шийдвэрийн хэрэгжилтээс үзэхэд 2017 оны эцсийн байдлаар буюу 1 жилийн хугацаанд нийслэлд байнга оршин суухаар бүртгүүлсэн иргэдийн тоо өмнөх онтой харьцуулахад 14,861 иргэнээр буурсан байна⁴⁰.

3.26 2008 оноос эхлэн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр уламжлалт зуухны хэрэглээг хумьж сайжруулсан зуухаар хангах, хэд хэдэн нам даралтын зуухнуудыг татан буулгаж, төвлөрсөн дулааны шугамд холбох, боловсруулсан түлшээр хангах зэрэг олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2012 оноос агаар дах хорт бодисын агууламж “**бара**” зэрэг буурсан үзүүлэлттэй байгаа боловч агаарын бохирдлыг бууруулах төрийн бодлого уялдаа холбоогүй, хийгдсэн ажлуудад тавих хяналт хангалтгүй, хариуцлагын тогтолцоо байхгүйгээс агаарын чанарын үзүүлэлт сүүлийн 10 жилийн хугацаанд стандартад заасан хүлцэх түвшнээс тогтмол өндөр, агаарын бохирдол 2016 оноос эхлэн дахин өссөн байна.

3.27 Тухайлбал, агаарын чанарт хэмжилт хийсэн станцуудын 2008-2016 оны мэдээнээс үзвэл хорт бодисын агууламж өвлийн саруудад буюу 11 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд эрс нэмэгдэж стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хүхрийн давхар исэл 6-20 дахин,


⁴⁰ *Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газраас гаргасан тоо мэдээ



азотын давхар исэл 2-13 дахин, нарийн ширхэглэгт тоосонцор 9-26 дахин өндөр байсан ба 2011 онд эдгээр хорт бодисуудын агууламж хамгийн өндөрт хүрч байжээ. Тухайлбал 2011 онд,

- Хүхрийн давхар исэл 20мкг/м³ байхаас 402 мкг/м³,
- Азотын давхар исэл 40 мкг/м³ байхаас 516 мкг/м³,
- Нарийн ширхэглэгт тоосонцор 50 мкг/м³ байхаас 1296 мкг/м³-т болж хэмжигдсэн байна.


Дүрслэл 15. Агаар бохирдуулагч бодисын стандартаас хэтэрсэн хэмжээ



Эх сурвалж: ЦУОШГ

3.28 Агаарын бохирдлын асуудал зөвхөн УБ хотын хувьд гамшгийн хэмжээнд хүрээд байгаа төдийгүй Баянхонгор, Хөвсгөл, Өмнөговь, Орхон, Ховд, Өвөрхангай аймгийн төв агаарын бохирдол ихтэй, бохирдлын үзүүлэлт хүлцэх дээд хэмжээнээс хэтэрсэн байна.

Дүрслэл 16. Аймгуудын агаар бохирдуулагч бодисын стандартаас хэтэрсэн хэмжээ



Эх сурвалж: ЦУОШГ

3.29 Дээрх аймгуудын төвийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхэд ЦАС-аас нийт 706.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн боловч үр дүнг тодорхойлон тайлагнаагүй байна. Тухайлбал,

- Дорнод, Дархан-Уул аймгийн гэр хорооллын айл өрхүүдэд 285 ширхэг сайжруулсан зуух олгох, Баянхонгор, Ховд, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн төвийн нам даралтын зуухыг шинэчлэх, халаалтын зууханд утаа шүүгч төхөөрөмж суурилуулах, шахмал түлшний тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг арга хэмжээг санхүүжүүлжээ.

Агаарын бохирдлын төлбөр ногдуулах хэмжээ өнөөгийн нөхцөл байдалтай уялдахгүй байна

3.30 ЗГТСТХ-ийн 12⁴ дугаар зүйлийн 12⁴.1.1-т “ЦАС-ийн хөрөнгө нь агаарын бохирдлын төлбөр, нөхөн төлбөрөөс бүрдэнэ” гэсэн заалтын дагуу ЦАС-ийн орлогыг бүрдүүлж, түүнээс зарцуулалтыг хийхээр эрх зүйн баримт бичигт заасан боловч улсын төсвөөс санхүүжүүлж ирсэн байна.

3.31 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор БОАЖС /Л.Гансүх/, ЗТБХБС /Х.Баттулга/-ын 2011 оны А/63/67 дугаар хамтарсан тушаал, НИТХТ /дарга Д.Баттулга/-ийн 2015 оны 28 дугаар тогтоолоор баталсан журмаар авто тээврийн хэрэгслийг 6 ангилан шатахууны шаталтаас гарах бохирдлын хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас



хамааруулан 1,800-9,500 төгрөгийн нэг удаагийн төлбөр авахаар тогтоосон нь нөхцөл байдалтай уялдахгүй, агаарын бохирдлыг бууруулахад бодитой нөлөө үзүүлж чадаагүй байна.

Дүрслэл 17. Автомашины тоо ба бохирдлын төлбөрийн харьцаа



3.32 Авто тээврийн техникийн хяналтын төвүүдэд ашиглаж байгаа авто тээврийн хэрэгслээс агаарт ялгарах нүүрс хүчлийн хийг хэмжигч багаж нь бохирдлыг хувиар тооцож байгаа нь Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т “авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс нэгж километр зайд явахад ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээг граммээр тооцож төлбөр тогтооно” гэж заасантай нийцэхгүй, агаарт хаях хорт утааны ялгаралтын хэмжээг бодитой тодорхойлж чадахгүй байна.

3.33 Мөн агаарын бохирдлын төлбөр төлөгчөөр гэр хорооллын айл өрхүүд болон хос тэжээлт⁴¹ автомашин эзэмшигчдийг хамруулахгүй байх талаар эрх зүйн зохицуулалтгүй байгаа нь Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч”, 4.1.6-гийн “агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага агаарын бохирдлын төлбөр төлөгч байна” гэсэн заалттай зөрчилдөж, хэрэгжихгүйд хүргэж байна.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга, хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт дутагдсанаас зөрчил гарч хууль, хяналтын байгууллагаар шалгагдсан байна

3.34 ЦАС-аас 2011-2015 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зарцуулсан 93.4 тэрбум төгрөгийн зарцуулалтад эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт хангалтгүй байснаас ЦАС-ийн нэр бүхий албан тушаалтнууд ихээхэн хэмжээний төсвийн хөрөнгийг хувьдаа ашигласан асуудлаар хууль, хяналтын байгууллагад шалгагдсан байна. Тухайлбал,

- ЦАС-аас түлш нийлүүлэх тухай албан ёсны гэрээ байгуулаагүй “Шарын голын энерги Болд” ХХК-д ажлын гүйцэтгэл, ажил дүгнэсэн баримтгүйгээр 2011 онд 2,260.0 сая, 2012 онд 466.5 сая, бүгд 2,726.5 сая төгрөг;
- Сургалт, семинарын зардал нэрээр “Хорчихуйн булаг” ХХК-д 2012 онд нийт 116.0 сая төгрөг;
- Ажлын хөлс нэрээр “Орхон сайхан булаг” ХХК-д 2012 онд 21.4 сая төгрөг;
- Түлш нийлүүлэх гэрээ нэрээр “Шарын гол дулаан” ХХК-д 2011 онд 240.0 сая төгрөг;
- Монгол патентын зуухны үнэ нэрээр “Анандложистик” ХХК-д 2012 онд 429.7 сая төгрөгийг санхүүжүүлсэнтэй холбоотой.

3.35 НЗД /Г.Мөнхбаяр/-ын 2010 оны 395, 2011 оны 156 дугаар захирамжаар, НЗД /Э.Бат-Үүл/-ын 2012 оны А/411 дүгээр захирамжаар батлагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 964.5 сая төгрөгийн ТАХ-ний гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй 2010-2012 онд НАЧА, НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс гэрээ байгуулсан байна.

3.36 Дээрх ААНБ-аас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 4 ААНБ-ийг шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Үүнд:

⁴¹ цахилгаан болон бензин хосолсон



- “Номгон хайрхан” ХХК-тай байгуулсан “Хязгаарлалтын бүсийн 145 айл өрхөд 79.8 сая төгрөгийн халаалт болон ахуйн хэрэглээний хосолмол цахилгаан зуухыг 2011 оны 10 дугаар сарын 22-ны дотор нийлүүлж, суурилуулах” ажлын 2011 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн АЧА/11/07 дугаартай гэрээ,
- “Их эрин элч” ХХК-тай байгуулсан “Шалны цахилгаан усан халаагуур 370 ширхгийг 489.9 сая төгрөгөөр 2011 оны 11 дүгээр сард бэлтгэн нийлүүлж, суурилуулах” ажлын 2011 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн ЦА-6789 дугаартай гэрээ,
- “Ворм энерги” ХХК-тай байгуулсан “Үртсэн шахмал түлшний тоног төхөөрөмжийг 152.9 сая төгрөгөөр 2013 оны 2 дугаар сарын 15-нд, 1,300 тонн үртсэн шахмал түлшийг 2014 оны 2 дугаар сарын 28-нд нийлүүлэх” ажлын 2012 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн АЧА/12/02/03Б дугаартай гэрээ,
- “Тара” ХХК-тай байгуулсан “Үртсэн шахмал түлшний үйлдвэрийн тоног, төхөөрөмжийг 200.0 сая төгрөгөөр бэлтгэн нийлүүлж, угсарч, суурилуулах, 1,330 тонн үртсэн шахмал түлш нийлүүлэх” ажлын 2012 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн АЧА/12/02/03А дугаартай гэрээ.

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй ажилласан байна

3.37 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байсан байна.⁴² Тухайлбал,

- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрт НЗДТГ дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.
- Гэр хорооллын ядуу өрхүүдийн агаарын бохирдлыг бууруулах төсөлд ЭХЯ, “Цэвэр агаар төсөл”-д СЯ, ЗГХЭГ дотоод хяналт тавьж ажиллаагүй байна.

3.38 Мөн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ТАХ-нд захиалагчийн хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд хяналт тавьж ажиллагаагүй нийтлэг зөрчил аудитын явцад илэрлээ. Тухайлбал,

- Үртсэн шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулж ажлыг комисс хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- БХБЯ-ны /одоогийн нэрээр/ БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл болон улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Орон сууцны хороолол, дэд бүтэц” төслийн хүрээнд СБД-ийн 7-р хороолол, БЗД-ийн 14-р хороололд 2,592 айлын орон сууц барих ажлыг санхүүжүүлэхээр 2012 оны 2 дугаар сарын 07-ны өдөр СЯ-тай 70.5⁴³ сая ам.долларын дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулсан боловч СЯ-аас тус гэрээний мэдээллийг өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, авлагаар бүртгээгүй, зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийг зээлдэгч БХБЯ-тай шинэчлээгүй, БХБЯ эргэн төлөлт хийгээгүй байна.

3.39 YAG-т НЗДТГ-аас 2018 оны 03/1141 дүгээр албан бичгээр “УБЗАА-нд 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 22 арга хэмжээг хэрэгжүүлсэн” гэсэн мэдээллийг ирүүлсэн байхад УБ хотын Ерөнхий менежер бөгөөд ЗАА-ны дарга Т.Гантөмөрөөс 6 дугаар сарын 18-нд “Хариу тайлбар хүргүүлэх тухай” 01/1531 дүгээр албан бичигт “Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй” гэжээ.

3.40 Аудитын явцад УБЗАА болон холбогдох бусад байгууллагаас авсан баримт, материалаас үзэхэд тус албанд 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ТАХ-г хэрэгжүүлсэн нь дараах баримтаар нотлогдож байгаа ба түүнд тавих дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна. Жишээ нь:

- УБЗАА-ны нягтлан бодогч Б.Халиунаас УБЗАА-ны хот тохижилтын урсгал зардлын гүйцэтгэлийн мэдээг 2008-2016 оны байдлаар гаргуулан авч шалгахад 2008 оны төсөвт “Агаарын бохирдол бууруулах ТАХ”-нд 120.0 сая төгрөг төсөвлөж, 41.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан,

⁴² Гадаадын зээл, тусламжийн тухай хууль, /2015 оны 2 сард хүчингүй болсон/, Өрийн удирдлагын тухай хууль, Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “ЗГ-ын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам” 2015 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”, “Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “ЗГ-ын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих ТАХ-г хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

⁴³ БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр 60.0 сая ам.доллар, Улсын төсвөөс 10.5 сая ам.доллар



- УБЗАА-аас 2011 онд 3,048.8 сая төгрөгийн дүнтэй “Гэр хорооллын ахуйн бохироос үүдэлтэй агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын нүхэн жорлонг ариутгаж, шивтрийн хийг бууруулах үйлчилгээтэй бэлдмэл нийлүүлэх” ТАХ-г хэрэгжүүлсэн байна.


3.41 БОАЖС /Л.Гансүх/-ын 2011 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А-181 дүгээр тушаалын дагуу “Гэр хорооллын ахуйн бохироос үүдэлтэй агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын нүхэн жорлонг ариутгаж, шивтрийн хийг бууруулах үйлчилгээтэй бэлдмэл нийлүүлэх” ТАХ-ний захиалагчаар УБЗАА-г томилж, 3,048.8 сая төгрөгийг ЦАС-аас УБЗАА-ны дансанд 2011 оны 6 дугаар сараас 12 дугаар сарын хооронд шилжүүлсэн байна. УБЗАА-аас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахгүйгээр “Ирвэс интертрейд” ХХК-тай 2011 оны 6 дугаар болон 11 дүгээр сард 2 удаа шууд гэрээ байгуулжээ. Гэрээнд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүйгээс ажил гүйцэтгэсэн, хүлээн авсан, хянаж баталсан акт байхгүй байгаа ба ЦАС болон УБЗАА-аас айл өрхүүдэд тараагдсан бэлдмэлийн тоо зөрүүтэй байгаа нь аудитын явцад илэрч байна. Иймд тус компанитай холбоотой асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

3.42 БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлсэн “Орон сууцны хороолол, дэд бүтэц” төслийн хэрэгжилтэд БХБЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2017 онд аудит хийж, дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хэрэгжилт хангалтгүй, эргэн төлөлт хийгдээгүй зөрчлийг илрүүлж, зөвлөмж өгсөн боловч төслийн нэгжийн удирдлага хэрэгжүүлээгүй байгаа нь дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байгааг харуулж байна.

3.43 Сангийн яамнаас 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 12-1/1598 дугаар албан бичгээр YAГ-т ирүүлсэн танилцуулгад “АНУ-ын МСС-ийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2010-2013 онд хэрэгжүүлсэн “Цэвэр агаар төсөл”-ийн хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад 40.4 сая ам.долларыг зарцуулж, үүнээс 20,000 гэрийн дулаалга, 103,000 сайжруулсан зуух, 5,000 гэрийн үүдний амбаар, 99 гэр өгч, агаарын бохирдолд 13 төрлийн судалгаа хийсэн” гэж байгаа боловч энэхүү төслийн баримт материал СЯ, БОАЖЯ, ЗГХЭГ-т байхгүй байгаа нь аудитаар төслийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх боломжгүй болгосон болно.

3.44 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдсэн арга хэмжээг нэгтгэн дүгнэх, хяналт үнэлгээ хийгдэх ажил орхигдсон байна. (Зураг 5-д үзүүлэв)

Зураг 5. АББ чиглэлээр ажил хариуцсан байгууллагуудын хяналтын тогтолцоо



3.45 Гадаадын байгууллага, орнуудаас 2008-2016 онд 153.3 сая ам.долларын нийт 9 ТАХ-г санхүүжүүлснээс 104.7 сая ам.долларын дүнтэй 4 ТАХ зээлийн хөрөнгөөр, 48.6 сая ам.долларын дүнтэй 5 ТАХ буцалтгүй тусламж, техник туслалцааны хөрөнгөөр хэрэгжсэн байна.



3.46 Гадаадын байгууллага, орнуудаас 2008-2016 онд 5.4 сая долларын өртөг бүхий 3 техник туслалцааны төслийг хэрэгжүүлж МУ-ын агаарын бохирдлын байдалд дүн шинжилгээ хийн агаарын бохирдлыг бууруулах бодлого тодорхойлогч болон хэрэгжүүлэгч байгууллагуудын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, агаарын бохирдлыг бууруулах санал зөвлөмжийг боловсруулсан байна.

3.47 2008-2016 онд гадаадын техник туслалцаатай хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд 14 санал, зөвлөмж өгснөөс одоогийн байдлаар хэрэгжүүлэх шатандаа 9, хэрэгжүүлээгүй 5 санал зөвлөмж байгаа ба зарим санал, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд өртөг өндөртэйгөөс шалтгаалан хэрэгжээгүй байна.

3.48 СЯ болон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрт өгсөн санал, зөвлөмжийн биелэлтийг гаргаж, үр дүнг тооцдоггүй байна.

3.49 ДЭМБ-аас 2018 оны 2 дугаар сард МУ-ын агаарын бохирдолд хийсэн судалгааны ажлын тайланд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр урт, дунд, богино хугацаанд анхаарч зохион байгуулах арга хэмжээний талаар зохих зөвлөмжийг ЗГ-ын анхааралд толилуулсан байна.

Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаас хийсэн хяналт шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна

3.50 YAG-аас “Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн”-д 2017 онд хийсэн аудитаар БХБЯ-ны БНХАУ-ын 60.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн ашиглалттай холбоотой албан шаардлагыг өгсөн боловч түүнийг хэрэгжүүлээгүй, зээлийн эргэн төлөлт эргэн төлөлт хийгдээгүйгээс улсын төсвөөс зээлийн хүүгийн төлбөрт 2012-2017 онд 7.3 сая ам.доллар буюу 14.6 тэрбум төгрөгийг төлжээ.


3.51 YAG-аас 2014 онд *“ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн 210.0 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах* төслийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар ОХУ-ын “Сибтермо” ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэж ажлыг дуусгах, албан тушаалтанд хариуцлага тооцох талаар ЭХЯ, УУЯ-нд зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

3.52 YAG-аас УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 12 дугаар тогтоолын дагуу *“Утаагүй түлшний үйлдвэрийн төсвийн зарцуулалт, үр дүн”*-нд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг УУЯ, ЭХЯ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.53 YAG-аас *“ЦАС-ийн 2011-2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт”*-д 2014 онд хийсэн аудитаар *“Нийслэлийн нийтийн тээврийн их багтаамжийн 400 автобусыг дизель-хийн түлшний хосолмол хэрэглээнд шилжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах”* ТАХ-ний гүйцэтгэгч “Туртелком” ХХК-аар ажлыг бүрэн гүйцэтгүүлэх талаар ЗТЯ, Нийслэлийн тээврийн газар, ЦАС-нд албан шаардлагыг өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

3.54 YAG-аас 2014 онд *“ЦАС-ийн 2011-2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт”*-д хийсэн аудитаар *“Авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтын хэмжээг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах”* ТАХ-ний гүйцэтгэгч “Хаш техник” ХХК-аар санхүүжилтийн 90 хувь буюу 747.0 сая төгрөгийг ЦАС-аас шилжүүлэн авсан боловч ажлын ажлыг бүрэн гүйцэтгүүлэх талаар БОНХЯ, БОНХЯ, ЦАС-нд албан шаардлагыг өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

3.55 YAG-аас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2010-2017 онд хийгдсэн ажлуудын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар ТЕЗ-ийн харьяа газар, агентлагуудад илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг холбогдох төрийн байгууллагууд, ажил хариуцсан албан тушаалтнууд тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй, гарсан зөрчлүүд арилаагүй байгаа тул эдгээр зөрчлүүдийг арилгах талаар Ерөнхий сайдад зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

**Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийсэн ажлын үр дүн, үр нөлөөг нээлттэй ил тод тайлагнаагүй байна**

зарцуулалтын гүйцэтгэл, үр ашгийг харуулсан бүтэц, агуулгатайгаар тайлагнаагүй байна.

3.57 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулахын тулд ахиц дэвшлийг үнэлэхийн зэрэгцээ бодлогын зорилтуудын биелэлтийг гаргаж, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг эрэмбэлэн, хүндрэлтэй асуудлаар тодорхой шийдвэр гарган ажиллаагүй байгаа ба энэ талаар хариуцсан эзэнгүй байна.

**ДҮГНЭЛТ:**

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- УБ хотод агаар, орчны бохирдлын хамрах хүрээ нэмэгдэж хорт бодисын агууламж стандарт хэмжээнээс хэтэрснээс иргэдийн эрүүл мэндийн байдалд нөлөөлж байгаа нь МУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т *“Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”* гэсэн баталгаа хангагдахгүйд хүргэж байна.
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 1995 оноос эхлэн гарсан хууль, эрх зүйн шийдвэрүүд нь өөр хоорондоо уялдаа холбоогүйгээс агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг оновчтой зохицуулж чадаагүй байна.
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Үндэсний хороог МУ-ын ЕТГ-ын дэргэд 2 удаа, Ерөнхий сайдын дэргэд 2 удаа, ажлын албыг БОАЖС-ын дэргэд 2 удаа, агаарын бохирдлыг бууруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх, хяналт тавих газар, албыг НЗД-ын дэргэд 3 удаа байгуулж, байнга бүтцийн нэгж солигдож, үйл ажиллагаа нь хангалтгүй зохион байгуулагдсанаас чиг үүргийн давхцал үүсэж, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэн тайлагнах, хяналт тавих, хариуцлага тооцох боломжгүй байдалд хүргэсэн байна.
- Төрийн аудитын байгууллагаас агаарын бохирдлыг бууруулах талаар удаа дараа хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчилтэй асуудлаар холбогдох байгууллага албан тушаалтанд зөвлөмж, албан шаардлага өгч байсан боловч харьяалах ТЕЗ нар хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Нийслэл хотоос гадна аймгийн төвүүдэд агаарын бохирдол ихтэй, бохирдлын үзүүлэлт хүлцэх дээд хэмжээнээс хэтэрсэн нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон эх үүсвэрээр зарцуулахаар төлөвлөсөн арга хэмжээг цогц байдлаар, үе шаттайгаар, нэг удирдлага, хяналтын дор хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.
- МУ-д агаарын чанарыг 6 үзүүлэлтээр хэмждэг боловч хүний биед хамгийн их хор нөлөө үзүүлдэг хүнд металлыг хэмждэггүй, манай улсад агаарын чанарын стандарт болгосон зарим үзүүлэлтийн дээд хязгаар нь олон улсын агаарын чанарын стандартаас зөрүүтэй байна.
- Агаар дах хүнд металлын агууламжийг тодорхойлдог техник, тоног төхөөрөмж байхгүй, агаарын бохирдлыг хэмжигч техник хэрэгслүүдийн ашиглалтын хугацаа дууссан, хүрэлцээ муутай, цөөн байршилд хэмжилт хийж байгаа нь агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг бүрэн хамарч бохирдлын үзүүлэлт бүрэн гүйцэт, үнэн зөв тодорхойлогдож чадахгүйд хүргэж байна.
- Агаарын бохирдлын бууруулах талаар судалгааны ажил хийгдэж байсан боловч түүний үр дүнг үнэлээгүй, хэрэгжүүлэх эсэхийг шийдээгүй орхисон байна.
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2008-2016 онд улсын төсөв, ЦАС-ийн хөрөнгөөр 164.1 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламжаар 153.3 сая ам.долларын ТАХ-үүдийг санхүүжүүлж, хэрэгжүүлсэн боловч гүйцэтгэл, үр дүнг нэгтгэн дүгнээгүй, агаарыг бохирдуулагч эх үүсвэр бүрээр агаарын чанарын үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөллийг гаргаж, хэрэгжүүлэх арга хэмжээний төрлийг тодорхойлоогүй, арга хэмжээ, зарцуулсан хөрөнгийн үр дүнг агаарын чанарын үзүүлэлтийн өөрчлөлттэй харьцуулан үнэлгээ хийгээгүйгээс агаарын бохирдол дорвитой буураагүй, илт мэдрэгдэх үр дүн гараагүй байна.
- СЯ “Орон сууцны хороолол, дэд бүтэц” төслийн дамжуулан зээлийн мэдээллийг өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулаагүй, авлагаар бүртгээгүй, зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийг шинэчлээгүй байгаа нь дамжуулан зээлд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2008 оноос хойш олон эх үүсвэрээр ТАХ-үүдийг хэрэгжүүлж байсан боловч энэ чиглэлийн ажил хариуцдаг нийслэлийн холбогдох



байгууллагууд хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг нэгтгэн дүгнэдэггүй, тоо мэдээг зөрүүтэй гаргадаг, зохих хяналтгүй ажиллаж иржээ.

- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон төрлийн сайжруулсан зуухыг айл өрхийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн үйлдвэрлэх, нийлүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүй, зуухыг хөнгөлөлттэй үнээр айл өрхүүдэд худалдан нийлүүлсэн боловч технологийн дагуу ашиглаагүй, одоогийн байдлаар эдгээр зуух элэгдэлд орж, ердийн зуухтай ижил үүрэг гүйцэтгэх болжээ.
- Сайжруулсан зуухны хэрэгцээ, зориулалтын түлшний нийлүүлэлтэд үндэслэн түлш үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг тооцохгүйгээр гэрээ байгуулсан, “ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн байгуулсан үйлдвэр ажиллаагүйгээс түлшний 22.4 хувийг нийлүүлсэн нь агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөхүйц арга хэмжээ болж чадаагүй байна.
- Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд монгол гэрийн дулааныг алдагдуулахгүй, түлшний зарцуулалтыг багасгахын тулд гэрийн дулаалгыг хөнгөлөлттэй үнээр худалдан нийлүүлсэн боловч энэхүү ажлын үр дүн тодорхойгүй, дулаалгын ашиглалтын хугацааг тогтоогоогүй, зорилтот айл өрхөд нийлүүлэгдэн ашиглагдаж байгаа эсэх талаар бүртгэл судалгаа байхгүй, хяналт тавьж ажиллаагүй байна.
- Нийслэл болон орон нутгийн гэр хорооллын өрхийн орой, шөнийн цагаар хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийг тодорхой хувиар хөнгөлөлт үзүүлсэн боловч энэ нь ердийн зуухны галлагааг багасгаж, агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлсөн нөлөөллийг тооцсон судалгаа, тооцоолол хийгдээгүй байна.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд зарим нам даралтын зуухыг татан буулгаж, төвлөрсөн дулааны шугамд холбосноос өөр утааны хорт ялгаралтыг бууруулах талаар дорвитой ажил хийгдээгүй байна.
- Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн утааны ялгаралтыг бууруулах чиглэлээр төсвөөс 9.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлж, ТАХ-үүдийг хэрэгжүүлсэн боловч зарим арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаагүй, бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүжилтийг гүйцэтгэлийн хувиар тооцож олгоогүй, ТАХ-ний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллаагүй байна.
- УБ хотын гэр хорооллын айл өрхийн тоо 2016 онд 2008 оныхтой харьцуулахад 1.4 дахин өссөн нь агаарын бохирдол нэмэгдэх нэг шалтгаан болсон байна.
- Нийслэлийн гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд зуухны яндангийн тоо цөөрсөн эсэх, хэрэгжүүлсэн арга хэмжээ агаарын бохирдлыг бууруулахад хэрхэн нөлөөлсөн талаар тооцоо судалгаа хийгдээгүй, орон сууцанд хамрагдсан гэр хорооллын айл өрх бодит байдалд орон сууцанд амьдарч буй болон утаа гаргадаг яндангийн тоо буурч буй эсэх талаар судалгаа байхгүй, эдгээрийг зохицуулсан эрх зүйн орчин байхгүй байна.
- Нийслэлийн нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ нь УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны хөтөлбөрт тодорхойлсон хэмжээнээс “**хэт бага**” зөрүүтэй байгаа нь хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилт биелэгдээгүйг харуулж байна.
- Агаарын бохирдлыг бууруулах талаар судалгааны ажилд тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулсан боловч түүний үр дүнг үнэлээгүй, цаашид хэрэгжүүлэх эсэхийг шийдээгүйгээр орхисон, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдсэн эрдэмтдийн судалгааны ажлыг анхаарч үзээгүй байна.
- Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр иргэдэд тэдний оролцоо, үүрэг хариуцлагын талаар таниулан сурталчлах ажлыг хангалттай хийж гүйцэтгээгүйгээс ТАХ-ний хэрэгжилтийн үр дүнд нөлөөлөх нөлөөлөл бага байна.

**ЗӨВЛӨМЖ:**

Аудитын илрүүлэлт, аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

А. УИХ болон Засгийн газрын түвшинд бодлогын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:***УИХ-ын анхааралд толилуулах нь:***

- УБ хотод агаар, ус, хөрсний бохирдол холбогдох стандарт хэмжээнээс хэтэрч гамшгийн түвшинд хүрсэн, тоос шороо, хог хаягдал, автомашины түгжрэл, дуу чимээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх эрсдэл үүсэж, хүн амын төвлөрөл нэмэгдэж байгаа нь МУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан МУ-ын иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх ноцтойгоор зөрчигдөж байгаа тул онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхий сайд, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны даргад:

- Агаар, орчныг бохирдуулж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам, хэрэгжилт, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог цогц тодорхой тусгасан хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар батлуулан, мөрдүүлэх;
- Агаар, орчны бохирдлыг бууруулах асуудлыг тухайлж хариуцах төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, шаардлагатай тохиолдолд тухайн асуудлыг хариуцсан байгууллага байгуулах эсэх асуудлыг судалж шийдвэрлэх;
- Аудитаар илэрсэн зөрчлүүдийг гүнзгийрүүлэн шалгах болон агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг нарийвчлан шалган үнэлж тайлагнах ажлын хэсгийг ТЕЗ-ын дэргэд байгуулан ажиллуулах;
- Агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрүүдэд зарцуулсан хөрөнгө, арга хэмжээг бохирдуулагчийн хэмжилттэй зэрэгцүүлэн жишиж, цаашид авах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байх, энэ талаар олон нийтэд нээлттэй мэдээлэл түгээх;
- Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой ТАХ-ний хэрэгжилтэд YAG-аас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар арга хэмжээ аваагүй холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцож, биелэлтийг хангахад анхаарч ажиллах.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад:

- Агаарын бохирдлыг бүрэн үзүүлэлтээр хэмжих стандарт, индексийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж гаргах;
- Агаарын бохирдол хэмжигч орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр хангах, харуулын станцыг нэмэгдүүлэх, ялангуяа агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсэд хийх хэмжилтийн дүнг хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбон тогтмол тодорхойлж байх талаар зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Агаар, орчны бохирдол үүсгэгч эх үүсвэрийг бууруулах чиглэлээр эрдэмтдийн хийсэн судалгаа, санал, санаачилга болон олон улсад хэрэгжүүлж буй арга хэмжээг судалж, өөрийн оронд хэрэгжих боломжтой аргыг судалгаа, туршилт хийн тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

**Сангийн сайдад:**

- Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрийн хөрөнгөөр зарцуулах хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах;
- Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой гадаадын дамжуулан зээлийг хугацаанд нь төлөөгүй, түүнд хяналт тавьж ажиллаагүй холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцож, биелэлтийг хангахад анхаарч ажиллах.

Б. Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах, багасгах чиглэлээр үе шаттайгаар нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээ***Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:***

Б.1 Агаар, орчны бохирдол өсөж байгааг “**царцаах болон бууруулах**” чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг 2 үе шаттайгаар нэгдсэн бодлого, хяналтын дор зохион байгуулах шаардлагатай байна. Үүнд:

Эхний үе шатанд дараах цаг үеийн арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх:

1. Нийслэлийн агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүс дэх бага насны хүүхэд болон цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд амны хаалт түгээх, сургууль, эмнэлэг, цэцэрлэгт агаар цэвэршүүлэгч төхөөрөмжийг суурилуулах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх ажлыг зохих хяналтын дор зохион байгуулах;
2. Нийслэлийн агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийн дүүрэг, хороодоос авсан сайжруулсан зуух, түлшний хэрэгцээний талаарх судалгаа, зуух, түлшний лабораторийн шинжилгээ болон түлш үйлдвэрлэгчдийн хүчин чадалд тулгуурлан түлш үйлдвэрлэгчдийг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулж, түлшээр хангах арга хэмжээг зохих хяналтын дор хэрэгжүүлж, үр дүнг тооцох, хэрэгцээнд тулгуурлан сайжруулсан зуухны ашиглалтын хугацааг үндэслэн байнга нийлүүлэх арга хэмжээ авч, үр дүнг тооцох;
3. Нийслэлийн иргэдийн гэр, байшингийн дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр хийсэн арга хэмжээ агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөхүйц байгаа тохиолдолд тодорхой хэмжээний үнийн урамшуулал олгох асуудлыг зохион байгуулах;
4. Нийслэлийн гэр хорооллын айл өрхийн цахилгааны хэрэглээнд хөнгөлөлт үзүүлж буй одоогийн цагийн хязгаарыг бодит байдалтай харьцуулан дахин хянаж үзэх;
5. УБ хотод түүхий нүүрсээр ажилладаг айл өрх, байгууллагын халаалтын нам даралтын болон бусад зуухнуудын утааны хорт ялгаралтыг бууруулахын тулд эдийн засгийн үр ашигтай, агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөхүйц, лабораториар туршигдсан, хэрэглэхэд хялбар, хэрэглэгчдэд хүндрэл учруулахгүй шүүлтүүрийг сонгож, ашиглах;
6. Ашиглалтын хугацаа өндөртэй, зохист хэмжээнээс их хорт утаа ялгаруулж байгаа нийтийн тээврийн автобус болон автомашины хэрэглээг хязгаарлаж, хийн түлш, цахилгаан болон бусад эх үүсвэрээр ажилладаг авто тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд түлхүү оролцуулах талаар арга хэмжээг ээлж дараалалтай авах;
7. Агаарыг бохирдуулагч эх үүсвэр бүрээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хөрөнгийн зарцуулалтыг нийслэлийн агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсүүдийн хувьд агаарын бохирдол хэмжилтэд хэрхэн нөлөөлж буйг судлан тодорхой үе шаттайгаар гүйцэтгэлийг тайлагнаж, иргэд олон нийтэд мэдээлж, судалгааны дүнд үндэслэн цаашид авах арга хэмжээг төлөвлөж байх;



- Иргэдийн агаар, орчны бохирдлын хор уршгийн талаарх ойлголт, түүнийг багасгахад иргэн бүрийн оролцоо, үүрэг хариуцлага, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан таниулан сурталчлах үйл ажиллагааг тогтмол явуулж байх;

Хоёр дахь үе шатанд:

- УБ хотын ерөнхий төлөвлөгөө МУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан МУ-ын иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэсэн заалттай нийцэж буй эсэх ялангуяа хот төлөвлөлтөд агаарын солилцооны урсгалыг тооцож хотын гудамж, барилгажилт, ногоон байгууламж гэх мэтийг зөв төлөвлөсөн эсэхийг хянаж үзэх;
- Нийслэлийн хүн ам шалтгаалан агаар, орчны бохирдол ихсэж байгаа тул УБ хотод орж ирэх урсгалыг сааруулах талаар тодорхой арга хэмжээ авах.
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэх, гэр хорооллын дэд бүтцийг бий болгож, төвлөрсөн дулаан хангамжид холбох арга хэмжээ авах;
- Нийслэлийн агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг системтэй, шат дараатай хэрэгжүүлэхээр төлөвлөх;
- УБ хотын төвд байршилтай барилгын материалын болон төмөрлөгийн үйлдвэр, төмөр замын барилгын /цемент гэх мэт/ материал ачиж, буулгах нэгдсэн тайлбайг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах;
- Нийслэлийн гэр хорооллын иргэдийг халаалт болон ахуйн хэрэглээндээ хийн түлш хэрэглэж сургах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Нийслэлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хур тунадасны усыг хуримтлуулан усан сан байгуулах замаар тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах;
- Агаар, орчны бохирдолд олон нийт, иргэдийн үүрэг оролцоог сайжруулах, энэхүү үйл ажиллагааг бүх нийтийн үйлс болгох талаар арга хэмжээ авах;

**Холбогдох байгууллагын санал****Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн санал:**


**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26-61-71, Факс: (976-51) 26-62-86,
И-мэйл: monenv@mail.mn, Вэбсайт: www.mne.mn
2018.09.11 № 03/6324
танай _____ -ны № _____ -т
**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР С.ОЮУНБИЛЭГ ТАНАА**

Танай 01/1812 дугаар албан бичигтэй танилцлаа.
Агаарын бохирдлыг бууруулахаар 2008-2016 онд
хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтэд хийгдэж
буй гүйцэтгэлийн аудитын шалгалтын тайлантай
танилцан саналаа хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА  П.ЦОГТСАЙХАН





Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
 2018 оны 05 сарын 11 өдрийн 37/6324 дугаар
 албан бичгийн хавсралт

Үндэсний аудитын газраас Цэвэр агаарын сан болон 2008-2016 онд агаарын
 бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн
 ажлын үр дүнгийн тайланд өгөх санал

YAG-ын
 тайлбар 1-
 ийг үзнэ үү.

YAG-ын
 тайлбар 2-
 ыг үзнэ үү.

YAG-ын
 тайлбар 3-
 ыг үзнэ үү.

YAG-ын
 тайлбар 4-
 ийг үзнэ үү.

Агуулга	Тодруулга
2015 онд ЗГ-ын 501 тогтоолоор Цэвэр агаарын сангийн Ажлын албыг татан буулгаж, хэрэгжүүлж байсан чиг үүргийг БОНХАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт шилжүүлсэн.	2015 онд ЗГ-ын 501 тогтоолоор Цэвэр агаарын санг татан буулгаж хэрэгжүүлж, байсан чиг үүргийг БОАЖЯ-д шилжүүлсэн. ХБОБНУГ гэж тусгайлан нэр заагаагүй тул хасах.
1.1-д Агаарын бохирдлын тухай хууль...	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль гэж нэрийг засах
1.2-т 2017 оны А/04-А/19 дүгээр тушаал захирамжийн 2.3.3.1, 2.4.3.1 заалт болон Агаарын тухай хуулийн 9.1.8 зөрчилдөж байна.	Агаарын тухай хуулийн 9.1.8-д агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаахгүй байх, БОАЖС, НЗД-ийн хамтарсан 2017 оны А/04-А/19 дүгээр тушаал захирамжийн 2.3.3.1 ба 2.4.3.1-д агаарын чанарыг сайжруулах 3-4 дүгээр бүсэд түүхий нүүрс түлүүлэхгүй байх гэж заасан байдаг. Дээрх 2 заалтууд түүхий нүүрс түлэхгүй шатаахгүй байхаар зааж өгсөн тул хоорондоо зөрчилдөхгүйгээр байна.
1.4-д...Агаарын бохирдлын тухай хууль...	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль гэж нэрийг засах
1.19-д ...Төрийн захиргааны байгууллага нь агаарын чанар, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, хүчиллэг тунадас, давхраат мандлын озон, хүлэмжийн хийн өөрчлөлтөд ...судалгаа, шинжилгээ хийж үнэлгээ өгөх.... заалтыг хэрэгжүүлээгүй байна.	Агаарын чанар, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, хүчиллэг тунадасны өөрчлөлтөд судалгаа, шинжилгээ хийж үнэлгээ өгөх асуудлыг ЦУОШГ, давхраат мандлын озоны Озоны үндэсний алба, хүлэмжийн хийн өөрчлөлтийг Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгж зэрэг БОАЖЯ-ны харьяа байгууллагууд хэрэгжүүлдэг.
2.3-д...4.1.4 болон 4.1.6 заалттай зөрчилдөж энэхүү заалт хэрэгжихгүй байна.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4.1.4 дэх заалтыг үндэслэн тээврийн хэрэгслээс жилд 1 удаа агаар бохирдуулсны төлбөрийг авч байна.



YAG-ын
тайлбар 5-
ыг үзнэ үү.

YAG-ын
тайлбар 6-г
үзнэ үү.

YAG-ын
тайлбар 7-г
үзнэ үү.

		харин 4.1.6 дахь заалтад агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас буюу гэр хороололд хэрэглэж байгаа уламжлалт гэр сууц, байшингийн 100кВт-аас доош хүчин чадалтай зуухнаас агаарын бохирдлын төлбөрийг авахаар хуульчилж өгсөн. Дээрх заалтууд хоорондоо зөрчилдөхгүй.
	2.14-д ...Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө нь хэрэгжиж эхлээгүй байна.	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний 2017 оны хэрэгжилтийг яамд, агентлаг, НЗТГ-аас тайланг авч нэгтгэн БОАЖЯ-ны ХШҮДАГ-аас 70% гүйцэтгэлтэй гэж дүгнэн Засгийн газарт хүргүүлсэн.
	3.2-д Нарийн ширхэгт тоосонцор PM2.5	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 стандартаар "нарийн ширхэглэгт тоосонцор" гэсэн нэр томъёог өөрчлөн "PM2.5 тоосонцор" гэсэн нэршилтэй болгосон.
3	3.5-д 2008-2016 оны мэдээнээс үзвэл...өвлийн саруудад буюу 11 сараас 3 сарын хооронд эрс нэмэгдэж стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хүхрийн давхар исэл 6-20 дахин, азотын давхар исэл 2-13 дахин, нарийн ширхэгт тоосонцор 9-26 дахин өндөр байсан...	Тус саруудын 24 цагийн дундаж агууламжийг стандарт дахь хүлцэх агууламжтай харьцуулж гаргасан юм болов уу. Хэрэв сарын дундаж үзүүлэлтээр тооцвол дараах байдлаар өөрчлөгдөнө. 11-р сараас дараа оны 3-р сарын хооронд эрс нэмэгдэж сарын дундаж агууламж стандартад заасан хүлцэх хэмжээнээс хүхрийн давхар исэл, азотын давхар исэл тус бүр 1.1-2 дахин, PM2.5 тоосонцор 9-5.4 дахин их байна./ЦУОШГ/
4	3.28 ...ЦУОШГ-аас авсан мэдээгээр энэ үзүүлэлт 2012 онд 30% буурахаас 20%-иар буурсан, 2016 онд 70% буурахаас 5% өссөн үзүүлэлттэй байна	Хэдэн оныг суурь он болгож ашигласан, ямар хугацааны мэдээг ашигласан, /хүйтний улирал, жил/ ямар тоосонцрын хэмжээгээр дүгнэсэн зэргийг тодруулах/ЦУОШГ/
5	3.50 ... ДЭМБ-аас гаргасан зөвлөмжтэй харьцуулахад сул тогтоогдсон байгаа тул.....	ДЭМБ-ийн зөвлөмж болгосон тодорхой зорилтот түвшин болон газар нутаг, цаг агаарын онцлог, ашиглагдаж байгаа түлшний шинж чанар зэрэгтэй уялдуулан хөрш 2 улс орон болон бусад улсуудын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулсан. Иймд олон улсын стандартын түвшинд байгаа гэж үзэж байна./ЦУОШГ/

**Агаарын бохирдлыг бууруулах газраас ирүүлсэн санал:****НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗАР**

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011
Утас: 31-48-76, Факс: (976-11) 32-46-32,
E-mail: info@aprd.ub.gov.mn
http://www.aprd.ub.gov.mn

2018.09.10 № 01/465

танай _____-ны № _____-т

Г ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ Г

"Цэвэр агаарын сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлуудын үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дээрх хугацаанд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүн, хэрэгжилтийн талаар холбогдох тайлбарыг хавсралтар хүргүүлж байна.

Хавсралт..4. хуудастай.

ДАРГА



Б.ЦАЦРАЛ

1116128190 м. 5220031

D:\ABBG2018\ALBAN BICBIG\09 SAR\ALBAN BICHIG A5.DOCX



Үндэсний аудитын “Цэвэр агаарын сан болон 2008-2016 онд агаарын
бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн
ажлуудын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх
тайлбар

**YAG-ын
тайлбар 2.1-
ийг үзнэ үү.**

2.27 ААНБ-аас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 4 ААНБ-ийгшүүхэд нэхэмжлэл гаргасан боловч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна. Үүнд:

- “Номгон хайрхан” ХХК-тай байгуулсан “Хягзаарлалтын бүсийн 145 айл өрхөд 79,8 сая төгрөгийн халаалт болон ахуйн хэрэглээний хосолмол цахилгаан зуухыг 2011 оны 10 дугаар сарын 22-ны дотор нийлүүлж, суурилуулах” ажлын 2011 08 дугаар сарын 22-ны АЧА/11/07 дугаартай гэрээ (Тайлангийн хуудас 22)

Тайлбар:

Сүхбаатар дүүргийн шүүхэд 2013.07.03-нд нэхэмжлэл гаргасныг 2013.07.05-ны өдрийн 5379 дүгээр шүүгчийн захирамжаар хариуцагч нь Баянхонгор аймагт харягтай байх тул шүүхийн харьяалал зөрчсөн гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст 2014.09.03-нд гомдол гаргаж захирал Т.Чинбатад эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулсан бөгөөд Өршөөл үзүүлэх тухай 2015.08.11-ний өдрийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр эрүүгийн хэргийг 2016.11.16-ны өдрийн 1317 дугаар прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгосон.

Баянхонгор аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2018.05.09-ны өдрийн 01/280 дугаартай албан бичгээр нэхэмжлэл гаргаж “Номгон хайрхан” ХХК-иас 23.925,000 төгрөг нэхэмжилснийг шүүх хүлээн авч, хэрэг үүсгэсэн бөгөөд 2018.08.14-нд шүүх хурал зарласан боловч захирал Т.Чинбатын бие хүнд өвдсөнөөс шалтгаалж иргэний хэргийг түдгэлзүүлсэн.

- “Их эрин элч” ХХК-тай байгуулсан “Шалны цахилгаан усан халаагуур 370 ширхэгийг 489,9 сая төгрөгөөр 2011 оны 11 дүгээр сард бэлтгэн нийлүүлж, суурилуулах” ажлын 2011 оны 08 дугаар сарын 18-ны ЦА-6789 дугаартай гэрээ (Тайлангийн хуудас 22)

Тайлбар:

Дүүргийн иргэний хэргийн нэгдүгээр шүүхэд 2015.06.23-нд 01/178 дугаартай албан бичгээр нэхэмжлэл гаргаж “Их эрин элч” ХХК-иас 146.976,000 төгрөг нэхэмжилсэн боловч хаягандаа үйл ажиллагаа явуулдаггүй, нүүсэн гэсэн үндэслэлээр 2015.07.31-ний өдрийн 24299 дүгээр захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг буцаасан байна.

Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст 2018.01.26-ны өдрийн 01/45 дугаартай албан бичгээр гомдол гаргаж тус компаны захирал Д.Түмэнхүүд эрүүгийн хэрэг үүсгэсэн боловч хаяг тодорхойгүй шалтгаанаар тус Цагдаагийн хэлтсээс Д.Түмэнхүүг эрэн сурвалжилж байгаа гэсэн тайлбарыг мөрдөгч н.Баярбилэг өгсөн.



- “Ворм энерги” ХХК-тай байгуулсан “Үртсэн шахмал түлшний тоног төхөөрөмжийг 152,9 сая төгрөгөөр 2013 оны 02 дугаар сарын 15-нд, 1,300 тн үртсэн шахмал түлшийг 2014 оны 02 дугаар сарын 28-нд нийлүүлэх” ажлын 2012 оны 12 дугаар сарын 25-ны АЧА/12/02/03Б дугаартай гэрээ (Тайлангийн хуудас 22)

Тайлбар:

Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст 2017.09.17-ны өдөр захирал П.Бүүвэйбаатарт эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар гомдол гаргасан бөгөөд 2017.12.18-ны өдрийн 525 дугаар прокурорын тогтоолоор гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хэрэг бүртгэлтийн хэргийн хаасан байна.

Баянзүрх дүүргийн шүүхэд 2018.02.07-нд 01/85 дугаартай албан бичгээр нэхэмжлэл гаргаж, “Ворм энерги” ХХК-иас 171.230,561 төгрөгийг нэхэмжилсэн боловч 2018.03.29-ны өдрийн 101/ШШ2018/01114 дугаартай шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд 2018.05.02-ны өдөр 01/260 дугаартай албан бичгээр давж заалдах гомдол гаргасныг 2018.06.06-ны өдрийн 1311 дугаартай магадлалаар “Ворм энерги” ХХК-иас 136.984.449 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн.

Дээрх магадлалыг “Ворм энерги” ХХК үл зөвшөөрч 2018.07.10-нд Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасан бөгөөд шүүх хурал зарлагдаагүй байна.

- “Тара” ХХК-тай байгуулсан “Үртсэн шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг 200,0 сая төгрөгөөр бэлтгэж нийлүүлж, угсарч суурилуулах, 1,330 тн үртсэн шахмал түлш нийлүүлэх” ажлын 2012 оны 10 дугаар сарын 08-ны АЧА/12/02/03 А дугаартай гэрээ (Тайлангийн хуудас 22)

Тайлбар:

Сүхбаатар дүүргийн шүүхэд 2017.09.27-нд 01/351 дугаартай албан бичгээр нэхэмжлэл гаргаж, “Тара” ХХК-иас 214.555,625 төгрөгийг нэхэмжилсэн боловч 2017.12.15-ны өдрийн 181/ШШ2017/03227 дугаартай шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд 2018.01.24-ны өдөр 01/40 дугаартай албан бичгээр давж заалдах гомдол гаргасныг 2018.03.05-ны өдрийн 621 дугаартай магадлалаар “Тара” ХХК-иас 168.244.500 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн.

Дээрх магадлалыг “Тара” ХХК үл зөвшөөрч 2018.03.30-нд Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасныг 2018.06.26-ны өдрийн 001/хт2018/010886 дугаартай тогтоолоор анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан бөгөөд Сүхбаатар дүүргийн шүүх хуралдаагүй байна

YAG-ын тайлбар
2.2-ыг үзнэ үү.

2.28 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас ТАХ-г хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаагүй, газар чөлөөлөлтийн асуудал шийдэгдээгүй зэрэг шалтгааны улмаас зарим ТАХ бүрэн болон дутуу хэрэгжээгүй байна. Тухайлбал,

Нийслэлийн төсөвийн хөрөнгөөр 2010-2015 онуудад хэрэгжсэн ажлууд:



- “Биозтанол шатахуун “Эко-92”-ын үйлдвэрлэлийг өргөжүүлэх”

- “Автотээврийн хэрэгслийн шатахууны чанарыг сайжруулагч, утаа бууруулагч биодизель түлшний үйлдвэрлэлийг өргөжүүлэх”

- “Эко болон биошатахуун түлшний үйлдвэрлэлийг дэмжих” (Тайлангийн хуудас 23)

Тайлбар:

Төсөл хэрэгжүүлэх үндэслэл: Автотээврийн хэрэгсэл нь агаар бохирдуулагч томоохон эх үүсвэрийн нэг бөгөөд утаа их ялгаруулж байгаа нийтийн тээврийн хэрэгсэл болон замын хөдөлгөөнд оролцож буй автотээврийн хэрэгслээс гарах бохирдлын хэмжээг бууруулах талаар арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлага үүссэж байсан.

Төсөл арга хэмжээний ач холбогдол: Эко болон биозтанол түлшний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Оргил Ойл” ХХК, Эн би эф” ХХК-иудтай түлшний этанол буюу Эко-92 шатахууны түүхий эд нийлүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байсан.

Энэхүү ажлын хүрээнд Петровис”, “Оргил-Ойл” компанийн инженер, химичдийн үйлдвэрлэсэн Спиртийн шаарыг боловсруулан этанол гарган авч түүнийгээ А-80 бензинтэй хольж, “Эко-92” бензинийг үйлдвэрлэдэг. “Эко-92” бензиний агаарт ялгарах хорт утааны хэмжээ 30-40 хувь бага байдаг учраас түүхий нефтээс гаргаж авдаг бусад шатахуунаас давуу талтай төсөл болсон.

- “Шалны цахилгаан усан халаагуурыг гэр хорооллын айл өрхөд нэвтрүүлэх” (Тайлангийн хуудас 23)

Тайлбар:

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсийн 393 өрхийг шинэ технологийн шал, хана, эрчим хүчний хэмнэлттэй халаалтаар халаахаар тендер зарлан компаниудтай гэрээ байгуулан ажилласан.

Гэрээний дагуу “Тот ком сервис” ХХК нь шалны цахилгаан усан халаагуурыг гэр хорооллын 65 айл өрхөд нэвтрүүлсэн бөгөөд энэхүү ажил нь иргэдэд олон нийтэд нийцсэн ажил болсон.

2.32 НАЧА бодит практикт нэвтрүүлэх эсэх нь тодорхойгүй дараах ажлуудыг хийлгэж, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна. Тухайлбал,

- МУИС-ийн Цөмийн судалгааны төвийн 2011 онд гүйцэтгэсэн 15,0 төгрөгийн төсөвт өртөгтэй “Дулааны цахилгаан станцуудын үнсэн сангийн найрлага, агуулгыг тодорхойлох” судалгаа (Тайлангийн хуудас 24)

Тайлбар:

Төсөл хэрэгжүүлэх үндэслэл: Улаанбаатар хотын хувьд хүнд болон химийн үйлдвэрийн салбар төдийлөн хөгжөөгүй боловч, хүн ам төвлөрөн суурьшсан томоохон хотуудад ажиллаж буй ДЦС-уудын хаягдал жилээс жилд их хэмжээгээр нэмэгдэж, байгаль орчин болон хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихсэж байгаа нь

**YAG-ын
тайлбар 2.3-
ыг үзнэ үү.**



энэ талын судалгааг мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдаар хийлгүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байсан.

Төслийн ач холбогдол: Улаанбаатар хотын ДЦС-3,4 станцуудад нүүрсний шаталтаас хаягдсан үнсэн сангийн дээжид цацраг идэвхт изотопуудын хэмжээг тогтоосноор хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагуудын барилга байгууламжид дүүргэлтийн блок болон бусад барилгын материалд ашиглаж байгаа үнсээс оршин суугчдын цацрагийн бохирдолд өртөж байгаа хэмжээг ямар түвшинд байгаа, энэ нь Монгол улсад мөрдөж стандартын хэмжээтэй харьцуулахад ямар байгааг тодорхой болгосон төдийгүй хотын иргэдийн цацрагаас үүдэлтэй бохирдлоос урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлснээр өндөр ач холбогдолтой судалгааны ажил болсон. Үүнээс гадна Японы ОУ-ын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн ажилд суурь судалгаа болон ашиглагдаж байна.

- ШУТИС-ын Дулаан техник үйлдвэрийн экологийн хүрээлэнгийн 2011 онд гүйцэтгэсэн 30 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гидродинамикийн насос ашиглан цахилгаан эрчим хүчийг хамгийн бага хэрэглэж, үйлдвэр, олон нийтийн үйлчилгээний барилгыг дулаанаар хангах” судалгаа (Тайлангийн хуудас 24)

Тайлбар:

Төсөл хэрэгжүүлэх үндэслэл: Улаанбаатар хотын хүн амын өсөлттэй уялдан олширч байгаа олон нийтийн зориулалттай үйлчилгээний барилга байгууламж, ялангуяа төвийн шугамаас алслагдсан байгууламжийг халаахад байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай халаалтын шийдлийг турших.

Төслийн ач холбогдол: Энэхүү ажил нь суурь судалгааны ажил бөгөөд энэ чиглэлээр төсөл хэрэгжүүлэх сонирхолтой хувь хүн байгууллагад онолын үндэстэй практик ач холбогдолтой нэгдсэн ойлголт өгч энэ нь хотын захиргааны цаашид баримтлах олон эргэлзээтэй шийдлүүдийн нэг чиглэлийг тодорхой болгож өгснөөрөө ач холбогдолтой судалгааны ажил болсон.

Иймд дээрх хэрэгжүүлсэн ажлуудыг хийлгэж төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна гэсэнтэй санал нийлэхгүй байна.

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар

**Ирүүлсэн саналд өгөх тайлбар*****Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар*****ҮАГ-ын тайлбар 1**

Ирүүлсэн 1 дэх саналыг хүлээн авч тайлангийн ерөнхий мэдээлэлд тусгалаа.

ҮАГ-ын тайлбар 2

Тайлангийн 1.1-д дурдсан Агаарын тухай хуульд агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс шатаахгүй байх тухай заасан байхад БОАЖС, НЗД-ийн хамтарсан тушаал захирамжид агаарын чанарыг сайжруулах бүсийн тухайлсан бүсэд түүхий нүүрс шатаахгүй байхыг зааж өгсөн учир саналыг хүлээн авах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 3

Тайлангийн 1.19-д дурдсан БОАЖЯ Агаарын тухай хуульд заасан агаар бохирдуулах эх үүсвэрүүдэд хийх хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 4

Тайлангийн 2.3-т Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, гэр хорооллын айл өрх агаарын бохирдлын төлбөр төлөгч байхаар хуульчилсан боловч тэдгээрээс хэрхэн, хэдий хэмжээний төлбөр авах талаар заалт байхгүй, мөн хуулийн нэр томъёоны тодорхойлолтод "авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл" гэж дизель түлш, шатахуунаар ажилладаг бүх төрлийн автомашин ... гэж хос тэжээлт автомашиныг оруулаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 5

Тайлангийн 2.14-д ирүүлсэн саналыг хүлээн авч тусгалаа.

ҮАГ-ын тайлбар 6

Тайлангийн 3.6-д агаарын чанарын 24 цагийн дундаж агууламжийг стандарт дах хүлцэх агууламжтай харьцуулж гаргасан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 7

Тайлангийн 3.59-д нарийн ширхэглэгт тоосонцрын хүлцэх агууламжийн хэмжээг заасан Монгол улсын агаарын чанарын стандартын хэмжээ нь ДЭМБ-ын зөвлөсөн хэмжээ болон зарим улсын агаарын чанарын стандартад заасан хэмжээнээс сул байгаа талаар дурдсан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар**ҮАГ-ын тайлбар 2.1**

Тайлангийн 2.27-д ирүүлсэн тайлбарыг хүлээн авч тайланд тусгалаа.

ҮАГ-ын тайлбар 2.2

Тайлангийн 2.28-д ирүүлсэн саналыг хүлээн авлаа.

ҮАГ-ын тайлбар 2.3

Тайлангийн 2.32-т дурдсан судалгаа практикт нэвтэрч үр дүнгээ өгсөн нь тодорхойгүй байгаа тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй байна.



Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал:



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цэвэр агаарын сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийсэн ажлын үр дүн"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хороо, Өргөдлийн Байнгын хороо, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны гуравдугаар улиралд багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /Н.Цэрэнбат/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Батболд/, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга /У.Хүрэлсүх/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /Л.Одгэрэл/-т даалгасугай.
5. Аудитын тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор холбогдох нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Д.Гандолгор/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР




Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaal\2018\1019GAG3.Docx

0213-1



Монгол Улсын Ерөнхий аудиторын
2018 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/189
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

/тэрбум.төг/				
№	Хариуцагч байгууллага	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
1	Зам, тээврийн хөгжлийн яам	Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг олгосон, хэрэгжиж дуусаагүй	-	3.0
	Нийт дүн			3.0


Хавсралтууд:

Хавсралт 1

Улсын төсвийн урсгал зардлаас зарцуулсан хөрөнгийн судалгаа

/сая төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Үнийн дүн
А. ЦЭВЭР АГААРЫН САНГААС:		
1	Сайжруулсан зуухны үнийн зөрүүнд санхүүжилт олгох, зуух борлуулах зорилгоор гэр цэгүүдийн үйл ажиллагааны зардал	32,246.2
2	Нам даралтын зуухыг татан буулгаж, төвлөрсөн дулаанд холбох	13,129.9
3	Боловсруулсан түлшний үнийн зөрүүд санхүүжилт олгох, түлш тээвэрлэх тээврийн зардал, түлшний бөөний агуулахын зардал	6,443.6
4	Хог, үнс тээвэрлэх автомашин нийлүүлэх	4,402.1
5	Нийтийн тээврийн автобусанд дизель болон хийн төхөөрөмж суурилуулах	3,380.0
6	Цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх, фидерийн ачааллыг хөнгөлөх, шугам сүлжээг өргөтгөх	3,298.7
7	Хөрсний бохирдлыг бууруулах, шивтрийн хийг багасгахад	3,048.8
8	Эрчим хүчний хэмнэлттэй гэрийн иж бүрэн дулаалга	3,013.0
9	Туул, Сэлбэ голын эхийг сэргээх, урсцыг нэмэгдүүлэх	2,297.0
10	Нүүрсний хийгээр халаалтын зуухыг хангаж, агаарын бохирдлыг бууруулах	1,965.0
11	Автомашин хийгээр цэнэглэх станц байгуулах	1,890.0
12	Авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтын хэмжээг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах	1,773.6
13	Цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэл	1,500.0
14	Шингэрүүлсэн хийн агуулахын хүчин чадлыг нэмэгдүүлэх	1,494.9
15	Дуобус угсрах, нэвтрүүлэх	1,499.9
16	Нийслэлийн гэр хорооллын зарим өрхүүдэд хийн зуух, плитк, түлш нийлүүлэх	1,465.2
17	Айл өрхийг хийн хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор хийн плиткийн иж бүрдлийг олгох	1,147.9
18	Агаарын чанарыг хянах лабораторийг багаж тоног, төхөөрөмжөөр хангах, холбогдох бусад арга хэмжээ	1,008.2
19	Аймгийн төвүүдэд АББ арга хэмжээ хэрэгжүүлэх /Дархан-Уул, Өвөрхангай, Орхон, Ховд, Баянхонгор, Хөвсгөл, Дорнод, Сүхбаатар, Дундговь аймаг/	706.0
20	Эзэн хариуцагч тодорхойгүй барилгын болон гэр хорооллын хур хог цэвэрлэх	633.9
21	СХД, ЧД 110/35/10 кв-ын телевиз, "Баянгол" дэд станцаас 10 кв-ын шинэ гаргалга фидер гаргаж, фидерийн ачаалал хөнгөлөх ажил	584.4
22	Нийслэлийн зарим өрхөд цахилгаан болон шалны халаагуур нийлүүлэх	1,060.2
23	Ойжуулалт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	489.7
24	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл тооллогын зардалд	341.2
25	Агаарын чанарын ухаалаг хяналтыг нэвтрүүлэх	327.5
26	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдсэн судалгааны зардалд	384.3
27	АББ, дулаан алдагдлыг багасгасан, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн худалдан борлуулдаг иргэн, ААН-д урамшуулал олгох	257.7
28	УБ хотын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа, дүгнэлт, АББ түүнийг ашиглах мастер төлөвлөгөө боловсруулах	17.9
29	УБ хотын агаарын бохирдлын эх үүсвэрүүдийн бохирдолд оруулж буй хувийг тодорхойлж, авсан арга хэмжээ, үр дүнд мониторинг хийх	50.0
30	АББ, орчны доройтолтой тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан бүсийн сургалт хийх, олон улсын хурал зохион байгуулах, ном хэвлэх	88.6
31	Мэдээлэл, сурталчилгаа	2,576.7
32	ЦАС-ийн дотоод зардал	932.1
	ЦАС нийт дүн	93,454.2
Б. БОАЖЯ-НЫ УРСГАЛ ЗАРДЛААС		4,263.7
УРСГАЛ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН		97,717.9


Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас зарцуулсан хөрөнгийн судалгаа

/сая төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Үнийн дүн
1	"ДЦС-2"-ийг түшиглэн 210 мянган тонн хагас коксон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах	14,193.8
2	"ДЦС-2" ХК-н хагас коксон түлш хийхэд шаардагдах Шингэн шилний үйлдвэр байгуулах	1,200.0
3	"ДЦС-4" ХК-ийн уур, усны дулаан солилцуулагч бүхий дулааны дэд станц барих /Улаанбаатар/ барилга угсралтын ажил	10,415.0
4	"ДЦС-4"-д зуухны гаргах утаа, үнсийг үлэмж хэмжээгээр бууруулах технологи нэвтрүүлэх /Улаанбаатар/ барилга угсралтын ажил	5,247.2
5	"ДЦС-4"-д зуухнуудын үнс, утааны хийн ялгаруулалтыг бууруулах технологи нэвтрүүлэх /Улаанбаатар/ барилга угсралтын ажил	4,726.3
6	ДЦС-4 сүлжээний өргөтгөлийн 1-р насосуудыг "0" түвшинд шилжүүлэх /Улаанбаатар/ барилга угсралтын ажил	1,425.0
7	60-80 м2 хүртэлх талбай халаах усан халаалттай сайжруулсан зуухыг худалдан авч нийлүүлэх	12,800.3
8	50 м2 хүртэлх талбай халаах ердийн сайжруулсан зуухыг худалдан авч нийлүүлэх	2,321.8
9	Бага дунд чадлын ус халаалтын зуухнуудын техникийн шинэчлэл	1,091.0
10	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр /УБ, ЧД/	249.1
11	Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх цахилгааны шугамын ачааллыг хөнгөвчлөх угсралтын ажил /Багц-2, ХУД, БЗД 110/35/10 кв-ын Зайсан дэд станцаас 10 кв-ын шинэ гаргалга фидер гаргаж, Зуслан фидерийн ачаалал хөнгөлөх ажил	285.9
12	Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх цахилгааны шугамын ачаалал хөнгөвчлөх ажлын СХД, ЧД, СБД 110/35/10 кв-ын дэд станцаас 10 кв-ын шинэ гаргалга фидер гаргаж, фидерийн ачаалал хөнгөлөх ажил	604.9
13	Нам даралтын зуухнуудын технологийн шинэчлэлт /Налайхын гордокийн зуух	52.9
14	ЧД-ийн 61-р сургууль, СБД-ийн 58-р сургуулийн зуух	56.0
15	БЗД-ийн УС-15 зууханд нүүрс хийжүүлж дулаан үйлдвэрлэх	200.0
16	Их чадлын трансформаторын засварын цех байгуулах Харш ХХК	30.8
Нийт дүн		54,895.6

Хавсралт 3

Нийслэлийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн судалгаа

/сая төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Үнийн дүн
1	Үртсэн шахмал түлшний үйлдвэрлэлийг өргөжүүлэх	149.1
2	Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, бохирдлын хор уршгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах	5.9
3	Үртсэн түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэр шинээр байгуулах	1,552.8
4	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор одоо ажиллаж байгаа үртсэн түлшний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэн түлшний нөөц бий болгох	80.0
5	Нийслэлийн төвийн дүүргийн нам даралтын халаалтын зууханд техник технологийн шинэчлэлт хийх	807.6
6	ХЗАЭГ-ын харьяа НДХЗ-ны урсгал засварын зардал	232.7
7	Газрын гүний дулааныг дулаан хангамжид нэвтрүүлэх	100.0
8	Авто тээврийн хэрэгсэлд шингэрүүлсэн нефтийн хийн тоног төхөөрөмж суурилуулах	189.9
9	Давхар шаталттай гэрийн зуухыг нэвтрүүлэх	60.1
10	Биоэтонол шатахуун "ЭКО 92"-ын үйлдвэрлэлийг өргөжүүлэх	100.0
11	Авто тээврийн хэрэгслийн шатахууны чанарыг сайжруулагч, утаа бууруулагч биодизель түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	40.0
12	Шинэ төрлийн утаа багатай гэрийн зуухны туршилт хийх	5.0
13	Шалны цахилгаан усан халаагуурыг гэр хорооллын айл өрхөд нэвтрүүлэх төсөл	147.0
14	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур болон бусад жижиг төслүүдийг туршин нэвтрүүлэх	10.0



15	Монгол улсын шинжлэх ухааны академи, Оросын шинжлэх ухааны академийн Сибирийн салбартай хамтран хэрэгжүүлэх УБ хотын агаарын бохирдлын загварчлал төсөл	30.0
16	Агаарын бохирдлыг хэмжигч суурин харуулуудын сэлбэг, урвалж бодис, техник тоног төхөөрөмж	18.6
17	Боловсруулсан түлш нөөцлөх агуулах түрээслэх	15.8
18	БЗД-ийн УС-15, СБД-ийн 58, ЧД-ийн 61-р сургуулиудын халаалтын зуухны шинэчлэлтийн ажил	288.6
19	Авто тээврийн хэрэгслийн түлшний чанарыг сайжруулж, хэмнэлтийг дээшлүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	66.0
20	Эко болон био шатахуун түлшний үйлдвэрлэлийг дэмжих	65.0
21	Дулааны цахилгаан станцуудын үнсэн сангийн найрлага, агууламжийг тодорхойлох судалгааны ажил	15.0
22	Бага оврын нам даралтын зуухны технологийн шинэчлэлтийг дэмжих	184.0
23	Шалны цахилгаан халаагуур	195.0
24	Хананы цахилгаан халаагуур	59.9
25	Радиаторт цахилгаан халаагуур	56.5
26	Таазны цахилгаан халаагуур	47.5
27	Цахилгаан зуух	23.9
28	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /Дулаан баригч/	100.0
29	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /Авто тээврийн хэрэгслийн шатахууны чанар дээшлүүлэх, утаа бууруулах бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгсэлд суурилуулах/	293.9
30	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /Шалны цахилгаан халаагуур/	130.0
31	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /Утаа шүүгч/	95.0
32	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /УБ агаарын бохирдлын загварчлал/	30.0
33	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /СЭХ ашиглан хороо өрхийн эмнэлэг цагдаагийн барилгын нэгдсэн барилгын халаалт болон ахуйн хэрэглээний халуун ус бэлтгэх тоног төхөөрөмж ажиллуулах/	97.5
34	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /СЭХ ашиглан гэр хорооллын айл өрхийн халаалт болон ахуйн хэрэглээний халуун ус бэлтгэх тоног төхөөрөмж ажиллуулах/	99.4
35	Агаарын бохирдлыг бууруулах /СЭХ ашиглан гэр хор-ын айл өрх болон нэгдсэн барилгын халаалтын асуудлыг шийдвэрлэх/	76.3
36	Агаарын бохирдлыг бууруулах /Хананы цахилгаан халаагуур/	79.7
37	Агаарын бохирдлыг бууруулах /Зөвлөх үйлчилгээ/	30.0
38	Агаарын бохирдлыг бууруулах /Дулаан баригч/	50.0
39	Агаарын бохирдлыг бууруулах /Шалны цахилгаан халаагуур/	102.0
40	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /Агаарын чанарт хяналт – шинжилгээ хийх тоног төхөөрөмж худалдан авах/	146.7
41	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /Үртсэн шахмал түлшний шинэ үйлдвэрлэлийг дэмжих, түлшний нөөц бий болгох/	152.9
42	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах /Үртсэн шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулж, ажиллуулах, бүтээгдэхүүн нийлүүлэх/	190.0
43	Үртсэн шахмал түлшний үйлдвэрийн түүхий эдийн нөөц нэмэгдүүлэхэд шаардагдах техникийн шинэчлэлт	833.4
44	Нийслэлийн агаарын бохирдлыг хэмжигч 4 суурин автомат харуулын тоног төхөөрөмжийг шинэчлэх	500.0
45	Түлш хадгалах агуулах /СХД, БГД/	500.2
46	Хороодын байрыг сэргээгдэх эрчим хүчээр хангах	819.8
47	Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрүүдэд хэмжилт хийх тоног төхөөрөмжүүдийг суурилуулах зориулалтын автомашин /2ш/	162.0
48	Агаарын бохирдлын хэмжилтийн суурин харуулын тоосонцор хэмжих багаж	365.4
Нийт дүн		9,424.6



Монгол Улсыг хөгжүүлэх сангаас зарцуулсан хөрөнгийн судалгаа

/сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Үнийн дүн
1	Үртсэн шахмал түлшний үйлдвэрийг өргөжүүлэх /Сэлэнгэ аймаг Мандал сум Түнхэл хороо/	163.8
2	Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байршилтай төрийн болон орон нутгийн өмчлөлийн байгууллагуудын халаалтын зуухнуудын технологийн шинэчлэлт	435.1
3	Боловсруулсан нүүрсний экологийн цэвэр түлшний үйлдвэрлэлийг дэмжих	186.0
4	Нүүрсний дутуу шаталтаас үүсэх агаарын бохирдлыг бууруулах дэвшилтэт технологийн нэвтрүүлэх	15.7
5	Авто тээврийн хэрэгслээс ялгарах утааны бохирдлыг бууруулах арга хэмжээнд	500.0
6	Нийслэлийн Агаарын чанарын албаны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	345.0
7	Их чадлын трансформаторын засварын цех байгуулах	416.9
Нийт дүн		2,062.5

Хавсралт 5

Гадаадын зээл, тусламжаас зарцуулсан хөрөнгийн судалгаа

/сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Үнийн дүн
1	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах сүлжээ байгуулах төсөл	1.6 сая евро
2	Гэр хорооллын ядуу өрхүүдийн агаарын бохирдлыг бууруулах төсөл	2.0 сая ам.доллар
3	Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл 1, 2	480.0 сая иен
4	Улаанбаатар цэвэр агаар бодлогын зөвлөгөө ба техник туслалцааны төсөл	0.5 сая ам.доллар
5	Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл	99.8 сая ам.доллар
6	Улаанбаатар цэвэр агаар төсөл	7.4 ЗТЭ
7	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр /3 үе шаттай/	42.0 сая ам.доллар, 50.0 сая евро
8	Нүүрснээс цэвэр түлш гаргаж авах замаар гэр хорооллыг дулаанаар хангах, эрчим хүч үйлдвэрлэх техник туслалцааны төсөл	0.4 сая ам.доллар
9	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах сүлжээ байгуулах төсөл	1.6 сая евро

Хавсралт 6


Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Илэрсэн зөрчил		Зөрчил гаргасан албан тушаалтан	Аудитаар авсан арга хэмжээ
	Огноо	Утга		
Тус аудитаар илэрсэн зөрчилтэй холбоотой асуудлаар:				
1	2011	Нийслэлийн нийтийн их багтаамжийн 400 автобусыг дизель-хийн түлшний хосолмол хэрэглээнд шилжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажлын гүйцэтгэгч “Туртелком” ХХК нь 3.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан боловч 150 автобусанд тоног төхөөрөмж суурилуулаагүй, ажлын гүйцэтгэл дутуу.	ЗТБХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, ЦАС-ийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх, “Туртелком” ХХК-ний ерөнхий захирал С.Мөнхжаргал	Дутуу хийгдсэн ажлыг гүйцээх, цаашид зөрчил гаргахгүй байх талаар ЗТХС-д албан шаардлага өгч, мөн дээрх асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулахаар шийдвэрлэсэн
	2012	Гэрийн иж бүрдэл ханган нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Урал инженер” ХХК-д гэрээний үнийн дүнгээс 22.7 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон.	НЗД-ын орлогч Д.Ганболд, ЦАС-ийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх, “Урал инженер” ХХК захирал О.Алтанцэцэг	Илэрсэн зөрчилтэй асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулахаар шийдвэрлэсэн
	2012	Гэр хорооллын нүхэн жорлонг ариутгаж, шивтрийн хийг бууруулах үйлчилгээтэй бэлдмэл нийлүүлэгч “Ирвэс интертрейд” ХХК-тай хууль зөрчиж 3.0 тэрбум төгрөгөөр ажил гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан, чанаргүй бэлдмэл хэрэглэсэн.	УБ хотын ерөнхий менежер бөгөөд ЗАА-ны дарга Ч.Бат-Эрдэнэ, ЦАС-ийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх “Ирвэс интертрейд” ХХК гүйцэтгэх захирал Л.Төгсжаргал	Илэрсэн зөрчилтэй асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулахаар шийдвэрлэсэн
2	2012-2016	Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой гадаадын дамжуулан зээлийг хугацаанд нь төлөөгүй, түүнд хяналт тавьж ажиллаагүй байна.	БХБЯ-ны ТНБД С.Магнайсүрэн, Санхүүгийн хэлтсийн дарга Д.Баярсайхан	Эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож, биелэлтийг хангахад анхаарч ажиллах тухай зөвлөмжийг Сангийн сайдад өгөхөөр шийдвэрлэсэн.
ҮАГ-аас өгч байсан зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүйтэй холбоотой асуудлаар:				
3	2010	ҮАГ-аас “Утаа бага гаргах түлш боловсруулах зориулалтаар 2009-2010 онд төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-нд 2010 онд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж биелэгдээгүй.	ЭБЭХС Д.Зоригт НЗД дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр	Аудитаар илэрсэн зөрчлийг гүнзгийрүүлэн шалгах болон АББ чиглэлээр хэрэгжүүлсэн
	2014	ҮАГ-аас “ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн 210 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төслийн зарцуулалтын байдалд 2014 онд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж биелэгдээгүй.	ЭХС М.Сономпил, УУС Д.Ганхуяг	



№	Илэрсэн зөрчил		Зөрчил гаргасан албан тушаалтан	Аудитаар авсан арга хэмжээ
	Огноо	Утга		
	2014	ҮАГ-аас “ЦАС-ийн 2011-2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт”-д 2014 онд хийсэн аудитаар “Нийслэлийн нийтийн тээврийн их багтаамжийн 400 автобусыг дизель-хийн түлшний хосолмол хэрэглээнд шилжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулах” ажлын хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналт тавьж ажиллах талаар өгсөн албан шаардлага биелэгдээгүй .	ЗТС А.Гансүх Нийслэлийн тээврийн газрын дарга Ч.Энхбат ЦАС-ийн гүйцэтгэх захирал Д.Баасан “Туртелком” ХХК ерөнхий захирал С.Мөнхжаргал	ТАХ-ний үр дүнг нарийвчлан шалган үнэлж тайлагнах ажлын хэсгийг ТЕЗ нар байгуулан ажиллуулах талаар Ерөнхий сайдад зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.
	2014	ҮАГ-аас “ЦАС-ийн 2011-2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт”-д 2014 онд хийсэн аудитаар “Авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтын хэмжээг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах” ажлын хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналт тавьж ажиллах талаар өгсөн албан шаардлага биелэгдээгүй .	БОНХСайд С.Оюун, БОНХЯ-ны ТНБД Ж.Батболд, ЦАС-ийн гүйцэтгэх захирал Д.Баасан, “Хаш техник” ХХК-ийн захирал Д.Бадрах	

